

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶᠢᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ
ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА**



Улаанбаатар хот
2022 он

Олон нийтэд зориулав.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА**

(2022.03.15 - 2022.07.06)

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

АГУУЛГА

	Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганыг нээж УИХ-ын дарга Г.Занданшатарын хэлсэн үг	6
НЭГ.	УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	
	1.1. Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны нэгдсэн тойм.....	20
ХОЁР.	УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН БОЛОН ДЭД ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
	2.1. Байнгын хороодын үйл ажиллагааны талаар	23
	2.2. Улсын Их Хурлын Байнгын болон дэд хороодын бүрэлдэхүүн.....	25
ГУРАВ.	УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	
	3.1. Тодорхой асуудлаар шалган судлах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шалгалт хийсэн талаар	71
	3.2. Улсын Их Хурлын гишүүний асуулга, асуултын талаар	77
	3.3. Монгол Улсын Ерөнхий сайдын нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийсэн талаар	79
ДӨРӨВ.	УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
	4.1. Мэдээлэл, сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаа	89
	4.2. Улсын Их Хуралд иргэд, сонгогчдоос ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	91
	4.3. Мэдээллийн технологийн болон хуралдааны цахим системийн үйлчилгээ	93
	4.4. Судалгаа шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа	95
	4.5. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа	97
ТАВ.	ХАВСРАЛТУУД	
	Хавсралт 1. Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар баталсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын жагсаалт..	104
	Хавсралт 2. Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар баталсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга	117
1.БИЕ ДААСАН ХУУЛЬ		
	<i>1.1.Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомслоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн танилцуулга /2022.04.15/.....</i>	<i>117</i>
	<i>1.2.Эрдэнэсийн сангийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн танилцуулга /2022.04.22/.....</i>	<i>119</i>

1.3.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн танилцуулга /2022.04.29/...	120
1.4.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хууль, “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга /2022.05.27/.....	124
1.5.Далай ашиглах тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн танилцуулга /2022.06.03/.....	128
1.6.Хөрөнгийн үнэлгээний тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн танилцуулга /2022.06.17/.....	129
1.7.Зөвшөөрлийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн танилцуулга /2022.06.17/.....	132
1.8.Үндэсний их баяр наадмын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн танилцуулга /2022.06.28/.....	136
1.9.Хууль зүйн туслалцааны тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн танилцуулга /2022.07.01/.....	138
1.10.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн танилцуулга /2022.07.05/.....	140
1.11.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн танилцуулга /2022.07.06/....	141

2.НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

2.1.Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга /2022.04.15/.....	142
2.2.Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга /2022.04.22/.....	143
2.3.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга /2022.04.22/.....	144
2.4.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга /2022.04.29/.....	145
2.5.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн зарим хуулийн танилцуулга /2022.04.29/.....	146
2.6.Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн протоколд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн танилцуулга /2022.06.03/.....	150
2.7.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга /2022.06.03/.....	153
2.8.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга /2022.06.03/.....	154

2.9.Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга /2022.06.03/.....	155
2.10.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга /2022.06.10/.....	156
2.11.Донорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга /2022.06.17/.....	157
2.12.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга /2022.06.17/.....	158
2.13.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн танилцуулга /2022.07.01/.....	159
2.14.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн танилцуулга /2022.07.05/....	160
2.15.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга /2022.07.05/.....	161

3.ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

3.1.Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн танилцуулга (Ази, номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай) /2022.04.28/...	164
3.2.Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн танилцуулга (Олон улсын автоматэвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн багийн ажлын тухай Европын хэлэлцээр) /2022.05.04/.....	165
3.3.Конвенцод оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн танилцуулга (Олон улсын хөдөлгөөнт хиймэл дагуулын байгууллагын 1976 оны конвенц) /2022.07.05/.....	166

4.УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

4.1.“Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга /2022.04.07, дугаар 10/.....	167
4.2.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга (Монгол Улсын Хөгжлийн банкаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах үүрэг бүхий) /2022.04.15, дугаар 14/.....	168
4.3.“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга /2022.04.29, дугаар 16/.....	169
4.4.“Хүүхдийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга /2022.04.29, дугаар 17/.....	170
4.5.“Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга /2022.05.05, дугаар 19/.....	170

4.6. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга (Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсад эмийн хяналт шалгалтыг сайжруулах, хянан шалгах үүрэг бүхий) /2022.05.19, дугаар 21/.....	171
4.7. “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга /2022.05.26, дугаар 23/.....	172
4.8. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга (Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох үүрэг бүхий) /2022.06.10, дугаар 31/.....	173
4.9. “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга /2022.06.16, дугаар 34/.....	174
4.10. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга /2022.06.17, дугаар 36/.....	175
4.11. “Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ заагийг шинэчлэн тогтоож, зарим орчныг олон нийтэд нээлттэй болгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга /2022.06.17, дугаар 37/.....	176
4.12. “Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга /2022.07.06, дугаар 47/.....	177
4.13. “Түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга (Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаарх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий) /2022.07.06, дугаар 48/.....	178
4.14. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга /2022.07.06, дугаар 49/.....	179
4.15. “Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга /2022.07.06, дугаар 52/.....	180

Хавсралт 4.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганыг хааж УИХ-ын дарга Г.Занданшатарын хэлсэн үг	182
Товчилсон үгийн жагсаалт	186

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫГ НЭЭЖ УИХ-ЫН ДАРГА Г. ЗАНДАНШАТАРЫН ХЭЛСЭН ҮГ



Эрхэм гишүүд ээ,

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайд аа,

Хатагтай, ноёд оо,

Бүрэн эрхт Монгол Улсын эрх чөлөөт ард иргэд ээ,

Урин цагийн амьсгал наашилж, цар тахлын аюул цаашилсан цаг үед Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулган нээлтээ хийж байна.

Коронавирусийн дөрөв дэх давалгаа саарч, бүх нийтээрээ хэвийн амьдралын горимд шилжиж байгаа энэ цаг үед “Шинэ сэргэлтийн бодлого”-оо эрчимтэй хэрэгжүүлэх боломж бий боллоо. Гэхдээ цар тахал томуу өвчний хэлбэрт шилжих, шинэ хувилбар дахин дэгдэх эрсдэлтэйг анхаарч, халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нэгэнт тогтсон сайн дадал хэвшлийг дагаж мөрдөх нь зайлшгүй чухал гэдгийг үгийнхээ эхэнд сануулж хэлье.

Улсын эдийн засаг, ард олныхоо амьжиргааг сэргээх боломж бүхнийг алдалгүй ашиглаж, цар тахлын дараах “Шинэ сэргэлтийн бодлого”-оо тууштай хэрэгжүүлэхийн төлөө төр, хувийн хэвшил, иргэд олон нийт нэгдэж, итгэл төгс урагшлах шинэ эрмэлзлийн цаг ирж байна.

Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд ээ,

Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан Та бүхний анхаарлыг гурван багц асуудалд хандуулахыг хүсэж байна.

1.Цар тахлын нөхцөл байдал сайжирч байгаа ч олон улсын нөхцөл байдал хурцадмал болж таамаглах аргагүй, яах нь тодорхойгүй олон эрсдэлийг өдөөж байна.

Гадаад орчин эмзэг байгаа энэ үед монголчууд оюун санаа, үнэт зүйлийн эв нэгдэлтэй байж “Дайны хажуугаар дажин” гэгчээр буруу зөрүү ойлголтоор бусдыг төөрөгдүүлэх, учир начрыг олоогүй байж яаруу гоомой дүгнэлт хийж, нийгэм, олон нийтийг өдөөн турхирах үйлдлээс ангид байх нь чухал байна. Мэдээллийн дайны энэ эрин үед мэдэхгүйн гайд нэрвэгдэх, нийгмийн сүлжээний давалгаагаар нийтийн эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргаж, хөтлөгдөж болохгүй.

Монгол Улсын эдийн засаг 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.4 хувийн өсөлттэй гарсан нь олон улс болон дотоодын мэргэжлийн байгууллагуудын төсөөллөөс харьцангуй бага байлаа.

Хэдийгээр дотоодод цар тахлын халдвар хумигдаж байгаа ч хөрш орнуудын энэ чиглэлээрх хатуу бодлого, гадаад орчны нөлөөллөөс шалтгаалан экспорт буурсан нь эдийн засагт зарим хүндрэл бий болгож байна. Тухайлбал, 2022 оны эхний хоёрдугаар сарын байдлаар төмрийн хүдрээс бусад уул уурхайн бүтээгдэхүүний биет үйлдвэрлэл 13-97 хувь буурч, төлбөрийн тэнцэл 2022 оны нэгдүгээр сард 340.9 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Үнийн өсөлт эрчимжиж, инфляц 2022 оны хоёрдугаар сарын байдлаар улсын хэмжээнд 14.2 хувьд хүрчээ.

Олон улсын тавцанд бий болсон хурцадмал байдал нь инфляцын хөөрөгдөл, зарим бараа бүтээгдэхүүний хомсдол, ханшийн уналт, бүс нутгийн хөрөнгө оруулалтын эрсдэл зэргээр манай улсын эдийн засаг, иргэдийн амьжиргаанд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй байна. Иймд төсөв, мөнгөний бодлогыг оновчтой уялдуулж, инфляц, эдийн засгийг зөв удирдах шаардлагатай байна. Үнийн өсөлтийг хязгаарлаж, эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогыг оновчтой хэрэгжүүлж дараах асуудлуудыг даруй анхаарах шаардлагатай. Үүнд:

1) өргөн хэрэглээний болон стратегийн ач холбогдолтой бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой хангах, нийлүүлэлтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх арга хэмжээг авч, үнийн өсөлтийг бууруулах;

2) импортыг орлох, экспортыг дэмжих үндэсний үйлдвэрлэлийг бүх талаар дэмжих мөнгө, зээл, төсөв, татварын бодлогыг яаралтай хэрэгжүүлэх;

3) дэлхийн хөрөнгийн зах зээл тогтворгүй болж, ирэх жилүүдэд Монгол Улсын гадаад өрийг дахин санхүүжүүлэх эрсдэл нэмэгдэж байгаатай

холбогдуулан өрийн удирдлагын төлөвлөгөөг Улсын Их Хурлаар яаралтай хэлэлцэн батлах;

4) эдийн засгийн уналт үргэлжлэхээс сэргийлж, боомтын хүчин чадал, экспортыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх;

5) үнийн өсөлт, эдийн засгийн хүндрэл эмзэг бүлэгт хүндээр тусах магадлалтай тул нийгмийн халамжийн бодлогыг зорилтот бүлэгт чиглүүлэх нь чухал байна.

Түүнчлэн эрсдэлийн цаана боломж ч бас байгааг олж харж, түүнийг алдахгүйн төлөө чармайн ажиллах хэрэгтэй байна.

Дэлхийн зах зээл дээр алтны ханш унц нь 2000 ам.долларт дөхлөө. Нүүрсний үнэ гуравдугаар сар гарснаас хойш тонн тутамдаа 300 юаниар нэмэгдсэн. Зэсийн үнэ сүүлийн арван жилийн хугацаан дахь хамгийн дээд түвшиндээ хүрсэн ч цаашид нэмэгдэнэ, тонн нь 15.000 ам.долларт хүрэх магадлалтай гэсэн тооцооллыг шинжээчид хийсэн.

Түүнчлэн Европ, Азийг холбосон худалдааны нэг томоохон зангилаа нь манайх байх боломжтой гэж үзэж байгаа. Тиймээс хоёр хөрш болон дэлхийн бусад улс оронтой тогтоосон эдийн засаг, улс төрийн сайн харилцаагаа идэвхжүүлэх, боломжийг бодит ашиг, үр дүнд хүргэхэд чиглэсэн зөв бодлогыг яаралтай боловсруулан хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

2. “Шинэ сэргэлтийн бодлого”-оо цаг алдалгүй хэрэгжүүлж эхэлье.

Энэхүү бодлого нь эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, цар тахлын эдийн засагт учруулсан сөрөг нөлөөллийг арилгах, эрчим хүчний, аж үйлдвэржилтийн, хот-хөдөөгийн, ногоон хөгжлийн болон төрийн бүтээмжийн хүрээнд сэргэлт бий болгох хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг даван туулахад чиглэсэн.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг амжилттай хэрэгжүүлж чадвал эдийн засгийн өсөлт дунджаар зургаан хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого хоёр дахин нэмэгдэнэ. Ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүрч, боомтын хүчин чадал гурав дахин, эрчим хүчний эх үүсвэр хоёр дахин нэмэгдэх юм. Товчоор хэлбэл, Монгол Улс шинэ сэргэлтийн сэргэн мандлын замд гарна. Тиймээс бодлого баталсандаа санаа амарч, тайвширч, алгуурлаж сууж хэрхэвч болохгүй.

Сүүлийн 14 жилийн 12 жилд нь манай улсын төсөв, төлбөрийн урсгал тэнцэл хос алдагдалтай байснаар өр нэмэгдэж, валютын ханш өсөж, төгрөг үнэгүйдэж, үнэ ханш буурах биш, өсөх дарааллаар үргэлжилсээр ирэв. Эдийн засаг маань уул уурхайгаас хэт хараат болж, нийт экспортын 92 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж, уламжлалт мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт дөрвөн хувьд ч хүрэхгүй болжээ. Үүний уршгаар орлогын ялгаа нэмэгдэж, ажилгүйдэл, ядуурал буурахгүй байна.

Тиймээс хэрэглэгчээс үйлдвэрлэгч, импортлогчоос экспортлогч болох зорилгынхоо төлөө иргэн нэг бүр, байгууллага, аж ахуйн нэгж болгон, төр засаг, нийт үндэстэн даяараа хамтарч, тууштай зүтгэн хөдөлмөрлөж, хаврын тариалалт, ноолуур бэлтгэл зэрэг цаг үеийн ажлаас эхлээд, боловсруулах үйлдвэрлэл байгуулах, түүний хүний нөөцийг бэлтгэх, боомтууд, төмөр замын тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг дэд бүтцийн ойрын үеийн зорилтоо ханган хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Өнгөрсөн долоо хоногт Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт эхэллээ. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам энэ долдугаар сард ашиглалтад орох ёстой. Эдгээр төмөр зам ашиглалтад орсноор нүүрсний экспорт 60.0 сая тоннд хүрэх боломжтой. Тиймээс төмөр замдаа онцгой анхаарал хандуулж, төлөвлөсөн хугацаанаасаа өмнө ашиглалтад оруулах бүх талын арга хэмжээ авч ажиллах нь чухал байна.

“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан Улсын Их Хурлаар нэн яаралтай хэлэлцүүлэх томоохон долоон хуулийн төсөл, 2022 онд үе шаттайгаар өргөн мэдүүлж хэлэлцүүлэх 20 хуулийн төслийг шуурхай хэлэлцэх, хэлэлцүүлэгт бэлтгэх шаардлагатай байна. Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн төслүүдийг өргөн мэдүүлсэн байгааг эхний ээлжинд хэлэлцэнэ. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай, Худалдан авах ажиллагааны тухай, Үндэсний баялгийн сангийн тухай, Эдийн засгийн сэргэлтийг дэмжих хөгжлийн төслийг санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх тухай, Хөгжлийн сангийн тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай, Дампуурлын тухай зэрэг хуулийн төслүүдийг боловсруулах, хэлэлцэж батлахад төр, хувийн хэвшил, иргэд, олон нийтийн идэвхтэй оролцоог хангаж, яаравчлах шаардлагатай байна.

3.Улсын хэмжээнд тулгамдсан, шийдлээ хүлээж буй асуудлуудад анхаарлаа хандуулж, оновчтой, хурдтай, зөв шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх нь зайлшгүй чухал боллоо.

Энэ оны хоёрдугаар сарын сүүлчээр үндэсний хэмжээнд явуулсан олон нийтийн санаа бодлын судалгаанаас үзэхэд судалгаанд оролцогчдын 45 хувь нь өрхийн амьжиргаа өмнөхөөсөө дордож, орлого буурсан гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчид ойрын үеийн нэн тулгамдсан таван асуудлаар:

- хүнсний барааны үнийн өсөлт;
- шатахууны үнийн өсөлт;
- эрүүл мэндийн байгууллагын хүртээмж, үйлчилгээний чанар, Ковид-оос бусад өвчлөлд анхаарал хандуулах байдал;
- Улаанбаатар хотын замын түгжрэл;
- ядуурал, иргэдийн амьжиргааны доройтлыг нэрлэсэн байна.

Эрхэм гишүүд ээ,

Энэ хаврын чуулган нэлээд ачаалалтай, шахуу хуваарьтай байхаар байна. 2020 оны сонгуулиар сонгогч олны итгэлийг хүлээн сонгогдсон Та бидний бүрэн эрхийн хугацаа үндсэндээ талдаа орлоо. Шийдлээ хүлээсэн бодлого, шийдвэр, эрх зүйн реформын олон асуудлууд өмнө минь байна. Тиймээс бидэнд илүү идэвх санаачилгатай байж, амралт алжаалыг хойш тавин зүтгэх шаардлагатай байгааг тэмдэглэе.

Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан судалгаагаар хэлэлцүүлгийн шатанд 102 хууль тогтоомжийн төсөл байгаагаас нэгдсэн хуралдаан, Байнгын хороогоор хэлэлцэх, эсэхийг нь шийдвэрлэсэн 56 төсөл байна. Тэдгээрээс хамгийн олон нь буюу 30 төсөл Эдийн засгийн байнгын хороонд, тус бүр 12-13 төсөл Хууль зүй, Төрийн байгуулалт, Нийгмийн бодлогын байнгын хороон дээр байна.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэн тэргүүнд хэлэлцэн батлах ёстой 31 томоохон хууль багтсанаас бид 14 хууль баталж, хоёр хуулийн төсөл хэлэлцүүлгийн шатанд байгаа.

Үндэсний баялгийн сангийн тухай, Улс төрийн намын санхүүжилтийн тухай анхдагч хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон нэмэлт, өөрчлөлт оруулах тухай бусад хуулийн төслүүд батлагдаагүй үлдээд байна. Нэн тэргүүнд батлах ёстой эдгээр хуулийн зарим нь одоо хүртэл өргөн баригдаагүй байгааг сануулъя.

Энэ удаагийн Улсын Их Хурал хүний эрхийг дээдэлсэн парламент байж, батлан гаргаж буй хуулиуддаа хүний эрхийг амин сүнс болгон суулгах, хөгжлийн монгол загвар бий болгож, эдийн засгийн Шинэ сэргэлтийн замд орох талаар дэвшүүлсэн зорилгоо хэрэгжүүлэхийн төлөө тууштай чармайх болно.

Улмаар эдгээр хоёр үндсэн зорилго дээрээ нэмж нэг шинэ зорилго дэвшүүлж байгаагаа Та бүхний анхааралд толилуулъя. Энэ бол парламентын төгөлдөршил буюу парламентын ардчиллын хөгжил шинэтгэлийн тухай асуудал юм.

Парламентын ардчиллыг төлөвшүүлэх талаар дөрвөн асуудлыг онцолъё гэж бодож байна.

Нэгдүгээрт, парламентын засаглалыг сонгон замнасан өнгөрсөн 30 жилд бид туршлага, сургамжийн аль алиныг хуримтлуулсан. Сонгуулиар засаг төрөө эмхлэн байгуулдаг, олон намын төлөөлөлтэй, ардчилсан парламентын засаглалд эргэлт буцалтгүй шилжсэн нь яахын аргагүй том ололт.

2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр олон зүйлийг засаж сайжруулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүд томилох, томилогдох болон төсвийн эрх мэдлээсээ татгалзаж, Засгийн газрын тогтвортой байдалд Улсын Их Хурлын зүгээс нөлөөлөх нөлөөллийг эрс багасгаж чадсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгалахаар заасан. “Төрийн бодлогыг тодорхойлж, нийгмийн харилцааг зохицуулахын тулд ард түмний өмнөөс хууль тогтоомжийн акт гаргаж, түүнийгээ гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа байдлыг хянан шалгаж, дэмжих замаар улсыг хуулиар жолоодох үйл ажиллагааг бүхэлд нь хууль тогтоох эрх мэдэл гэнэ” хэмээн Үндсэн хуулийн эхийг баригч Бяраагийн Чимид гуай тодорхойлсон байдаг.

Тэгэхээр хууль тогтоох эрх мэдэл нь зөвхөн хууль “үйлдвэрлэх” төдий ойлголт бус, хууль батлан гаргах, баталсан хуулийнхаа хэрэгжилтийг хянан шалгаж, эцсийн үр дүнд хүргэх замаар нийгмийг хуулиар жолоодох нь энэ эрх мэдлийн үндэс юм.

Гэтэл өнгөрсөн он жилүүдэд хянан шалгах чиг үүрэгтээ Улсын Их Хурал дутуу дулим хандаж ирсэн нь бодит үнэн. Хууль хэрэгжүүлэх нь Засгийн газрын үүрэг гэсэн зарчмаар халхавч хийсээр өнөөг хүргэсэн. Энэ байдлыг засаж, хянан шалгах үндсэн чиг үүргээ хууль ёсоор хэрэгжүүлэхийн тулд өнгөрсөн чуулганаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг баталсан. Энэ хууль батлагдсанаар сонгодог парламент болж төлөвших шинэ үе шат эхэлж байна хэмээн хэлсний учир үүнд оршиж байгаа юм.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль нь шударга ёсыг тогтоох, төрийн бүх шатанд сахилга хариуцлагыг бэхжүүлэх амин чухал зорилтыг хэрэгжүүлэх чухал арга хэрэгсэл юм.

Монголын ард түмэн хүнсний бараа, шатахууны үнийн өсөлтөөс илүү шударга ёс алдагдаж байгаад бухимдан дургүйцэж байна. Үүний нэг жишээ нь Хөгжлийн банк тойрсон асуудал юм. Тиймээс Улсын Их Хурлаас тусгайлан ажлын хэсэг байгуулж, тус банканд хяналт шалгалт хийж байна. Энэ асуудлаар гуравдугаар сарын 29-ний өдөр Ерөнхий хяналтын сонголт хийхээр товлосон. Энэхүү арга хэмжээний үр дүнд хэн, хэчнээн хэмжээний хөрөнгийг, ямар зорилгоор, хэрхэн авсан нь олон нийтэд ил тод болох ёстой.

Хөгжлийн банкны зээл Монгол Улсын эдийн засагт, хөгжилд өгөөжөө өгсөн байх учиртай бүрэн бүтэн эргэж төвлөрөх ёстой. Үүний төлөө Улсын Их Хурал ажиллах болно.

Нэг зүйлийг тэмдэглэж хэлэхэд, зээлээ зориулалтын дагуу ашиглаж, зээл, хүүгийн төлбөрөө зохих журмын дагуу төлж байгаа, цар тахлын нөлөө, макро эдийн засгийн алдаатай зарим шийдвэрийн улмаас буюу хүндэтгэн үзэх шалтгаанаар төлбөр нь саатсан ч төлбөрийн баталгаа гарган ажиллаж байгаа баялаг бүтээгчид, үндэсний үйлдвэрлэгчдийг буруу аргаар зээл авсан,

түүнийгээ зориулалтын бусаар ашигласан, зээлээ төлөхөөс бултаж, зугтаж яваа хүмүүсээс ялгаж салгаж хандах ёстой гэдгийг тэмдэглэж хэлье.

Хөгжлийн банкны чанаргүй зээлийн гуравны нэг нь төрийн өмчийн үйлдвэрийн газруудынх байгаад анхаарал хандуулах ёстой. Төрийн өмчийн үйлдвэрийн газруудын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийн ашиглалтад байнгын хяналт тавьж, ашиглан завшигч хандлага, хэт үрэлгэн, салан задгай байдалд цэг тавих цаг болсныг онцолъё.

Дээр дурдсан санал асуулгад оролцогчдын 64 хувь нь Улсын Их Хурлын эрхэм гишүүн Б.Баттөмөрийн ахалсан ажлын хэсэг энэ асуудлыг шударгаар шийдвэрлэж чадна хэмээн итгэж байгаагаа илэрхийлсэн байна билээ. Тиймээс энэ итгэлийг биелүүлэхийн төлөө хичээж зүтгэхийг ажлын хэсэгт үүрэг болгоё.

Хоёрдугаарт, парламент ард түмнээ бүрэн дүүрэн төлөөлөх учиртай. Бид ард түмний төлөөллийг хангалттай хэрэгжүүлж чадаж байгаа юу? Нийгмийн бүхий л ашиг сонирхлын бүлэглэлүүдийг бүрэн төлөөлж чаддаг уу, иргэдийн засаглах эрхийг эдлүүлж чадаж байгаа юу гэвэл, бүрэн хангалттай биш байгаа. Энэ нь олон хүчин зүйлээс хамаарч байж болох ч одоо мөрдөгдөж буй эрх зүйн тогтолцооноос нэлээд хэмжээгээр хамаарч буйг хэлэх хэрэгтэй.

Тухайлбал, сонгуулийн тогтолцооны асуудлыг дурдаж болно. Тиймээс сонгуулийн тогтолцооны олон хувилбаруудаас Монголын нөхцөлд хамгийн тохиромжтой, ард түмний төлөөлөх чадамжийг хангасан тогтолцоог сонгон хэрэглэх нь парламентын төлөвшил, төгөлдөршил, намуудын төлөвшил, ардчилсан засаглалын ирээдүй, Монгол Улсын эрх ашигт гарцаагүй чухал гэдгийг бодолцож, шийдэл гаргах цаг болсон.

Гуравдугаарт, маргаан дагуулдаг өөр нэг асуудал бол парламентын гишүүдийн тооны тухай яриа юм. Үндсэн хуулийг баталж байх 1992 онд манай улс 2.1 сая иргэнтэй байсан бол одоо 3.4 сая иргэнтэй болсон байна. Гучин жилийн өмнө нэг гишүүн 27.6 мянган хүнийг төлөөлж байж. Одоо нэг гишүүнд 44.7 мянган иргэн ногдож байна. Даруй 1.6 дахин өссөн гэсэн үг. Энэ хэрээр төлөөлийн чадамж суларсан байна. Тиймээс сайжруулах, эргэж харах цаг болсон гэдгийг Улс төрийн намын тухай хуулийн төслийг хэлэлцэх үеэр улс төрийн намуудын саяханы зөвлөгөөнөөр улс төрийн намууд санал нэгтгэйгээр гаргасныг энд онцлон тэмдэглэж байна.

Дөрөвдүгээрт, парламентад цахим шилжилт хийх нь зайлшгүй зорилт мөн. Улсын Их Хурлын 2024 он хүртэлх Стратеги төлөвлөгөөнд Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлж, иргэдийн оролцоог дэмжсэн цахим орчин бүрдүүлж, олон нийтэд нээлттэй, ил тод цахим парламент болох зорилтыг дэвшүүлсэн.

Мэдээллийн технологийн дэвшил дэлхийн улс орнуудын парламентад асар өргөн хүрээнд, маш хурдтай нэвтэрч байна. Бид үүнээс хоцрох ёсгүй.

Тиймээс тодорхой алхмууд хийж байгаа. Хуралдааны ирцэд гишүүдийг бүртгэх, үг хэлэх, санал өгөхөд биеийн давхцахгүй өгөгдөл буюу хурууны хээ ашигладаг болсноор “төгөлдөр хуурддаг” буруу үзэгдлийг бүрэн халсан. Үр дүнд нь хуралдааны ирц, гишүүдийн хариуцлага эрс сайжирсан. Цаашид нүүр таньдаг системийг суурилуулахаар ажиллаж байна. Хуулийн төсөл боловсруулах, санал авах lawmaker.parliament.mn, lawforum.parliament.mn системийг нэвтрүүлсэн. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Улсын Их Хурал үйл ажиллагаагаа нэг ч удаа тасалдуулалгүй явуулж, цахим хуралдааны томоохон туршлага хуримтлууллаа.

Эдгээрт тулгуурлан Улсын Их Хурал иргэдийн хүсэлт, өргөдөл, гомдлыг цахимаар авдаг “E-petition” цогц системийг олон улсын жишиг, аргачлалын дагуу үйл ажиллагаандаа нэвтрүүлж, холбогдох хуулийн төслийг боловсруулж, хаврын ээлжит чуулганаар батлуулахаар төлөвлөж байна. Энэ систем хууль тогтоох үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо хэлбэрийн төдий хангагддаг байдлыг засаж, Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ард түмний засаглах эрхийг эдлүүлэхэд чиглэнэ.

Энэ хүрээнд хуулийн төсөлд иргэдээс санал авах, иргэдтэй хамтран хэлэлцүүлэг хийх, иргэдийн хүсэлт, гомдлыг хүлээн авах, иргэддээ парламент бүрэн нээлттэй байх гэсэн дөрвөн үндсэн функцтэй “D-Parliament” цахим систем, аппликэйшнийг нэвтрүүлэх гэж байна. Үүгээр парламентын үйл ажиллагаа шилэн болж, иргэдийн гарт, гар утсан дээр нь очно гэсэн үг юм.

Иргэд нийгэмд тулгамдаж буй халуун сэдвээр тус платформ дээр цахим хэлэлцүүлэг өрнүүлж, тэр нь хуульд заасан тодорхой тооны хүний дэмжлэгийг авбал асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцэн, шийдвэрлэх боломж бүрдэнэ.

Монгол Улсын нийт өрхийн 80 хувь нь интернэтэд холбогдож, хүн амын 84.7 хувь нь ухаалаг утас хэрэглэж байна. Монгол Улсад интернэт хэрэглэгчдийн тоо 2.6 саяд хүрсэн. Суурь бүтэц ийм сайн байхад иргэдийн оролцоотой хууль тогтоодог, нээлттэй, ил тод, сонгогчидтойгоо амьд холбоотой цахим парламент болж, Улсын Их Хурал болон иргэдийг зааглаж буй зааг ялгааг нураах зорилго амжилтад хүрнэ гэдэгт огт эргэлзэхгүй байна.

Цаашид бид хууль тогтоох, хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэх, хуралдаан, хэлэлцүүлэг зохион байгуулах, хууль тогтоомж, судалгаа мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг бүхий л үйл ажиллагаандаа цахим технологийн боломж, инновацыг шингээх нь ард түмний засаглах эрхийг хангасан парламент болж төгөлдөржихөд нэн чухал ач холбогдолтой юм.

Энэ зорилтын хүрээнд зарим аймагт Улсын Их Хурлын үйл ажиллагааг нээлттэй сурталчлах төв байгуулж, мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгох, “Парламентын боловсрол” хөтөлбөрийг аймаг, нийслэл, дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсролын төвүүдээр дамжуулан хэрэгжүүлж, иргэддээ ардчилал, хүний эрх, Үндсэн хуульт болон парламентат

ёсны мэдлэг, боловсрол олгох ажлыг эрчимтэй явуулах ажлыг Улсын Их Хурлын Тамгын газраас хэрэгжүүлж байна.

Улсын Их Хурлын Эрхэм гишүүд ээ,

Хүндэт ард иргэд ээ,

“Хатан зориг бүхий л чадлаараа

Хайртай Монгол орноо мандуулъя” гэж бид төрийн дууллаа дуулдаг билээ. Монголчууд бид нэгдмэл үнэт зүйлстээ тулгуурлан, эвийн хүчийг эрхэмлэн, Монголоо мандуулах түүхэн цаг ирсэн байна. Үүнтэй холбогдуулан “Монголоо мандуулъя” төслийг эхлүүлэхээр Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо санаачлаад байна.

Монголчуудын оюун сэтгэлгээний дархлаа болсон эх оронч үзэл, үндэсний өв соёлоо дээдлэх үзлийг бэхжүүлэх нь Монголынхоо ирээдүй хойч үеийн өмнө бидний хүлээх журамт үүрэг юм. XXI зуунд дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах нь зүй ёсны хэрэг боловч даяаршлын эринд үндэстний ондоошлоороо ялгарч, оюуны дархлаагаа сэргээн бэхжүүлэх нь нэн чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Энэхүү төслийн зорилго нь үндэсний бахархалт өв соёлоо дээдлэх, уламжлалт зан заншлаа өвлөн дэлгэрүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, архидалт, ажилгүйдэл, авлигаас ангижрах, үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүлж үйлдвэрлэгч, бүтээн байгуулагч ард түмэн болох, ядуурлаас салж, хөгжин дэвшихэд чиглэх болно. Энэхүү аяныг хот, хөдөөгүй монгол хүн бүр, байгууллага, аж ахуйн нэгж болгон дэмжиж ажиллахыг уриалъя.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулган нээснийг мэдэгдье.



УИХ-ын 2022 оны хаврын чуулганы нээлтийн үйл ажиллагаа.

УИХ-ЫН ДАРГЫН ХАВРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ДАХЬ УУЛЗАЛТ, ДОТООД АРГА ХЭМЖЭЭ



Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Монгол Улс дахь Суурин төлөөлөгч ноён Ханнес Такач УИХ-ын дарга Г.Занданишарт баралхав.
2022.03.16



УИХ-ын дарга “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэн сайн таниулах вэ?” цахим хакатон тэмцээний шилдэг оролцогчид болон зохион байгуулагчдын төлөөллийг хүлээн авч уулзлаа.
2022.03.22




Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагуудын дарга нартай уулзаж, үүсээд байгаа өнөөгийн нөхцөл байдалтай холбогдуулан үүрэг, чиглэл өглөө.
2022.04.10



УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хуралдаж, УИХ-ын дарга Г.Занданишатар “Ажлаа хий” уриан дор зохион байгуулагдсан жагсаалын үеэр тавьсан залуусын шаардлагад бодитой хариу өгөх талаар чиглэл өгөв.
2022.04.10



УИХ-ын дарга үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөлтэй уулзаж, гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг бууруулах боломж ишийдэл, гарцын талаар санал солилцлоо.
2022.04.13



Олон улсын валютын сангийн Монголыг хариуцсан ажлын хэсгийн ахлагч хатагтай Ангана Банержи тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.
2022.05.02



Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын албанд ноён Ян Вытопилийг шинээр томилогдсонтой нь холбогдуулан хүлээн авч уулзлаа. 2022.05.10



УИХ-ын дарга Г.Занданшатар НУБ-ын Хүүхдийн сангийн Зүүн Ази, Номхон далайн бүсийн захирал хатагтай Дебора Комини тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. 2022.05.12




Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн оюутнуудад D-Parliament цахим системийн талаар танилцууллаа. 2022.05.16



“Илүү их унигья” уриатайгаар зохион байгуулагдах 31 дэх номын баярыг зохион байгуулах комиссын гишүүдтэй уулзлаа. 2022.05.17



Улсын Их Хурлын дарга Төрийн тусгай хамгаалалтын газрын удирдлагуудыг хүлээн авч уулзан Төрийн ордныг иргэдэд нээлттэй болгох талаар санал солилцлоо. 2022.05.17



Шведийн Хаант Улсын парламент буюу Риксдагийн Тэргүүн дэд дарга хатагтай Оса Линдестам тэргүүтэй төлөөлөгчид УИХ-ын даргад бараалахлаа. 2022.05.24



Азийн хөгжлийн банкны Монгол Улсыг харцуцсан захирал Павит Рамачандран тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

2022.05.26



Улсын Их Хурлын дарга Г.Занданишатар, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Х.Болорчулуун нар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд ажиллалаа.

2022.05.31



Бүгд Найрамдах Энэтхэг Улс дахь Монгол Улсын Соёлын элч Мухит Чоухан тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа.

2022.06.15



Монгол дахь Америкийн худалдааны танхим (АмЧам Монгол)-ын Удирдах зөвлөлийн дарга Жэймс Лиотта тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

2022.06.21



НУБ-ын төрийн албаны өдөрт зориулж, Улсын Их Хурлын дарга Г.Занданишатар мэндчилгээ дэвшүүлэв.

2022.06.23




Улсын Их Хурлын дарга Г.Занданиатар нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагч, иргэдтэй уулзав. 2022.06.27



Япон Улсын Токүшима дахь Монгол Улсын Өргөмжит консул Каваүчи Широүг хүлээн авч уулзав. 2022.06.28



Азийн хөгжлийн банкны Зүүн Азийн газрын ерөнхий захирал, хатагтай М.Тереза Хо тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. 2022.07.01



Улсын Их Хурлын дарга Г.Занданиатарын санаачилгаар үе үеийн Улсын Их Хурлын дарга нараас бүрдсэн "Хуралдай" клубийн ээлжит уулзалт болов. 2022.07.04



Улсын Их Хурлын дарга "Ил хаант улсыг үндэслэгч Хүлэгү ханы зуны ордон: БНТУ-ын нутаг буй Аладагийн ордны хайгуул, судалгаа"-ны төслийн удирдагч, доктор Д.Анхбаяр тэргүүтэй судлаачдыг хүлээн авч уулзлаа. 2022.07.05



Оросын Холбооны Улсын Гадаад хэргийн сайд С.В.Лавров тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсын Их Хурлын даргад бараалхав. 2022.07.05

НЭГ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХҮҮЛЬ ТОГТООХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТОЙМ



ХУРАЛДСАН ӨДӨР, ТОО

2022.03.15-2022.07.06 ХҮРТЭЛ



- Бие даасан хууль - **18**
- Нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль - **313**
- Хүчингүй болсонд тооцох тухай хууль - **8**
- Гэрээ конвенц соёрхон батлах тухай хууль - **3**
- Улсын Их Хурлын тогтоол - **44**

80 ажлын өдөр	ЧУУЛГАН
37 удаа	ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТОО
142 удаа	БАЙНГЫН БОЛОН ДЭД, ТҮР ХОРООДЫН ХУРАЛДААН

УИХ-ЫН ГИШҮҮД АЖЛЫН

ХЭСГЭЭС АСУУСАН



АСУУЛТ, ХАРИУЛТ **1146**



УИХ-ЫН ГИШҮҮД ҮГ ХЭЛСЭН
286 удаа,
20 цаг 23 минут



ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААН

2022.03 дугаар сар: 7 удаа 22 цаг 19 минут
2022.04 дугаар сар: 12 удаа 53 цаг 38 минут
2022.05 дугаар сар: 7 удаа 46 цаг 54 минут
2022.06 дугаар сар: 8 удаа 48 цаг 00 минут
2022.07 дугаар сар: 3 удаа 20 цаг 56 минут

- Чуулганы нэгдсэн хуралдааны явцын талаар нийт **617** хуудас товч тэмдэглэл хөтөлж, **3288** хуудас дэлгэрэнгүй тэмдэглэлийг дууны бичлэгээс буулгав.
- Байнгын хороодын **124** удаагийн, **222** цаг **03** минутын хуралдааны явцын талаар **773** хуудас товч тэмдэглэл хөтөлж, **3933** хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдэв.
- Дэд хороодын **8** удаагийн **13** цаг **15** минутын хуралдааны явцын талаар **21** хуудас товч тэмдэглэл хөтөлж, **202** хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдэв.
- Түр хорооны **3** удаагийн **6** цаг **06** минутын хуралдааны явцын талаар **7** хуудас товч тэмдэглэл хөтөлж, **117** хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдэв.
- Хянан шалгах түр хороодын **7** удаагийн **11** цаг **15** минутын хуралдааны явцын талаар **21** хуудас товч тэмдэглэл хөтөлж, **193** хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдэв.



Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы нээлт



УИХ дахь МАН-ын бүлгийн гишүүд



УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд



УИХ дахь бие даагч болон бусад нам, эвслийн төлөөлөл

ХОЁР

УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН БОЛОН ДЭД,
ТҮР ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ БОЛОН ДЭД, ТҮР ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ



ХУРАЛДСАН ӨДӨР, ТОО

2022.03.15-2022.07.06 ХҮРТЭЛ



БАЙНГЫН ХОРООД

124 удаа

ДЭД, ТҮР ХОРООД

18 удаа

ДЭД ХОРОО

ХУРАЛДСАН ТОО

8

НУТГИЙН УДИРДЛАГЫН ДЭД ХОРОО

1

УИХ-ЫН ГИШҮҮНИЙ ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ДЭД ХОРОО

2

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРОО

2

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДЭД ХОРОО

1

ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРОО

1

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ДЭД ХОРОО

1

ТҮР ХОРОО

ХУРАЛДСАН ТОО

3

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН БИЕЛЭЛТИЙГ САР ТУТАМ НЭЭЛТТЭЙГЭЭР ХЭЛЭЛЦЭЖ, ХЯНАЛТ ТАВИХ, ШААРДЛАГАТАЙ БОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХОЛБОГДОХ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ, САНАЛ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ҮҮРЭГ БҮХИЙ

2

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН

1

ХЯНАН ШАЛГАХ
ТҮР ХОРОО

ХУРАЛДСАН ТОО

7

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНААС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ЗЭЭЛ ОЛГОЛТ, ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ЯВЦЫН ТАЛААР ХЯНАН ШАЛГАХ ҮҮРЭГ БҮХИЙ

5

ХҮНИЙ ЭМИЙН ЧАНАР, ХУУРАМЧ БОЛОН СТАНДАРТ БУС ЭМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН АСУУДЛААР МОНГОЛ УЛСАД ЭМИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ САЙЖРУУЛАХ, ХЯНАН ШАЛГАХ ҮҮРЭГ БҮХИЙ

1

ХИЛИЙН БООМТУУДААР АЧАА, ТЭЭВЭР, НҮҮРС НЭВТРҮҮЛЭХ БОЛОН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД УЧИРЧ БАЙГАА ХҮНДРЭЛИЙГ ШАЛГАН ТОГТООХ ҮҮРЭГ БҮХИЙ

1

Байнгын хорооны **197** санал, дүгнэлт, танилцуулга бэлтгэн чуулганы нэгдсэн хуралдаанд оруулан шийдвэрлүүлжээ.

Байнгын хороонд иргэдээс **156** өргөдөл, гомдол ирүүлснээс **127**-д нь харуу өгч шийдвэрлэсэн бол албан байгууллага, аж ахуйн нэгжээс **452** албан бичиг ирүүлснийг хууль тогтоомжид заасан журмын дагуу хянаж, **163** албан бичигт харуу өгсөн.

2.2. БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХАРЬАЛАЛ

/2022.07.07-ны өдрийн байдлаар/

№	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо	Ёс зүй, сахилга хармуцлагын байнгын хороо	Инновац, цахим бодлогын байнгын хороо	Нийгмийн бодлогын байнгын хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Төсвийн байнгын хороо	Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо	Хууль зүйн байнгын хороо	Эдийн засгийн байнгын хороо
1.	Б.Баттөмөр	Х.Болорчулуун	Г.Дамдинням	Б.Бат-Эрдэнэ	Н.Учрал	М.Оюунчимэг	Ж.Мөнхбат	Ч.Хүрэлбаатар	Б.Чойжилсүрэн	С.Бямбацогт	Ж.Ганбаатар
2.	Ш.Адьяашаа	Ц.Анандбаатар	А.Адьяасүрэн	Ш.Адьяашаа	Г.Амартүвшин	П.Анужин	С.Амарсайхан	Г.Амартүвшин	А.Адьяасүрэн	Ш.Адьяашаа	Т.Аюурсайхан
3.	Н.Алтанхуяг	Т.Аубакир	Г.Амартүвшин	Х.Баделхан	Э.Бат-Амгалан	Д.Батлут	А.Адьяасүрэн	Д.Өнөрболор	Ц.Анандбаатар	Н.Алтанхуяг	Д.Батлут
4.	П.Анужин	Б.Бат-Эрдэнэ	П.Анужин	Б.Баярсайхан	Э.Батшугар	Б.Баярсайхан	Ё.Баатарбилэг	Ц.Анандбаатар	Т.Аубакир	С.Амарсайхан	Б.Баттөмөр
5.	Т.Аюурсайхан	Ж.Бат-Эрдэнэ	Т.Аубакир	Б.Баттөмөр	Х.Ганхуяг	Б.Бейсен	Ж.Батсуурь	Х.Булгантуяа	Ж.Бат-Эрдэнэ	Д.Ганбат	Д.Бат-Эрдэнэ
6.	Х.Баделхан	Ж.Батжаргал	Ё.Баатарбилэг	С.Бямбацогт	Н.Ганибал	С.Ганбаатар	С.Бямбацогт	Ж.Батжаргал	Ж.Батжаргал	Б.Дэлгэрсайхан	Ж.Бат-Эрдэнэ
7.	Х.Булгантуяа	Б.Бейсен	Б.Баярсайхан	Б.Бейсен	Т.Доржханд	Ц.Идэрбат	Ж.Ганбаатар	Х.Баделхан	Д.Батлут	Л.Мөнхбаатар	Х.Болорчулуун
8.	С.Батболд	Г.Ганболд	Э.Батшугар	Ж.Мөнхбат	Ц.Идэрбат	Ц.Сандаг-Очир	Г.Ганболд	Ж.Батсуурь	Г.Ганболд	Ц.Мөнхцэцэг	Х.Булгантуяа
9.	Э.Бат-Амгалан	Н.Ганибал	Х.Ганхуяг	Л.Энх-Амгалан	Ц.Сэргэлэн	Д.Сарангэрэл	Г.Занданшатар	С.Ганбаатар	С.Ганбаатар	Ц.Мөнх-Оргил	Н.Ганибал
10.	Б.Бат-Эрдэнэ	Г.Дамдинням	Ж.Мөнхбат	Б.Энхбаяр	Б.Саранчимэг	Б.Саранчимэг	Ц.Мөнх-Оргил	Ц.Даваасүрэн	Г.Дамдинням	Х.Нямбаатар	Х.Ганхуяг
11.	Д.Бат-Эрдэнэ	Г.Мөнхцэцэг	Б.Жаргалмаа	Ж.Чинбүрэн	Ж.Чинбүрэн	Ц.Мөнх-Оргил	Ц.Мөнхцэцэг	Л.Мөнхбаатар	Л.Мөнхбаатар	Б.Пүрэвдорж	Ц.Даваасүрэн
12.	Д.Ганбат	Н.Наранбаатар	Ц.Мөнхцэцэг	Ц.Ундрам	Ч.Ундрам	С.Одонтуяа	Х.Нямбаатар	С.Одонтуяа	Н.Наранбаатар	Ш.Раднаасэд	Т.Доржханд
13.	Т.Доржханд	Д.Өнөрболор	Г.Мөнхцэцэг	Г.Мөнхцэцэг	Б.Жаргалмаа	Б.Жаргалмаа	М.Оюунчимэг	Б.Пүрэвдорж	Д.Өнөрболор	Ц.Сандаг-Очир	Б.Жавхлан
14.	Б.Дэлгэрсайхан	Б.Саранчимэг	Ж.Чинбүрэн	Ж.Чинбүрэн	Ц.Туваан	Ц.Туваан	Л.Оюун-Эрдэнэ	Ш.Раднаасэд	О.Цогтгэрэл	Ж.Сүхбаатар	М.Оюунчимэг
15.	Н.Наранбаатар	Г.Тэмүүлэн	Ч.Ундрам	Ч.Ундрам	Ч.Ундрам	Ч.Ундрам	Б.Пүрэвдорж	Ц.Сандаг-Очир	Ш.Раднаасэд	Ц.Сэргэлэн	Ч.Хүрэлбаатар
16.	Ц.Сэргэлэн	Ц.Туваан	Н.Учрал	Н.Учрал	С.Чинзориг	С.Чинзориг	Ж.Сүхбаатар	Д.Тогтохсүрэн	Г.Тэмүүлэн	Н.Учрал	О.Цогтгэрэл
17.	Д.Цогтбаатар	О.Цогтгэрэл	С.Чинзориг	С.Чинзориг	Ж.Чинбүрэн	Ж.Чинбүрэн	Д.Тогтохсүрэн	Г.Тэмүүлэн	Т.Энхтүвшин	Д.Цогтбаатар	Ц.Цэрэнлунцаг
18.	Б.Энх-Амгалан	Ц.Цэрэнлунцаг	Т.Энхтүвшин	Т.Энхтүвшин	Н.Энхболд	Н.Энхболд	Н.Энхболд	Б.Жавхлан	Ц.Туваан	Б.Энх-Амгалан	С.Чинзориг
19.	Н.Энхболд	Т.Энхтүвшин	Л.Энх-Амгалан	Л.Энх-Амгалан			Ж.Эрдэнэбат	Б.Чойжилсүрэн	Ж.Эрдэнэбат	Б.Энхбаяр	Б.Энхбаяр

ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХАРЬАЛАЛ

/2022.07.07-ны өдрийн байдлаар/

№	Тусгай хяналтын дэд хороо	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо	Нутгийн удирдлагын дэд хороо	Улсын Их Хурлын халдлагын байдлын дэд хороо	Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо	Төсвийн зарлагын хяналтын дэд хороо	Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хороо	Хөнгөн үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо	Хүнд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо	Хүний эрхийн дэд хороо	Тогтвортой хөгжлийн зоригын дэд хороо
1	С.Батболд	Б.Саранчимэг	Ё.Баатарбилэг	Н.Энхболд	Г.Ганболд	Б.Пүрэвдорж	Ж.Бат-Эрдэнэ	Ц.Анандбаазар	Г.Тэмүүлэн	Б.Энхбаяр	Х.Булгантуяа
2	Н.Алтанхуяг	Т.Аубакир	Ж.Батсуурь	С.Батболд	Ж.Мөнхбат	Г.Амартүвшин	А.Адъяасүрэн	А.Адъяасүрэн	Ц.Анандбаазар	Ш.Адъяашаа	Б.Баттөмөр
3	Т.Аюурсайхан	Г.Ганболд	Г.Ганболд	Б.Бат-Эрдэнэ	Ц.Мөнх-Оргил	Ц.Анандбаазар	Ж.Батжаргал	Т.Аубакир	Н.Наранбаатар	Н.Алтанхуяг	Д.Бат-Эрдэнэ
4	Д.Бат-Эрдэнэ	Г.Дамдинням	Х.Нямбаатар	С.Бямбацогт	Б.Пүрэвдорж	Ж.Батжаргал	Г.Ганболд	Д.Өнөрболор	Ц.Туваан	Д.Ганбат	Н.Ганибал
5	Б.Дэлгэрсайхан	Ц.Туваан	Ж.Сүхбаатар	Ц.Мөнх-Оргил	Ж.Ганбаатар	Ж.Батсуурь	С.Ганбаатар	Ш.Раднаасэд	О.Цогтгэрэл	Ц.Мөнхцэцэг	Х.Ганхуяг
6	Ц.Сэргэлэн					Х.Булгантуяа	Т.Энхтүвшин	Г.Тэмүүлэн	Б.Чойжилсүрэн	Ш.Раднаасэд	Т.Доржжанд
7	Б.Энх-Амгалан					С.Ганбаатар		Ц.Туваан	Т.Энхтүвшин	Ц.Сандаг-Очир	Б.Жавхлан
8						Г.Тэмүүлэн				Ж.Сүхбаатар	
9										Н.Учрал	

НЭГ. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Б.БАТТӨМӨР



АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд



19 ГИШҮҮН

12

удаа

ХУРАЛДААН

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ (давхардсан тоогоор) **25**

6 ЗӨВШИЛЦӨХ АСУУДАЛ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТЭСӨЛ **2**

15 САНАЛ, ДҮГНЭЛТ

БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ **3**

11 ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛ

ХУУЛИЙН ТЭСӨЛ **11**

2 ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН **1**

2 ТАНИЛЦУУЛГА

Батлуулсан хууль, тогтоомж

БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ **3**

7 ХУУЛЬ

Ажлын хэсэг **1** удаа байгуулж **5** удаа хуралдсан.

Тайлант хугацаанд ирсэн албан бичиг **26**, харуу өгсөн албан бичиг **53**

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Байнгын хороо ээлжит чуулганы хугацаанд долоон хуулийн төслийг эцэслэн батлуулж, Байнгын хорооны гурван тогтоолыг баталж, олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцын зөвшилцөх зургаан асуудлыг шийдвэрлэж, холбогдох байгууллагуудад хуралдааны тэмдэглэлээр зургаан үүрэг, даалгавар өгч, хоёр хэлэлцүүлэг зохион байгуулав.

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг

<i>Шийдвэр</i>	<i>Ажлын хэсгийн нэр</i>	<i>Бүрэлдэхүүн</i>
Байнгын хорооны тогтоол 2022.03.23, №02	Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн	Ажлын хэсгийн ахлагч: Б.Энх-Амгалан Гишүүд: Х.Булгантуяа Н.Наранбаатар Б.Пүрэвдорж Н.Энхболд

Хяналт шалгалтын ажлын талаар

Хяналт шалгалтын ажлын хүрээнд холбогдох гурван байгууллагын мэдээллийг сонсож, Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны нэг тогтоолыг батлуулсан.

Бусад ажлын талаар

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, мэдээлэл солилцох зорилгоор хоёр хэлэлцүүлэг, нэг уулзалт, ярилцлага, гадаадын зочид, төлөөлөгчтэй таван уулзалт, гадаад томиллолт, нэг албан айлчлалыг зохион байгуулж ажиллав.



Байнгын хорооны дарга Б.Баттөмөрийн санаачилгаар “Монгол Улсад хөгжлийн шинэ загварыг бий болгох нь” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав.
2022.03.21



Байнгын хорооны хуралдаанаар Тамсагбулагийн сав газрын Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд үйл ажиллагаагаа явуулж байгаа “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн үйл ажиллагааны талаар мэдээлэл сонлоо.
2022.05.18




Байнгын хорооны дарга Б.Баттөмрийн санаачилгаар “Монгол Улсад төрийн зохицуулалтыг оновчтой болгох нь” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав. 2022.05.23



Байнгын хорооны дарга Шведийн Хаант Улсын парламент буюу Риксдагийн Тэргүүн дэд дарга хатагтай Оса Линдестам тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. 2022.05.23



Байнгын хорооны дарга Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд ноён Зафер Атешийг хүлээн авч уулзав. 2022.06.07



Байнгын хорооны дарга Европын Холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайд хатагтай Аксель Никейзийг хүлээн авч уулзлаа. 2022.06.03



Байнгын хорооны дарга Б.Баттөмөр тэргүүтэй төлөөлөгчид Бельгийн Хаант Улсын Парламентад зочилж, Парламентын Сенатын танхимын дарга хатагтай Стефани Д’хос-т бараалхав. 2022.06.16



Байнгын хорооны дарга Б.Баттөмөр тэргүүтэй төлөөлөгчид Люксембургийн Их Гүнт Улсад айлчлав. 2022.06.17

ХОЁР.БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО



БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Х.БОЛОРЧУЛУУН



19 ГИШҮҮН

12

удаа

ХУРАЛДААН

1

удаа

ХАМТАРСАН
ХУРАЛДААН

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ (Давхардсан тоогоор) **26**

6 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН

ХУУЛИЙН ТЭСЭЛ **12**

58 ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

УИХ-ЫН ТОГТООЛЫН ТЭСЭЛ **4**

12 САНАЛ, ДҮГНЭЛТ

БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТЭСЭЛ **7**

10 ТАНИЛЦУУЛГА

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН **2**

Батлуулсан хууль, тогтоомж

УИХ-ЫН ТОГТООЛ **1**

44 ХУУЛЬ

Ажлын хэсэг **3** удаа байгуулж, **19** удаа хуралдсан.

Тайлант хугацаанд ирсэн албан бичиг **40**, явуулсан албан бичиг **23**

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд дөрвөн хууль, Улсын Их Хурлын нэг тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ханган эцэслэн батлуулж, Байнгын хорооны долоон тогтоолыг баталж, хоёр хэлэлцүүлэг, батлагдсан хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах нэг ажлыг зохион байгууллаа.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Бүрэлдэхүүн
Улсын Их Хурлын даргын захирамж 2022.06.02, №87	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, шаардлагатай тохиолдолд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Х.Болорчулуун Гишүүд: Ц.Анандбазар Ж.Бат-Эрдэнэ Х.Булгантуяа С.Ганбаатар Г.Ганболд Н.Ганибал Ц.Даваасүрэн Л.Мөнхбаатар М.Оюунчимэг Д.Өнөрболор Ц.Туваан

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Бүрэлдэхүүн
Байнгын хорооны тогтоол 2021.01.12, №02	Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Ц.Анандбазар Гишүүд: Ж.Батжаргал Б.Бат-Эрдэнэ Д.Өнөрболор Б.Саранчимэг Ц.Туваан Г.Тэмүүлэн
Байнгын хорооны тогтоол 2021.01.12, №04	Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Г.Мөнхцэцэг Гишүүд: С.Ганбаатар Г.Ганболд Г.Дамдинням

		Н.Наранбаатар Ц.Туваан Т.Энхтүвшин
Байнгын хорооны тогтоол	Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Т.Энхтүвшин Гишүүд: Б.Бат-Эрдэнэ Г.Мөнхцэцэг Б.Саранчимэг Ц.Туваан
2022.04.13, №02		

Хяналт шалгалтын ажлын талаар

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалтын чиглэлээр Байнгын хорооны тогтоолоор гурван Ажлын хэсэг байгуулан ажиллаж, холбогдох байгууллагын үйл ажиллагаатай танилцсан.

Бусад ажлын талаар

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, мэдээлэл солилцох зорилгоор хууль тогтоомжийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг хоёр, хурал зөвлөгөөн хоёр, уулзалт, ярилцлага нэг, гадаадын зочид, төлөөлөгчтэй нэг уулзалтыг тус тус зохион байгуулав.



Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийнхэн Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймагт ажиллалаа.
2022.04.11



Байнгын хорооны дарга Х.Болорчулуун болон Байнгын хорооны гишүүд яс боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцав.

2022.04.25



Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд Хустайн нуруунд ажиллалаа.

2022.04.26



Байнгын хорооноос “Тураг гогой буюу хар галууны экологийн асуудал” сэдэвт олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

2022.05.06



Байнгын хорооноос Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн талаарх хэлэлцүүлгийг зохион байгуулав.

2022.05.09



Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд Баянзүрх дүүрэгт ажиллаж, “М Си Эс Кока Кола” ХХК болон “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн удирдлагуудтай уулзлаа.

2022.05.11



Байнгын хорооны гишүүд Дэлхийн банкны төлөөлөгчидтэй уулзаж, байгаль орчин, хунс, хөдөө аж ахуйн хамтын ажиллагааны талаар санал солилцов.

2022.05.18

ГУРАВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРОО



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Г.ДАМДИННЯМ



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2022 оны хаврын хаврын чуулганы хугацаанд



19 ГИШҮҮН

5

удаа

ХУРАЛДААН

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ (Давхардсан тоогоор) **10**

4 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ **1**

1 ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ

БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ **4**

3 САНАЛ, ДҮГНЭЛТ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН **1**

Батлуулсан хууль, тогтоомж

БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ **4**

Ажлын хэсэг **1** удаа байгуулж, **9** удаа хуралдсан.

Тайлант хугацаанд ирсэн албан бичиг **20**, явуулсан албан бичиг **32**

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд таван удаа хуралдаж, давхардсан тоогоор 10 асуудлыг хэлэлцэн шийдвэрлүүллээ. Түүнчлэн Боловсролын багц хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийн хүрээнд 135 зарчмын зөрүүтэй саналаар санал хураалгав.

Улсын Их Хурлын даргын захирамжаар болон Байнгын хорооны тогтоолоор хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий 12 ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг:

Улсын Их Хурлын даргын 2021 оны 58 дугаар захирамжаар Боловсролын багц хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий долоон салбар ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Бүрэлдэхүүн
Улсын Их Хурлын даргын захирамж 2021.07.27, №58	Ерөнхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Ц.Мөнх-Оргил Гишүүд: Ё.Баатарбилэг Х.Ганхуяг Г.Дамдинням Ц.Мөнхцэцэг Ч.Ундрам Т.Энхтүвшин
	Боловсролын ерөнхий хуулийн төслийн ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Ё.Баатарбилэг Гишүүд: Ш.Адьяаа Г.Амартүвшин Б.Баярсайхан Х.Ганхуяг Г.Тэмүүлэн Ч.Ундрам Т.Энхтүвшин

	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн төслийн	Ажлын хэсгийн ахлагч: Г.Дамдинням Гишүүд: Г.Амартүвшин Х.Булгантуяа Х.Ганхуяг Б.Пүрэвдорж Ч.Ундрэм
	Дээд боловсролын тухай хуулийн төслийн	Ажлын хэсгийн ахлагч: Ч.Ундрэм Гишүүд: А.Адъяасүрэн Г.Амартүвшин Г.Ганболд Х.Ганхуяг Г.Дамдинням Ж.Сүхбаатар
	Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн	Ажлын хэсгийн ахлагч: Ц.Мөнхцэцэг Гишүүд: А.Адъяасүрэн Ч.Ундрэм Ж.Чинбүрэн Т.Энхтүвшин
	Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төслийн	Ажлын хэсгийн ахлагч: Т.Энхтүвшин Гишүүд: П.Анужин Г.Мөнхцэцэг Д.Сарангэрэл Н.Учрал С.Чинзориг Ж.Чинбүрэн
	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн төслийн	Ажлын хэсгийн ахлагч: Х.Ганхуяг Гишүүд: Б.Жаргалмаа Ч.Ундрэм С.Чинзориг

Хяналт шалгалтын ажлын талаар

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалтын чиглэлээр Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан дөрвөн ажлын хэсэг ажиллаж, холбогдох таван байгууллагын үйл ажиллагаатай танилцсан.

Бусад ажлын талаар

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, мэдээлэл солилцох зорилгоор хууль тогтоомжийн таван төслийн талаарх таван уулзалт, ярилцлага, нэг хурал зөвлөгөөн, хоёр хэлэлцүүлгийг зохион байгуулж ажиллалаа.

Тухайлбал, Дээд боловсролын тухай болон Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хүрээнд Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Дотоод хэргийн их сургууль, Үндэсний тагнуулын академийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсны зэрэгцээ Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын санаачилсан “Монголоо мандууль” аяны хүрээнд Төрийн байгуулалтын байнгын хороотой хамтран “Нийгмийг соён гэгээрүүлэхэд шинжлэх ухааны үүрэг, оролцоо, шийдэл, гарцууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурал болон “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн төсөл болон техникийн боловсрол” сэдэвт хэлэлцүүлгийг Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран зохион байгуулсан.

Мөн Байнгын хорооны дарга Г.Дамдинням Монгол Улсын Боловсролын их сургуулиас эрхлэн явуулдаг «Edu Talk» подкастын зочноор уригдан оролцож, боловсролын салбарын шинэчлэл, Боловсролын багц хуулийн талаар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Д.Сүнжидтэй Боловсролын багц хуулийн төслийн хүрээнд хүний эрхийн асуудлаар уулзалт зохион байгуулж, санал бодлоо солилцов.

Түүнчлэн Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Байнгын хорооны дарга Г.Дамдинням нар боловсрол, соёлын салбарын төрийн үйлчилгээний ажилтнууд болон НҮБ-ын Хүүхдийн сангийн суурин төлөөлөгч Эваристе Коуасси-Комлан, ахлах зөвлөх Б.Цогтбаатар нартай албан уулзалт хийлээ.

Байнгын хорооноос Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн төслийг танилцуулах уулзалтыг Боловсрол, шинжлэх ухааны яам, олон улсын байгууллагын төлөөлөл, төрийн болон хувийн өмчийн Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв, ажил олгогч, хувийн хэвшлийнхний оролцоотой зохион байгуулав.



Байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороотой хамтран “Нийгмийг соён гэгээрүүлэхэд шинжлэх ухааны үүрэг оролцоо, шийдэл гарц” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав. 2022.03.28



Байнгын хорооны тогтоолоор байгуулсан Ажлын хэсгийн гишүүд Хүүхэд хамгааллын харцу үйлчилгээ, түр хамгаалах байр болон Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай танилцав. 2022.05.25



Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан Ажлын хэсгийн гишүүд нийслэлийн ерөнхий боловсролын 75 дугаар сургууль болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд ажиллалаа. 2022.04.22



Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг ажлын хэсгийн ахлагч Б.Баярсайхан Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага болон Монгол Улсын хүүхэдлэйн театрын үйл ажиллагаатай танилцлаа. 2022.07.05

ДӨРӨВ. ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРОО



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Б.БАТ-ЭРДЭНЭ



ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд



10 ГИШҮҮН

4

удаа

ХУРАЛДААН

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ (Давхардсан тоогоор)

6

1

БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТӨСӨЛ

ХУУЛИЙН ТӨСӨЛ

7

5

САНАЛ, ДҮГНЭЛТ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

1

2

ТАНИЛЦУУЛГА

Батлуулсан хууль, тогтоомж

БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

1

Ажлын хэсэг 1 удаа байгуулж, 2 удаа хуралдсан.

Тайлант хугацаанд ирсэн албан бичиг 6, явуулсан албан бичиг 5

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат, Ё.Баатарбилэг, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан нарын гишүүдээс өргөн мэдүүлсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, уг хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны тогтоолоор байгуулан ажиллаж байна.

Мөн тус Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2021 оны биелэлт, Монгол Улсын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилт, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж энэ талаарх санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлэв.

Бусад ажлын талаар

Ээлжит чуулганы хугацаанд Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд “Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2021 оны 105 дугаар тогтоолын талаар олон нийтэд цахимаар болон бусад хэлбэрээр танилцуулах ажил зохион байгуулсан.

Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Төрийн байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн зөвлөлүүдийг чадавхжуулах чиглэлээр Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Төрийн албаны ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх нь” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулж, зургаан яам, дөрвөн агентлаг, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хүний нөөц, Ёс зүйн зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг оролцуулан зохион байгууллаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т заасан эрхлэх асуудлын хүрээнд чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн ирцийн мэдээг олон нийтэд танилцуулав.



Байнгын хорооны дарга, Улсын Их Хурал дахь Монгол-Кубын парламентын бүлгийн дарга Б.Бат-Эрдэнэ Бүгд Найрамдах Куба Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд ноён Хорхе Альберто Феррер Родригесийг хүлээн авч уулзлаа. 2022.03.31



Байнгын хороо Төрийн албаны зөвлөл, Сангийн яамтай хамтран “Ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав. 2022.05.26



Байнгын хороо, Төрийн албаны зөвлөл хамтран “Ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгууллаа. 2022.06.13

ТАВ. ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Н.УЧРАЛ



ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд



12 ГИШҮҮН

3

удаа

ХУРАЛДААН

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

6

3

САНАЛ, ДҮГНЭЛТ

ХУУЛИЙН ТӨСӨЛ

4

2

ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

2

Тайлант хугацаанд ирсэн албан бичиг **8**, явуулсан албан бичиг **0**

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Инновац, цахим бодлогын байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд гурван удаа хуралдаж, нийт зургаан асуудлын хүрээнд дөрвөн хуулийн төсөл, Улсын Их Хурлын хоёр тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлүүлээ.

Хяналт шалгалтын ажлын талаар

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалтын чиглэлээр Байнгын хорооны тогтоолоор нэг ажлын хэсэг ажиллуулж, холбогдох гурван байгууллагын үйл ажиллагаатай танилцав.

Бусад ажлын талаар

Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээлэл солилцох зорилгоор хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх нэг хэлэлцүүлэг, 10 уулзалт, ярилцлага, таван сургалт, семинарыг зохион байгуулж ажиллалаа.

Тухайлбал, Байнгын хорооноос төрийн албаны мэдээллийн технологийн асуудал хариуцсан 200 гаруй албан хаагчдыг оролцуулсан “Цахим хөгжлийг дэмжих багц хуулиуд болох Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтэд анхаарах асуудал” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Мөн төрийн албаны шинэтгэлийн үйл явц, тулгарч буй сорилтын шийдэл гарцын талаар Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Н.Учрал, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг болон Улсын Их Хурлын Тамгын газрын холбогдох ажилтнуудтай уулзалт хийсэн.

Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Байнгын хорооны дарга Н.Учрал нар тоон гарын үсгээ иргэний үнэмлэх дээрээ авч, тоон гарын үсгийн ач холбогдлын талаар санал солилцсоны зэрэгцээ Байнгын хорооны дарга жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Инновацын 7 хоног – 2022” арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд оролцов.

Түүнчлэн Байнгын хорооны дарга Н.Учрал БНСУ-ын Дижитал байгууллагын холбооны төлөөлөлтэй, мөн АНУ-ын кибер аюулгүй байдлаар хангагдсан сонгууль программ хангамжийн шийдэл, Засгийн газарт зориулагдсан цахим систем технологийн шийдлээр дэлхийд тэргүүлэгч компанийн төлөөлөлтэй, эрүүл мэндийн салбарын үйлчилгээнд технологи нэвтрүүлэн “data analyze” хийдэг байгууллагын төлөөллийг хүлээн авч уулзав.

Байнгын хорооноос Мэдээлэл, технологийн үндэсний паркийн удирдлагатай уулзалт зохион байгуулсаны зэрэгцээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан төрийн байгууллагын мэдээллийн технологийн асуудал хариуцсан албан тушаалтнуудад холбогдох журмын танилцуулга Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран дөрвөн удаагийн сургалтыг зохион байгуулсан.



Байнгын хорооны дарга Н.Учрал болон Эрүүл мэндийн салбар дахь цахим шилжилттэй холбоотой хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд Улсын гуравдугаар төв эмнэлэг, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвүүдэд ажиллав. 2022.04.04



Байнгын хорооноос “Цахим хөгжлийг дэмжих хуулиудын хэрэгжилтэд анхаарах асуудал” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. 2022.05.10



Байнгын хорооны даргын дэргэд “Хилийн чанад дахь монголчуудын технологийн зөвлөл”-ийг байгуулав. 2022.07.04

ЗУРГАА. НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО



НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
М.ОЮУНЧИМЭГ



17 ГИШҮҮН

11
удаа

ХУРАЛДААН

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ (давхардсан тоогоор) 35

5 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН

ХУУЛИЙН ТЭСӨЛ 15

2 ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТЭСӨЛ 4

2 АЛБАН ТУШААЛТНЫГ ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ

БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТЭСӨЛ 17

1 ТАНИЛЦУУЛГА

САНАЛ, ДҮГНЭЛТ 15

16 ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛ

Батлуулсан хууль, тогтоол

хууль 2

2 УИХ-ЫН ТОГТООЛ

Ажлын хэсэг 4 удаа байгуулж, 7 удаа хуралдсан.

Тайлант хугацаанд ирсэн албан бичиг 60, явуулсан албан бичиг 63

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийн таван санал, дүгнэлт, анхны хэлэлцүүлгийн таван санал, дүгнэлт, эцсийн хэлэлцүүлгийн нэг танилцуулгыг бэлтгэж холбогдох Байнгын болон дэд хороонд хүргүүлж, ажлын хэсгийн хоёр танилцуулгыг бэлтгэж, Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгийн шатанд зарчмын зөрүүтэй 13 саналын томьёолол, эцсийн хэлэлцүүлгийн шатанд зарчмын зөрүүтэй гурван саналын томьёололыг тус тус бэлтгэн төслийг эцэслэн батлах бэлтгэл ханган ажиллалаа.

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Бүрэлдэхүүн
Байнгын хорооны тогтоол 2022.04.12, №09	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Б.Баярсайхан Гишүүд: С.Ганбаатар Б.Жаргалмаа С.Одонтуяа М.Оюунчимэг Б.Саранчимэг Ц.Туваан
Байнгын хорооны тогтоол 2022.04.20, №10	Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын таван гишүүнээс 2021.04.29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: С.Чинзориг Гишүүд: С.Ганбаатар Ц.Идэрбат Ц.Сандаг-Очир М.Оюунчимэг Ц.Туваан
Байнгын хорооны тогтоол 2022.05.10, №12	Эрүүл мэндийн тухай, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд эх, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: П.Анужин Гишүүд: Б.Бейсен Б.Жаргалмаа С.Одонтуяа Ц.Туваан

Байнгын хорооны тогтоол 2022.05.15, №17	“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.1.3, 5.1.4, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтын 4.2.10 дахь заалтын хүрээнд эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн харилцааны бүх шатанд олон талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлж, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлсэн эсэхийг хянан шалгах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: С.Ганбаатар Гишүүд: М.Оюунчимэг Д.Сарангэрэл Ц.Туваан С.Чинзориг Ч.Ундрам
--	---	--

Хяналт шалгалтын ажлын талаар

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалтын чиглэлээр Байнгын хорооны тогтоолоор гурван ажлын хэсэг, Хяналт шалгалтын нэг түр хороо байгуулж, холбогдох 18 байгууллагын үйл ажиллагаатай танилцлаа.

Ээлжит чуулганы хугацаанд хяналт шалгалтын чиглэлээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагч болон ажил олгогчийг төлөөлсөн гишүүнийг томилохтой холбогдуулан “Нэр дэвшигчийн сонсгол”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг томилохтой холбогдуулан “Нэр дэвшигчийн сонсгол”, Монгол Улсын иргэд, хүүхэд багачуудын эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурах, ажиллах эрхийг хангах зорилгоор Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг гурван удаа зохион байгуулсан.

Бусад ажлын талаар

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, мэдээлэл солилцох зорилгоор хоёр хууль тогтоомжийн төслийн талаарх олон нийтийн гурван хэлэлцүүлэг, найман уулзалт, ярилцлага, нэг сургалт, семинар, гадаадын зочид, төлөөлөгчтэй хийсэн хоёр уулзалтыг зохион байгуулав.



Байнгын хорооны дарга М.Оюунчимэг болон Байнгын хорооны гишүүд “Сүрьеэгээс сэргийлэх, сүрьеэг эрт илрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх нь” сэдэвт зөвлөгөөнд оролцов.
2022.03.21



Ахмад настны тухай, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, ахмад настны асрамжийн газрын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд Геронтологийн үндэсний төвийн барилга, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын асуудлаар холбогдох талуудын албан тушаалтнуудтай уулзлаа.
2022.03.28



Байнгын хорооноос Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогч болон даатгуулагчийг төлөөлсөн гишүүний нэр дэвшигчийн сонголыг зохион байгууллаа.
2022.04.18



Байнгын хорооноос Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулав.
2022.04.18



Эрүүл мэндийн салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээс “Цусны донорын тухай болон Эрхтэн, эд, эс ишлжүүлэн суулгах эмчилгээний тухай хуулийн төслийн талаарх хэлэлцүүлэг”-ийг зохион байгуулав.
2022.05.05



Байнгын хорооны дарга М.Оюунчимэг монголын парламентыг төлөөлж Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Францын тамхины эсрэг холбоо, Тамхигүй хүүхдүүд олон улсын байгууллагаас “Тамхины үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө, тамхи үйлдвэрлэгчдийн маркетинг, түүнтэй тэмцэх нь, тамхины ишинээс үүсэх бохирдол” сэдвийн дор зохион байгуулсан салбар хуралдаанд оролцов. 2022.05.26



Байнгын хорооны тогтоолоор байгуулсан Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд эх, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв болон “Гурван гал” нэгдсэн эмнэлэгт ажиллалаа. 2022.06.23



Байнгын хорооны дарга М.Оюунчимэг тархины саажилттай хүүхэдтэй эцэг, эхчүүдийн төлөөлөлтэй уулзлаа. 2022.06.08



Байнгын хорооноос Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг зохион байгууллаа. 2022.06.27

ДОЛОО. ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ж.МӨНХБАТ



ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд



19 ГИШҮҮН

15
удаа

ХУРАЛДААН

Батлуулсан хууль, тогтоол

ХУУЛЬ **139**

8

УИХ-ЫН ТОГТООЛ

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ (Давхардсан тоогоор) **32**

1 ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

ХУУЛИЙН ТӨСӨЛ **138**

26 САНАЛ, ДҮГНЭЛТ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ **5**

218 ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТӨСӨЛ **10**

9 ТАНИЛЦУУЛГА

ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН **1**

Ажлын хэсэг **6** удаа байгуулж, **43** удаа хуралдсан.

Тайлант хугацаанд ирсэн албан бичиг **10**, явуулсан албан бичиг **10**

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах 139 хууль, Улсын Их Хурлын найман тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ханган эцэслэн батлуулж, Байнгын хорооны 10 тогтоолыг баталж, холбогдох байгууллагуудад хуралдааны тэмдэглэлээр гурван үүрэг, даалгавар өгч, гурван хэлэлцүүлэг, батлагдсан хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах хоёр ажлыг зохион байгуулсан.

Улсын Их Хурлын даргын захирамжаар болон Байнгын хорооны тогтоолоор хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий зургаан ажлын хэсгийг байгуулан ажилласнаас нэг ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг:

<i>Шийдвэр</i>	<i>Ажлын хэсгийн нэр</i>	<i>Бүрэлдэхүүн</i>
Улсын Их Хурлын даргын захирамж 2022.03.25, №43	Засгийн газраас 2022.03.11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Н.Энхболд Гишүүд: С.Ганбаатар А.Адъяасүрэн Ж.Ганбаатар Т.Доржханд Б.Жаргалмаа Ц.Мөнх-Оргил Б.Пүрэвдорж Б.Энхбаяр Ц.Цэрэнпунцаг
Улсын Их Хурлын даргын захирамж 2022.05.27, №80	Засгийн газраас 2022.05.04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуунаас 2019.05.03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгтгэн Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Ж.Мөнхбатаар Гишүүд: Ш.Адъяаа А.Адъяасүрэн Ж.Батжаргал Ж.Батсуурь Б.Бат-Эрдэнэ Ж.Бат-Эрдэнэ Г.Ганболд Ц.Даваасүрэн Ц.Сандаг-Очир Ц.Туваан Г.Тэмүүлэн С.Чинзориг

Улсын Их Хурлын даргын захирамж 2022.06.02, №88	Засгийн газраас 2022.04.14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын гурван гишүүнээс 2021.05.21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэгээс 2021.07.05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгтгэн Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Н.Энхболд Гишүүд: Ц.Даваасүрэн Ц.Идэрбат Ц.Мөнхцэцэг Н.Наранбаатар С.Одонтуяа С.Чинзориг Б.Энхбаяр Т.Энхтүвшин
---	---	--

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг:

<i>Шийдвэр</i>	<i>Ажлын хэсгийн нэр</i>	<i>Бүрэлдэхүүн</i>
Байнгын хорооны тогтоол 2022.04.20, №07	Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Ё.Баатарбилэг Гишүүд: Г.Ганболд Ц.Мөнх-Оргил Б.Пүрэвдорж Н.Энхболд
Байнгын хорооны тогтоол 2022.05.18, №11	Сонгуулийн тогтолцоо болон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар улс төрийн намууд, түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын саналыг дэмжсэн 100 000 иргэдээс ирүүлсэн санал, шаардлагыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Ж.Мөнхбатаар Гишүүд: А.Адъяасүрэн С.Бямбацогт Ц.Мөнх-Оргил Ц.Мөнхцэцэг М.Оюунчимэг Б.Пүрэвдорж Д.Тогтохсүрэн Н.Энхболд

Байнгын хорооны тогтоол 2022.06.13 №13	Байнгын хорооны 2022 оны 11 дүгээр тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлт, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар иргэдээс ирүүлсэн санал, улс төрийн намуудын “Тунхаг бичиг”, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн шийдвэрийн талаар судалж, олон нийтийн санаа бодлыг тандан судлах сэдвийн хүрээг тодорхойлох, хэлэлцүүлгийн хугацааг тогтоох болон зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: С.Бямбацогт Гишүүд: А.Адъяасүрэн Г.Ганболд Ц.Мөнх-Оргил М.Оюунчимэг
--	--	---

Хяналт шалгалтын ажлын талаар

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалтын чиглэлээр Байнгын хорооны тогтоолоор нэг ажлын хэсэг байгуулан ажиллуулж, холбогдох нэг байгууллагын үйл ажиллагаатай танилцсан.

Бусад ажлын талаар

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, мэдээлэл солилцох зорилгоор хууль тогтоомжийн төслийн талаарх олон нийтийн гурван хэлэлцүүлэг, гурван хурал, зөвлөгөөн, есөн уулзалт, ярилцлага, гурван удаагийн сургалт, семинар, гадаадын зочид, төлөөлөгчтэй таван уулзалтыг зохион байгуулсан.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг баталсны 10 жилийн ойн хүрээнд Төрийн байгуулалтын байнгын хороо, Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хороо хамтран 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдөр “Хуулийн хэрэгжилт, ач холбогдол, цаашдын үр нөлөө” сэдэвт онол практикийн бага хурлыг зохион байгуулсан.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор байгуулагдсан Сонгуулийн тогтолцоо болон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар улс төрийн намууд, түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын саналыг дэмжсэн 100 000 иргэдээс ирүүлсэн санал, шаардлагыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээс, эрдэмтэн, судлаач, хуульчид, улс төрийн намуудын удирдлагууд, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүд, Ардчилсан Үндсэн хууль тогтоогч нарын холбооны төлөөллийг оролцуулан “Сонгуулийн тогтолцоо болон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт” сэдэвт цуврал хэлэлцүүлэг зохион байгуулав.



Байнгын хороо, Засгийн газар, Жендэрийн үндэсний хороотой хамтран “Хуулийн хэрэгжилт, ач холбогдол, цаашидын үр нөлөө” сэдэвт онол практикийн бага хурлыг Төрийн ордонд зохион байгууллаа. 2022.03.29




Байнгын хорооны дарга Ж.Мөнхбат Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн газрын Сонгууль ажиглах тусгай хорооны тэргүүн Лолита Чигане, сонгуулийн зөвлөх Кира Кастальдо нарыг хүлээн авч уулзав. 2022.04.07



Байнгын хорооны дарга, УИХ дахь Монгол-БНСУ-ын парламентын бүлгийн дарга Ж.Мөнхбат Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн гишүүн Ким Ён Жү тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. 2022.05.06



Байнгын хорооноос “Сонгуулийн тогтолцоо болон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт” асуудлаар цуврал хэлэлцүүлгийг зохион байгууллаа. 2022.05.23



Байнгын хорооны дарга Ж.Мөнхбат Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандыг хүлээн авч уулзан, албан шаардлагынх нь харигу нь өгөв. 2022.05.16

НАЙМ. ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ч.ХҮРЭЛБААТАР



ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд



19 ГИШҮҮН

14

удаа

ХУРАЛДААН

Батлуулсан хууль, тогтоол

ХУУЛЬ **18**

6 УИХ-ЫН ТОГТООЛ

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ (Давхардсан тоогоор) **37**

8 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН

ХУУЛИЙН ТӨСӨЛ **22**

24 САНАЛ, ДҮГНЭЛТ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ **7**

6 ТАНИЛЦУУЛГА

БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТӨСӨЛ **4**

86 ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛ

ЗӨВШИЛЦӨХ **5**

Ажлын хэсэг **1** удаа байгуулж, **5** удаа хуралдсан.

Тайлант хугацаанд ирсэн албан бичиг **132**, явуулсан албан бичиг **15**

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд 18 хууль, Улсын Их Хурлын тогтоолын зургаан төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ханган эцэслэн батлуулж, Байнгын хорооны дөрвөн тогтоолыг баталж, холбогдох байгууллагуудад хуралдааны тэмдэглэлээр нэг үүрэг, даалгавар өгч ажилласан.

Байнгын хорооны тогтоолоор хууль тогтоомжийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий хоёр ажлын хэсгийг байгуулан ажилласнаас нэг ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна.

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг

<i>Шийдвэр</i>	<i>Ажлын хэсгийн нэр</i>	<i>Бүрэлдэхүүн</i>
Байнгын хорооны тогтоол 2020.11.04, №05	Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Х.Булгантуяа Гишүүд: Н.Алтанхуяг Г.Амартүвшин Х.Баделхан Ж.Батсуурь Г.Тэмүүлэн Б.Чойжилсүрэн

Ээлжит чуулганы хугацаанд Байнгын хорооноос Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2021 оны биелэлт, Монгол Улсын Засгийн газрын 2022-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийн талаар хэлэлцсэн санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд, Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд, “Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтээ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хүргүүлж ажиллав. Мөн Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрүүдийн төсөл, Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Хөтөлбөрийн хэлэлцээрийн төсөл Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийн төсөл, “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-д нэгдэн орох тухай, Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцсэн санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд тус тус хүргүүлсэн.

Хяналт шалгалтын ажлын талаар

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалтын чиглэлээр Төрийн аудитын байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайлан, Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”, “МҮОНРТ-ийн 2017-2020 оны улсын төсвийн санхүүжилтийн хэрэгжилт, үр нөлөө”, “Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүн”, “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт, үр нөлөө”-ний аудитын тайлан болон “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд барилгын материалын үнийн өсөлтийг тооцож, магадлал хийж, нэгдсэн дүгнэлтээр баталгаажуулсан тайланг хэлэлцүүлсэн.



Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомслоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах, үүсээд буй хямралт нөхцөл байдлыг шийдвэрлэх бодлогын шийдэл гаргах, хэмнэлтийн горимд шилжих чиглэлээр төсөвт тодотгол хийх холбогдох хууль, тогтоол, хөтөлбөрт өөрчлөлт оруулах төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд цаг үеийн асуудлаар мэдээлэл хийлээ. 2022.04.08



Байнгын хороо Монгол Улсын 2022 оны төсвийн тодотголын талаарх төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийв. 2022.04.28



Монгол Улсын Их Хурал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хамтран “Монгол Улсын төлбөрийн тэнцлийг сайжруулах нь өрийн удирдлагын үндсэн зарчим” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. 2022.06.28

ЕС. ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО



ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Б.ЧОЙЖИЛСҮРЭН



19 ГИШҮҮН

9

удаа

ХУРАЛДААН

1

удаа

хамтарсан
ХУРАЛДААН

Батлуулсан хууль, тогтоол

ХУУЛЬ

14

3

УИХ-ЫН ТОГТООЛ

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ (Давхардсан тоогоор) 22

1 ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

ХУУЛИЙН ТЭСЭЛ 16

11 САНАЛ, ДҮГНЭЛТ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТЭСЭЛ 7

85 ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТЭСЭЛ 6

2 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН

Ажлын хэсэг 4 удаа байгуулж, 42 удаа хуралдсан

Тайлант хугацаанд ирсэн албан бичиг 35, явуулсан албан бичиг 42

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Ээлжит чуулганы хугацаанд Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд 14 хууль, Улсын Их Хурлын гурван тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ханган эцэслэн батлуулж, Байнгын хорооны зургаан тогтоолыг баталж, хоёр хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Улсын Их Хурлын даргын захирамжаар болон Байнгын хорооны тогтоолоор хууль тогтоомжийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий хоёр ажлын хэсгийг байгуулж, Улсын Их Хурлын даргын захирамжаар 2021 онд байгуулагдсан нэг ажлын хэсэг, нийт гурван ажлын хэсэг ажилласан бөгөөд нэг ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг

<i>Шийдвэр</i>	<i>Ажлын хэсгийн нэр</i>	<i>Бүрэлдэхүүн</i>
Улсын Их Хурлын даргын захирамж 2021.10.18, №80	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Ж.Бат-Эрдэнэ Гишүүд: Т.Аубакир Ж.Батжаргал Г.Тэмүүлэн С.Чинзориг
Улсын Их Хурлын даргын захирамж 2022.02.11, №23	Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээний хүрээнд ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, боловсронгуй болгох Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Ж.Бат-Эрдэнэ Гишүүд: Ж.Батжаргал Л.Мөнхбаатар Г.Тэмүүлэн Ц.Цэрэнпунцаг

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг

<i>Шийдвэр</i>	<i>Ажлын хэсгийн нэр</i>	<i>Бүрэлдэхүүн</i>
Байнгын хорооны тогтоол 2022.04.12, №03, 04	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Г.Тэмүүлэн Гишүүд: Ж.Батжаргал Ж.Бат-Эрдэнэ Э.Батшугар С.Ганбаатар Г.Ганболд Л.Мөнхбаатар О.Цогтгэрэл Т.Энхтүвшин

Хяналт шалгалтын ажлын талаар

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалтын чиглэлээр Хөнгөн үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны тогтоолоор байгуулагдсан Ажлын хэсэг Төв аймгийн Аргалант, Лүн, Заамар, Цээл, Сүмбэр, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр сумд болон Булган аймгийн Баяннуур, Дашинчилэн, Бүрэгхангай сум, Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сум, Дархан-Уул аймагт ажиллан орон нутгийн иргэдийн саналыг сонсож, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8.8-д заасны дагуу малыг эрүүлжүүлэх, сүүний үйлдвэрлэлийн салбарт төрөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх асуудлаар “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулсан.

Бусад ажлын талаар

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, мэдээлэл солилцох зорилгоор хуулийн төслийн талаар нэг хэлэлцүүлэг, бусад асуудлаар нэг хэлэлцүүлэг, нийт хоёр хэлэлцүүлэг, таван уулзалт, ярилцлагыг зохион байгуулж ажиллав.



Байнгын хороо, хуулийн төсөл санаачлагч УИХ-ын гишүүд хамтран Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг зохион байгууллаа. 2022.03.14



Байнгын хорооны хуралдаанаар Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээлэл сонсов. 2022.04.27



Байнгын хорооноос “Эрүүл мал-Чанартай сүү үйлдвэрлэл” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. 2022.05.12

АРАВ. ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
С.БЯМБАЦОГТ



ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд



19 ГИШҮҮН

18

удаа

ХУРАЛДААН

Батлуулсан хууль, тогтоол

ХУУЛЬ **61**

9

УИХ-ЫН ТОГТООЛ

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ (Давхардсан тоогоор) **48**

2 ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

ХУУЛИЙН ТЭСӨЛ **15**

1 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТЭСӨЛ **7**

18 САНАЛ, ДҮГНЭЛТ

БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТЭСӨЛ **13**

2 ТАНИЛЦУУЛГА

АЛБАН ТУШААЛТНЫГ ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ **5**

122 ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛ

Ажлын хэсэг **4** удаа байгуулж, **42** удаа хуралдсан.

Тайлант хугацаанд ирсэн албан бичиг **50**, явуулсан албан бичиг **36**

Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Хууль зүйн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын эрх зүйн бодлого, хүний эрх, эрх чөлөө, түүний баталгаа, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогын хүрээнд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар Байнгын, дэд хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх, тодорхой асуудлаар санал, дүгнэлт гаргах, Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх харьяа байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх, үүрэг, чиглэл өгөх, Улсын Их Хурлын гишүүд болон Байнгын хорооны гишүүдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан.

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд 61 хууль, Улсын Их Хурлын есөн тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ханган эцэслэн батлуулж, Байнгын хорооны 13 тогтоолыг баталж, гурван нийтийн сонгол, таван хэлэлцүүлэг, батлагдсан хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг гурван удаа зохион байгууллаа.

Байнгын хорооны тогтоолоор хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий дөрвөн ажлын хэсгийг байгуулан ажилласнаас дараах гурван ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна.

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг

<i>Шийдвэр</i>	<i>Ажлын хэсгийн нэр</i>	<i>Бүрэлдэхүүн</i>
Байнгын хорооны тогтоол 2022.03.30, №06	Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Л.Мөнхбаатар Гишүүд: С.Бямбацогт Б.Дэлгэрсайхан Б.Жаргалмаа Ц.Мөнх-Оргил Ц.Сэргэлэн
Байнгын хорооны тогтоол 2022.06.17, №10	Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Ж.Сүхбаатар Гишүүд: С.Бямбацогт Х.Ганхуяг Б.Пүрэвдорж Ц.Сэргэлэн Ц.Мөнхцэцэг

Байнгын хорооны тогтоол 2022.06.29, №13	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Л.Мөнхбаатар Гишүүд: Д.Ганбат Ж.Мөнхбат Ц.Мөнхцэцэг С.Одонтуяа Ш.Раднаасэд Ч.Хүрэлбаатар С.Чинзориг Д.Цогтбаатар Б.Энх-Амгалан Б.Энхбаяр
---	---	--

Тус Байнгын хорооноос Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж энэ талаарх, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж энэ талаарх санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд, Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын протоколд (Кигалийн) оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг зөвшилцөх, хэлэлцүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд тус тус хүргүүлсэн.

Хяналт шалгалтын ажлын талаар

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалтын чиглэлээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд нэр дэвшигчидтэй хийх сонсголыг, мөн Улсын дээд шүүхийн нэр дэвшигчидтэй хийх нэр дэвшигчийн сонсголын товйг тогтоож, сонсголыг тус тус зохион байгуулжээ.

Бусад ажлын талаар

Ээлжит чуулганы хугацаанд Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд архидан согтуурахтай тэмцэх, соён гэгээрүүлэх Монголын эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэгийн үйл ажиллагаатай танилцаж, хуулийн төслийн талаар санал солилцсоны зэрэгцээ

Байнгын хорооны гишүүд Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагаатай танилцав.

Түүнчлэн хууль тогтоомжийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, мэдээлэл солилцох зорилгоор Хууль зүйн байнгын хорооноос Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгүүдтэй хамтран тус тус хэлэлцүүлэг зохион байгуулсан.



Байнгын хорооноос Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулав. 2022.04.20



Байнгын хорооноос Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд нэр дэвшигчтэй хийх томилгооны сонголыг зохион байгууллаа. 2022.05.04



Байнгын хорооноос Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар нээлттэй хэлэлцүүлэг хийв. 2022.06.16



Байнгын хорооноос Улсын дээд шүүхийн нэр дэвшигчтэй хийх сонсголыг зохион байгууллаа. 2022.07.04



Байнгын хорооноос 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажил, батлуулсан хуулийн гол зохицуулалтын талаар хэвлэлийн бага хурлыг хийв. 2022.07.08

АРВАН НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО



ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ж.ГАНБААТАР



19 ГИШҮҮН

19

удаа

ХУРАЛДААН

1

удаа

ХАМТАРСАН
ХУРАЛДААН

Батлуулсан хууль, тогтоол

хууль **97**

15 УИХ-ЫН ТОГТООЛ

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ (Давхардсан тоогоор) **65**

4 ЗӨВШИЛЦӨХ АСУУДАЛ

ХУУЛИЙН ТЭСЭЛ **30**

2 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТЭСЭЛ **16**

36 САНАЛ, ДҮГНЭЛТ

БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТЭСЭЛ **10**

11 ТАНИЛЦУУЛГА

ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛ **342**

Ажлын хэсэг **6** удаа байгуулж, **19** удаа хуралдсан.

Тайлант хугацаанд ирсэн албан бичиг **36**, явуулсан албан бичиг **2**

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах 97 хууль, Улсын Их Хурлын 15 тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлуулж, Байнгын хорооны 10 тогтоолыг баталж, нэг нийтийн сонсгол, хоёр хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Улсын Их Хурлын даргын захирамжаар болон Байнгын хорооны тогтоолоор хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий зургаан ажлын хэсгийг байгуулан ажилласнаас таван ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Бүрэлдэхүүн
Улсын Их Хурлын даргын захирамж 2022.05.20, №74	“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: С.Чинзориг Гишүүд: Ж.Батжаргал Б.Баттөмөр С.Бямбацогт Д.Сарангэрэл
Улсын Их Хурлын даргын захирамж 2022.04.08, №49	Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Б.Баттөмөр Гишүүд: Ц.Мөнх-Оргил Ц.Мөнхцэцэг Б.Пүрэвдорж Н.Энхболд

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Бүрэлдэхүүн
Байнгын хорооны тогтоол 2022.05.31, №06	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: С.Чинзориг Гишүүд: Б.Баттөмөр Ж.Бат-Эрдэнэ Х.Булгантуяа Н.Ганибал
Байнгын хорооны тогтоол 2022.05.31, №07	Хот, суурины ус хангамж, ариутгах татуурга ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: М.Оюунчимэг Гишүүд: Д.Батлут Т.Доржханд С.Чинзориг Ц.Цэрэнпунцаг

Байнгын хорооны тогтоол 2022.05.31, №09	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Ц.Цэрэнпунцаг Гишүүд: Б.Баттөмөр Д.Бат-Эрдэнэ Ж.Бат-Эрдэнэ Б.Жаргалмаа Д.Өнөрболор М.Оюунчимэг С.Чинзориг
Байнгын хорооны тогтоол 2022.06.28, №10	Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий	Ажлын хэсгийн ахлагч: Б.Энхбаяр Гишүүд: П.Анужин Т.Аубакир Д.Батлут Т.Доржханд Н.Наранбаатар Г.Тэмүүлэн

Хяналт шалгалтын ажлын талаар

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалтын чиглэлээр “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц байдал”, “Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох” зэрэг нийт Хяналт шалгалтын хоёр түр хороо байгуулж, нийтийн сонсгол нэг удаа зохион байгуулан ажиллав.

Бусад ажлын талаар

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, мэдээлэл солилцох зорилгоор хууль тогтоомжийн нэг төслийн талаарх олон нийтийн хоёр хэлэлцүүлэг, гурван удаагийн хурал, зөвлөгөөн, 45 уулзалт, ярилцлага болон гадаадын зочид, төлөөлөгчтэй нэг уулзалтыг зохион байгуулж ажиллалаа.



Хөгжлийн банкны асуудлаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” тогтоолын төслийг хэлэлцэв.
2022.04.13




Байнгын хороо Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцлээ.
2022.04.19

ГУРАВ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1.ТОДОРХОЙ АСУУДЛААР ШАЛГАН СУДЛАХ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТАЛААР



Ерөнхий хяналтын сонсгол:

Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор ерөнхий хяналтын сонсголыг Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан.

Ерөнхий хяналтын сонсголд Улсын Их Хурлын гишүүд болон тайлан, мэдээлэл хийх, тайлбар өгөхтэй холбогдуулан Засгийн газрын хэрэг эрхлэх газар, холбогдох яамд, Монголбанк, Хөгжлийн банк, Үндэсний аудитын газар, Санхүүгийн зохицуулах хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Барилгын хөгжлийн төвийн удирдах болон холбогдох албан тушаалтнууд, мөн Улсын Их Хурлын даргын 2022 оны 20 дугаар захирамжаар байгуулагдсан “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн гишүүд тус тус оролцсон. Мөн ерөнхий хяналтын сонсголд оролцох хүсэлт ирүүлсэн сонсголын дөрвөн ажиглагч, хэвлэл мэдээллийн 14 байгууллага, улс төрийн намуудын 11 төлөөлөл, төрийн бус байгууллагын 12 төлөөлөл, хувийн хэвшлийн 16 төлөөлөл, иргэдийн 14 төлөөлөл, нийт 130 гаруй хүн оролцлоо.

Түр хороо:

Улсын Их Хурлын 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хорооны үйл ажиллагаа үргэлжилж байна.

Хянан шалгах түр хороо:

Хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдлыг шалгах, Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсад эмийн хяналт шалгалтыг сайжруулах, эсхүл хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох талаарх саналыг Улсын Их Хуралд танилцуулах, Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоож Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороод байгуулагдан ажиллаж байна.

Үйл ажиллагаа нь дуусгавар болсон ажлын хэсгийн товч мэдээлэл:

Улсын Их Хурлын даргын захирамжаар

Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн захирамжаар байгуулж, Ажлын хэсэг Хөгжлийн банкны нөхцөл байдалтай танилцаж, банкны удирдлагуудтай уулзан удирдамжийн хүрээнд шаардлагатай тодруулга, мэдээлэл авах, шалгалтын чиглэлээр ажлын дэд хэсэг байгуулан ажиллуулах, уулзалт, ярилцлага зохион байгуулах зэргээр ажилласан. Ажлын хэсгээс Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтын үнэлгээчидтэй хамтран ажлын хэсгийн хүрээнд хийсэн нийт ажлын талаар нэгтгэн хэлэлцэхийн зэрэгцээ Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах ерөнхий хяналтын сонсголд ажлын хэсэг тайлангаа танилцуулснаар үйл ажиллагаа дуусгавар болсон.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт болон Төсвийн байнгын хорооны тогтоолоор

Байнгын хороодын 2021 оны 05 дугаар сарын 06/03 дугаар тогтоолоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын 2021 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны явц байдалтай танилцан, шалгаж, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг БШУЯ, Соёлын яам, Биеийн тамир, спортын улсын хороо, Төрийн худалдан авах ажиллагааны газруудын үйл ажиллагаа болон холбогдох зарим байгууллагын барилгын ажлын явц, төсвийн хөрөнгө оруулалтын байдалтай танилцахын зэрэгцээ барилгын материалын үнийн өсөлттэй холбоотойгоор үйлдвэрлэл эрхлэгчид болон шийдвэр гаргах эрх бүхий байгууллагуудтай хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулж, нөхцөл байдлын талаар санал солилцсон. Байнгын хороодын хамтарсан хуралдаанд Ажлын хэсгийн тайлан, тогтоолын төслийг хэлэлцүүлэхэд Байнгын хорооноос шийдвэр гаргах шаардлагагүй гэж үзсэн тул үйл ажиллагаа нь дуусгавар болсон.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоолоор

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор байгуулсан. Уг Ажлын хэсэг холбогдох байгууллагын мэдээлэл сонсох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцох, мөн ХХААХҮЯ, Мал эмнэлгийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Биокомбинат, Мал эмнэлгийн холбоо, Хэнтий, Говьсүмбэр аймгийн Хөдөө аж ахуйн газар, тус аймгийн малын эмч, малчдын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр ажилласан. Байнгын хорооны 2022 оны 04 дүгээр сарын хуралдаанаар Ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулан Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулсан. Байнгын хорооноос “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 04 дүгээр тогтоолоор Засгийн газарт чиглэл өгсөнөөр үйл ажиллагаа нь дуусгавар болов.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоолоор

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 13 дугаар тогтоолоор байгуулсан. Ажлын хэсэг БОАЖЯ-ны мэдээллийг сонсож, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Нийслэлийн Налайх дүүргийн болон Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга нартай уулзаж, нөхцөл байдалтай танилцан, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Төв

аймгуудад ажиллан холбогдох мэдээллийг сонсож, санал солилцсон. Тус Байнгын хорооны 2022 оны 05 дугаар сарын хуралдаанд Ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулж, Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд Байнгын хорооны 08 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгсөнөөр үйл ажиллагаа нь дуусгавар болсон.

Нийгмийн бодлогын байнгын хорооны тогтоолоор

Байнгын хорооны 2022 оны 01 дүгээр сарын 01 дүгээр тогтоолоор байгуулсан Ахмад настны тухай, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, Ахмад настны асрамжийн газрын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсэг ХНХЯ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын мэдээллийг сонсож, Хэнтий, Орхон, Хөвсгөл, Увс аймгуудад ажиллахаас гадна хэлэлцүүлэг зохион байгуулах, холбогдох байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж ажиллав. Тус Байнгын хорооны 2022 оны 06 дугаар сарын хуралдаанд Ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулсан бөгөөд Байнгын хорооноос 14 дүгээр тогтоолоор Засгийн газарт чиглэл өгснөөр Ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар боллоо.

Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтоолоор

Тус Байнгын хорооны 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор байгуулсан Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл, удирдлага, албан хаагчидтай уулзалт хийж, үйл ажиллагаатай танилцан МҮОНРТ-д үүсээд буй нөхцөл байдлын талаарх мэдээллийг сонсож, хугацаатай үүрэг, даалгаврыг өгсөн. Байнгын хорооны 2022 оны 04 дүгээр сарын хуралдаанд Ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулж, Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулсан. Засгийн газар болон МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлд 2022 оны 08 дугаар тогтоолоор чиглэл өгснөөр үйл ажиллагаа нь дуусгавар болсон.

Хөнгөн үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны тогтоолоор

Дэд хорооны 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээний хүрээнд малыг эрүүлжүүлэх, сүүний үйлдвэрлэлийн салбарт төрөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг “Эрүүл мал-чанартай сүү” сэдэвт хэлэлцүүлэг, уулзалтыг ҮББХ, ХХААХҮЯ-тай хамтран зохион байгуулж, Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор батлагдсан “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын

хэрэгжилттэй танилцах, иргэдийн саналыг сонсох, цаашид сүүний салбарт төрөөс олгож буй мөнгөн урамшууллын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Төв аймгийн Аргалант, Лүн, Заамар, Цээл, Сүмбэр, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр сумд болон Булган аймгийн Баяннуур, Дашинчилэн, Бүрэгхангай сум, Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сум, Дархан-Уул аймгуудад тус тус ажилласан. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулж, Байнгын хорооноос гарах тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулсан. Байнгын хорооны 2022 оны 07 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгсөнөөр ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.

Үйл ажиллагаа нь үргэлжилж байгаа зарим ажлын хэсгийн товч мэдээлэл:

Төсвийн байнгын хорооны тогтоолоор

Байнгын хорооны 2020 оны 11 дгээр сарын 04-ний өдрийн 05 дугаар тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамнаас ирүүлсэн мэдээлэл сонсож, ажлын дэд хэсэгт ажлын хэсгээс гарах санал, дүгнэлтийн төслийг боловсруулан танилцуулахыг үүрэг болгов. Төсвийн байнгын хорооны 2022 оны 06 дугаар сарын хуралдаанд Ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулсантай холбогдуулан Байнгын хорооны гишүүдээс гаргасан саналыг тусгаж санал, дүгнэлтээ дахин танилцуулахаар болсон.

Хууль зүйн байнгын хорооны тогтоолоор

Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор байгуулсан. Тус байнгын хорооны хуралдаанаар Гадаад харилцааны яам болон ХЗДХЯ-наас хариуцан хэрэгжилтийг тайлагнадаг олон улсын гэрээ, конвенцын талаар ажлын хэсгийн ахлагч Ц.Мөнх-Оргил танилцуулж, хуралдаанаас олон талт олон улсын 30 гэрээний хэрэгжилтийг Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээнд ХЗБХ-той хамтарсан хуралдаанаар хэлэлцүүлэхийг ажлын хэсэгт үүрэг болгов. Мөн 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр ХНХЯ-наас эрхлэх асуудлын хүрээний олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийн талаарх мэдээллийг ажлын хэсэгт ирүүлээд байна.

Эдийн засгийн байнгын хорооны тогтоолоор

Тус байнгын хорооны 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар тогтоолоор байгуулсан Дархан-Улаанбаатар хот хоорондын авто зам барих, ажлын явцыг эрчимжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тодорхой асуудлаар үүрэг, чиглэл өгөх үүрэг бүхий ажлын хэсэг Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажлын явцын талаар Зам, тээврийн хөгжлийн яам, МХЕГ болон төслийн зөвлөх компанийн мэдээллийг сонсож, үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар ЗТХЯ, холбогдох бусад газруудад үүрэг өгсөн төдийгүй ажлын хэсгийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэлтэй танилцав. Мөн Ажлын хэсгийн 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажлын явцын талаарх мэдээлэл сонсож, ажлын хэсгээс зам, барилгын ажлын явцыг эрчимжүүлэх талаар ЗТХЯ болон холбогдох байгууллагуудад үүрэг, чиглэл өгөөд байна. Түүнчлэн Ажлын хэсэг 07 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар авто замын үйл ажиллагааг эрчимжүүлэх, ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч компаниудын санхүүжилтийн асуудлыг хэлэлцээд Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам болон холбогдох бусад байгууллагуудад үүрэг өгөөд байна.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны тогтоолоор

Байнгын хорооны 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 03 дугаар тогтоолоор Газрын тосны салбарын хөрөнгө оруулалт, экспорт, эрэл хайгуул, ашиглалт, олборлолт, байгалийн нөхөн сэргээлтийн асуудлаар газар дээр нь ажиллаж мэдээлэл авах, тулгамдаж буй асуудлыг судлан шийдвэрлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх зорилгоор Дорнод аймгийн Тамсагбулагийн сав газарт ажиллах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Байнгын хорооны 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанд Тамсагийн сав газрын Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд үйл ажиллагаа явуулж байгаа “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон танилцуулсаны зэрэгцээ Ажлын хэсгийн тайланг танилцуулж, Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулсан. Байнгын хорооны 2022 оны 03 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгөөд байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны тогтоолоор

Байнгын хорооны 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулсан Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна” гэж заасны хэрэгжилтийг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Хан-Уул дүүргийн 75 дугаар сургууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн

55 дугаар сургууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сувиллын цэцэрлэг, яслийн 10 дугаар цогцолборын үйл ажиллагаатай танилцаж, Монгол Улсын Боловсролын их сургуулийн багш, ажилтнууд, удирдлагуудтай уулзсан. Мөн 2022 оны 06 дугаар сард Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын 3 дугаар сургууль, Улсын Тэргүүний 4 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж, санал солилцсон.

Нийгмийн бодлогын байнгын хорооны тогтоолоор

Тус Байнгын хорооны 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсэг үйл ажиллагааныхаа хүрээнд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт ажиллаж, үйл ажиллагааны тайланг сонссон. Мөн Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр, 108 төв, Завхан, Архангай, Өвөрхангай аймгуудын Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр, сургуулийн дотуур байр, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэл сонссон. Мөн Ажлын хэсэг 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага болон Хүүхэдэдэйн театрын үйл ажиллагаатай танилцлаа.


Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоолоор

Байнгын хорооны 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоолоор байгуулагдсан Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт болон ус ашиглалтын талаар хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг үйл ажиллагааныхаа хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр “Эм Си Эс Кока Кола” ХХК болон “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн хаягдал ус цэвэршүүлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцаж, цэвэршүүлсэн усыг хэрэглээнд хэрхэн бүрэн ашиглах, цэвэр усаа хэмнэх талаар санал солилцов. Ажлын хэсгээс арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцахаар төлөвлөсөн ч зарим байгууллагуудын үйл ажиллагаа зогссонтой холбоотой түр хойшлуулсан.

3.2. АСУУЛГА, АСУУЛТЫН ТАЛААР

Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад хандан 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 28 гишүүн 123 асуудлаар 20 удаа асуулга, Улсын Их Хурлын 5 гишүүн 17 асуудлаар 5 удаа асуулт тавьсан байна.

Ээлжит чуулганы хугацаанд



Улсын Их Хурлын гишүүний асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн байдал:

- 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгээс “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын боломжийг нээх болон “Монгол мал-II” арга хэмжээний хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаар” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд хандсан 20 дугаар асуулгын хариу;
- 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтоос “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлын явц, түүнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлэх бусад арга хэмжээний талаар” Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандсан 06 дугаар асуулгын хариу;
- 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагаас “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барьж байгуулахтай холбоотой авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар” Эрчим хүчний сайд Н.Тавинбэхэд хандсан 46 дугаар асуулгын хариу;
- 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Н.Учралаас “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандсан 03 дугаар асуулгын хариу;
- 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдоос “Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд хандсан 10 дугаар асуулгын хариу;
- 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгээс “Элэг бүтэн Монгол Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандсан 07 дугаар асуулгын хариуг тус тус хэлэлцсэн.

/Дэлгэрэнгүйг “Мэдээ-1” хүснэгтээс үзнэ үү/

Улсын Их Хурлын гишүүний асуултын хариуг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн байдал:

- ҮББХ-ны 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнээс “Ноос, ноолуурын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Байнгын хорооны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд хандсан асуултын хариуг хэлэлцжээ.

/Дэлгэрэнгүйг “Мэдээ-2” хүснэгтээс үзнэ үү/

3.3.МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН НЭГДСЭН ХУРАЛДААНД МЭДЭЭЛЭЛ ХИЙСЭН ТАЛААР

Ээлжит чуулганы хугацаанд нэгдсэн хуралдаанд Засгийн газраас нийт дөрвөн удаа мэдээлэл хийж, мэдээлэлтэй холбогдуулан давхардсан тоогоор Улсын Их Хурлын 21 гишүүн 85 асуулт асууж, үг хэлсэн байна.

УИХ-ын нэгдсэн хуралдаанд Засгийн газрын гишүүдийн хийсэн мэдээлэл

4

17

Байнгын хорооны хуралдаанд Засгийн газрын гишүүдийн хийсэн мэдээлэл

Үүнд:

- Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар “Газрын шинэтгэлийн бодлого, газрын харилцааны цахим системийн талаар”;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон “Эрдэс баялгийн салбарын хөгжлийн бодлого, шинэчлэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар”;
- Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар “Хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар”;
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ “Цөлжилт, газрын доройтол, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар”.

/Дэлгэрэнгүйг “Мэдээ-3” хүснэгтээс үзнэ үү/

Хаврын ээлжит чуулганы хугацаанд Байнгын хорооны хуралдаанаар Засгийн газрын гишүүд болон холбогдох бусад байгууллагын 17 удаагийн мэдээлэл, тайлан, илтгэлийг хэлэлцсэн бөгөөд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 147 гишүүн 429 асуулт асууж, үг хэлсэн байна.

/Дэлгэрэнгүйг “Мэдээ-4” хүснэгтээс үзнэ үү/

Мэдээ –1.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГЫН ТАЛААРХ МЭДЭЭ

№	Гишүүний нэр	Хандсан байгууллага, албан тушаалтан	Асуулгын агуулга	Хамрагдсан асуудлын тоо	Асуулга явуулсан огноо	Хариу ирүүлсэн огноо	Хугацаа хэтэрсэн эсэх /хоногоор/	Нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн эсэх		
								Гишүүний саналын огноо	Хэлэлцсэн огноо	Асуулт асуусан гишүүн, асуулт /тоогоор/
1	Ц.Даваасүрэн	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан	Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийн цогцлобор байгуулах, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын боломжийг нээх болон “Монгол мал-1” арга хэмжээний хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаар	3	2021.05.14 №20	2021.05.28 01/1744		2022.03.17 УИХ-03/2343	2022.03.25	10 гишүүн 35 асуулт
2	С.Бямбацогт	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлын явц, түүнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлэх бусад арга хэмжээний талаар	4	2021.03.15 №06	2021.04.08 ХЭГ/954		2021.06.15- нд УИХ- 03/5168	2022.04.08	14 гишүүн 40 асуулт
3	Ш.Адъяаа	Эрчим хүчний сайд Н.Тавинбэх	Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барьж байгуулахтай холбоотой авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар	3	2021.12.17 №46	2021.12.31 а/4649		2022.01.12 УИХ-03/287	2022.04.08	14 гишүүн 40 асуулт
4	Н.Учрал	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийн талаар	4	2022.01.31 №03	2022.03.02 ХЭГ/433		2022.03.15 УИХ-03/2183	2022.05.13	12 гишүүн 41 асуулт

2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС ТАВЬСАН АСУУЛГЫН ТАЛААРХ МЭДЭЭ

1	Т.Аюурсайхан	Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн	“Төрийн банк” ХХК-ийн 2012-2022 оны үйл ажиллагааны талаар	8	2022.03.17 №06	2022.04.15 н/55	Нууцын журмаар 1413 хуудас материал ирүүлсэн.	2022.04.25 УИХ-03/3869	2022.06.10	14 гишүүн 57 асуулт
2	Ж.Чинбүрэн	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	“Элэг бүтэн Монгол” Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар	3	2022.03.17 №07	2022.04.15 ХЭГ/825		2022.04.25 УИХ-03/3869		
3	Н.Энхболд	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан	Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар	4	2022.03.31 №10	2022.04.15 01/1310		2022.05.16 УИХ-03/4583	2022.05.27	5 гишүүн 21 асуулт
4	С.Бямбацогт	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа	Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар	6	2022.04.04 №11	2022.04.28 01/1150				
5	Н.Алтанхуяг	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Төрийн өмчийн талаар авч хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээний тухай	6	2022.04.12 №14	2022.05.1 3ХЭГ/1089		2022.05.20 УИХ-03/4836	-	
6	Н.Ганибал	Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан	Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын талаар	8	2022.04.13 №16	2022.06.03 3Г-2/320				

7	Ц.Туваан	Эрүүл мэндийн сайд С.Энхболд	Эм үйлдвэрлэл, эмийн үнийн талаар	4	2022.04.14 №17	2022.04.18 №19	2022.04.22 №20	2022.05.11 №21	2022.06.17 1a/2907	2022.06.17 ХЭГ/1432	2022.06.27 ХЭГ/1531
8	М.Оюунчимэг	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Эмийн үйлдвэрлэл, чанар, хяналт, хүртээмж зэрэг асуудал болон энэ талаарх цаашдын бодлого, зорилтын талаар	5	2022.05.05 ХЭГ/1021						
9	Т.Доржханд	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Байгалийн хийн хоолой барьж байгуулах төслийн үйл явц, үр дүнгийн талаар	5	2022.05.18 ХЭГ/Н-10						
10	Н.Ганибал	Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан	Байгалийн хийн хоолой барьж байгуулах төслийн гэрээ хэлэлцээрийн үйл явц, Монгол Улсад өгөх үр өгөөжийн талаар	8	2022.05.13 ЗГ-2/278						
11	Б.Дэлгэрсайхан Т.Энхтүвшин	Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Дорноговь аймаг дахь салбар сургуулийн талаар	6	2022.06.17 1a/2907						
12	М.Оюунчимэг	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой бүтээн байгуулалтын ажлын талаар	5	2022.05.20 №22						
13	Н.Алтанхуяг	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Засгийн газраас нүүрсний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн зээлийн талаар	16	2022.05.25 №23						

Мэдээ – 2.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭ

№	УИХ-ын гишүүний нэр	Хандсан байгууллага, албан тушаалтан	Асуултын агуулга	Хамрагдсан асуудлын тоо	Асуулт явуулсан огноо	Хариу ирүүлсэн огноо	Хугацаа хэтэрсэн эсэх /хоноогоор/	Байнгын хорооны хуралдаанд хуралдаанд хэлэлцүүлсэн эсэх /огноо/	Нээсэн хуралдаанд танилцуулсан эсэх /огноо/	Гарсан шийдвэр
1	Ж.Бат-Эрдэнэ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 3.Мэндсайхан	"Ноос, ноолуурын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Байнгын хорооны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар	1	2022.03.24 №08	2022.04.08 01/1100	12-нд ХХААХҮЯ-аас ирүүлсэн.	2022.04.27 ҮББХ 5 гишүүн 14 асуулт асууж, санал хэлсэн.	2022.05.06	"Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 19 дүгээр тогтоол
2	Ц.Даваасүрэн	Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар	Гишүүний бүрэн эрхэд халдсан талаар	5	2022.03.25 №09	2022.04.13 1/2094				
3	Х.Ганхуяг	Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан	Хилийн боомтуудын үйл ажиллагааны талаар	4	2022.04.05 №12	2022.04.27 3Г-2/228				
4	Х.Ганхуяг	Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагваасүрэн	Төгрөг, долларын ханш болон төлбөр тооцооны асуудалд ямар зохицуулалт хийж байгаа талаар	2	2022.04.05 №13	2022.04.05 А-1/403				

5	Ц.Даваасүрэн	Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 6, 7, 13 дугаар хороодыг цэвэр, бохир усны шугамд холбох ажлын гүйцэтгэлийн талаар	5	2022.04.13 №15	2022.05.06 1/2253	1	1	1
Нийт – 5				17	5	1	1	1	1

Мэдээ – 3.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ**

№	Сэдэв	Мэдээлэл хийсэн сайд	Мэдээлэл сонссон огноо	Асуулт асууж, үг хэлсэн гишүүд /тоогоор/	Асуусан асуулт, хэлсэн үгийн тоо
1	Газрын шинэтгэлийн бодлого, газрын харилцааны цахим системийн талаар	Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар	2022.03.18	4	17
2	Эрдэс баялгийн салбарын хөгжлийн бодлого, шинэчлэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон	2022.04.01	5	23
3	Хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар	Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар	2022.05.20	4	13
4	Цөлжилт, газрын доройтол, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ	2022.06.03	8	32
Нийт – 4				21	85

Мэдээ – 4.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ, ИЛТГЭЛ

№	Байнгын хорооны нэр, огноо	Мэдээлэл хийсэн байгууллага, албан тушаалтан	Мэдээллийн сэдэв	Асуулт асууж, үг хэлсэн гишүүд / давхардсан тоогоор/	Асуусан асуулт, хэлсэн үгийн тоо
1	Түр хороо /КОВИД -19/ 2022.03.15	Монгол Улсын Шадар сайд, УОК-ын дарга С.Амарсайхан	Монгол Улсын Засгийн газраас 2021 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар УОК-оос авч хэрэгжүүлсэн нөхцөл байдлын талаар	6	20
2		Эрүүл мэндийн сайд С.Энхболд	ЭМЯ-наас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, нөхцөл байдлын талаар		
3	БСШУСБХ 2022.03.28	Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалтын хэрэгжилтийн талаар	5	14
4	АБГББХ 2022.03.30	Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав	Цөмийн энергийн комиссын үйл ажиллагааны тайлан	2	7
5	БОХХААБХ 2022.04.13	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар	14	49
6	БОХХААБХ 2022.04.19	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан	Хаврын тариалалтын бэлтгэл ажлын талаар	12	33
7	ЭЗБХ 2022.04.19	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан	Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны үйл ажиллагааны тайлан	9	13
8	НББХ 2022.05.04	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга А.Ариунзаяа	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайлан	8	32

9	НББХ 2022.05.10	Эрүүл мэндийн сайд С.Энхболд	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайлан	20	78
10	БСШУСБХ 2022.05.11	Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ц.Шаравжамц	БСШУСБХ-ны 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 08 дугаар тогтоолын биелэлтийн талаар	6	15
11	БСШУСБХ 2022.05.11	Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан	Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны талаар	7	21
12	БСШУСБХ 2022.05.11	Эрүүл мэндийн сайд С.Энхболд	Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь электрон тамхины хэрэглээний талаар	11	21
13	ТБХ 2022.05.24	Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Үндэсний аудитын газрын Аудитын III газрын захирал Д.Энхболд	Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүнгийн талаар	9	28
14	ТБХ 2022.05.24	Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Үндэсний аудитын газрын Аудитын IV газрын захирал Я.Самбууням	МҮОНРТ-ийн 2017-2020 оны улсын төсвийн санхүүжилтийн хэрэгжилт, үр нөлөөний талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлан	10	27
15	/КОВИД-19/-ын Түр хороо 2022.06.07	Эрүүл мэндийн сайд С.Энхболд	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын нөхцөл байдал, шинэ төрөл, чиг хандлага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар	5	15
16	НББХ 2022.06.07	Эрүүл мэндийн сайд С.Энхболд	Хорт хавдрын өвчлөл, нас баралтын өнөөгийн байдлын талаар	16	41
17	ХЗБХ 2022.06.15	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан	Хүний эрхийн Үндэсний Комиссын 21 дэх илтгэл	7	15
Нийт – 17				147	429

ДӨРӨВ

УЛСЫН ИХ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА,
СҮРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1.МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс нь Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хууль тогтоох үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд бодитой, шуурхай түгээлээ.

Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл, чуулганы нэгдсэн хуралдаан, Байнгын, дэд, түр хороо болон Ажлын хэсгийн хуралдааны тойм, Улсын Их Хурлын дарга, гишүүд, Байнгын хороод, Улсын Их Хурлын Тамгын газраас зохион байгуулсан хэвлэлийн хурал, уулзалтууд, үйл ажиллагааны талаарх нийт 287 текст мэдээг 1430 гэрэл зургийн хамт parliament.mn цахим хуудаст байршуулав. Хаврын ээлжит чуулганы хугацаанд parliament.mn цахим хуудасны англи хувилбарт 12 мэдээ нийтэллээ.

Ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын долоо хоног тутмын үйл ажиллагааг тоймлон 15 нэвтрүүлэг бэлтгэж, телевизүүдийн эфир, олон нийтийн сүлжээгээр иргэдэд хүргэв. Түүнчлэн Улсын Их Хурал, түүний Тамгын газрын албан ёсны мэдээ мэдээллийг түгээх сувгийг өргөжүүлэх зорилгоор дээрх нэвтрүүлгүүд, видео контентуудыг Тамгын газрын дотоод сүлжээний “Parliament TV”-ээр өдөр тутам түгээж байна.

БЭЛТГЭЖ ТҮГЭЭСЭН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ



Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүд, Улсын Их Хурлын дарга болон гишүүдийн уулзалтын талаарх 27 видео мэдээ, нийгмийн сүлжээний богино хэмжээний 197 контент бэлтгэж parliament.mn цахим хуудаст байршуулахын зэрэгцээ youtube.com, twitter.com, facebook.com сүлжээгээр олон нийтэд түгээв.


Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллага Улсын Их Хурал байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд телевизийн гурван нэвтрүүлэг

бэлтгэсний зэрэгцээ хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Улсын Их Хурлын гишүүдээр ажиллаж байсан төрийн зүтгэлтнүүдийн талаарх нийт 30 нийтлэл, дурсамж, ярилцлагуудыг цувралаар бэлтгэж, олон нийтэд сурталчилсан.

Ээлжит чуулганы хугацаанд Хууль зүйн байнгын хорооноос зохион байгуулсан Улсын дээд шүүхийн нэр дэвшигчтэй хийх нээлттэй сонсгол, Нийгмийн бодлогын байнгын хорооноос зохион байгуулсан Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол, Улсын Их Хурал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэй хамтран явуулсан “Монгол Улсын төлбөрийн тэнцлийг сайжруулах нь өрийн удирдлагын үндсэн зарчим” сэдэвт хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээнүүдийг IPTV, дотоод сүлжээ, цахим сүлжээгээр нийт 17 удаа шууд дамжуулсан.

Улсын Их Хурлын бүхий л үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг сурталчлах үйл ажиллагааг өргөжүүлэн Монголын Үндэсний олон нийтийн радио, “Эм Жи Эл” радио сувгуудаар Улсын Их Хурлын баталсан хууль тогтоомж, үйл ажиллагааны талаарх өдөр тутмын мэдээ, мэдээллийг тогтмол түгээж байна. Хаврын ээлжит чуулганы хугацаанд Монголын Үндэсний олон нийтийн радиогоор батлагдсан хууль тогтоомжийн талаарх “Шинэ хууль” нэвтрүүлгийн 10 дугаарыг бэлтгэн, давталттайгаар нэвтрүүлсэн бол “Эм Жи Эл” радиогийн шууд эфирээр Улсын Их Хурлын гишүүд болон Тамгын газрын ажилтнууд хэлэлцүүлэгт буй хуулийн төсөл болон батлагдсан хуулийн талаар, Улсын Их Хурлын Тамгын газраас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар нийт 14 удаа мэдээлэл хүргэсэн. Түүнчлэн “Эм Жи Эл” радио сувгаар ажлын өдрүүдэд 08.00, 13.00, 18.00 цагийн шуурхай мэдээгээр Улсын Их Хурлын үйл ажиллагаа, баталсан хууль тогтоомжийн талаар нийт 387 мэдээ мэдээлэл бэлтгэж нэвтрүүлсэн.

Улсын Их Хурлын Байнгын болон дэд хороод, Улсын Их Хурлын Тамгын газраас зохион байгуулсан нээлттэй сонсгол, хэлэлцүүлэг, уулзалт, семинар хэвлэлийн хуралд сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг өргөнөөр оролцуулах ажлыг тухай бүрд нь зохион байгуулж ажилласан.



Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.10 дахь хэсэгт “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд хэвлэн нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эх гэж үзнэ” хэмээн заасан байдаг. Ээлжит чуулганы хугацаанд “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 15 дугаарыг хэвлэж захиалагч, уншигчдад хүргүүлэв.

Эмхэтгэлийн дээрх дугааруудын тойм, танилцуулгыг бэлтгэн parliament.mn цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулав. Үүний зэрэгцээ дугаар бүрийн PDF хувилбарыг тухай бүр parliament.mn цахим хуудсанд нийтлэн, хууль тогтоомжийн албан ёсны эхийг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр шуурхай түгээлээ. Эмхэтгэлийн дугаарт Монгол Улсын хууль 186, Улсын Их Хурлын тогтоол 29, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 19, Засгийн газрын тогтоол 19, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт 1, Монгол Улс нэгдэн орсон олон улсын хоёр гэрээг тус тус нийтэлжээ. Мөн Монгол Улсын Засгийн газраас баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдэх хууль тогтоомжуудыг үндэсний монгол бичгээр хэвлэж байна.

Олон нийттэй харилцах үйл ажиллагааны хүрээнд Улсын Их Хурлын гишүүд болон иргэд, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу гадаад, дотоодын 15200 зочин, төлөөлөгчийг Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцуулах ажлыг зохион байгуулав.

ЦАХИМ ХУУДСААР МЭДЭЭЛЭЛ АВАГЧ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО



ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО

58,655



ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО

31,373

Олон нийтийн сүлжээн дэх Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсуудаар хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг текст, фото, видео хэлбэрээр шуурхай, хүртээмжтэйгээр олон нийтэд түгээж байна. Мөн олон нийтийн сүлжээний хэрэглэгчдэд мэдээллийг ойлгомжтой, шуурхай хүргэх зорилгоор постер 45-ыг бэлтгэн түгээв. Хаврын ээлжит чуулганы хугацаанд facebook.com цахим сүлжээн дэх Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсаар 58655 дагагч, twitter.com сүлжээн дэх Улсын Их Хурлын албан ёсны хаягаар 31374 дагагч хууль тогтоох байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны талаарх мэдээллийг шуурхай хүлээн авч байна.

4.2.УЛСЫН ИХ ХУРАЛД ИРГЭД, СОНГОГЧДООС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ

Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжилт чуулганы хугацаанд УИХ-ын гишүүд, Байнгын хороодод ирсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн тоог доорх зурагнаас харна уу?



Энэ хугацаанд Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороо хамтран 398 өргөдөл, гомдол буюу 25 хувийг бүрэн шийдвэрлэсэн бөгөөд 1196 өргөдөл буюу 75 хувь нь судалж шийдвэрлэх шатандаа байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдлийг агуулгаар нь ангилбал: Иргэдээс ээлжит чуулганы хугацаанд 1594 өргөдөл ирүүлснээс 839 буюу 52.6 хувь нь нийслэлийн иргэдээс, 328 буюу 20.6 хувь нь хөдөө орон нутгийн иргэдээс /427 буюу 26.8 хувийн өргөдөл хаяг тодорхойгүй/ тус тус ирүүлсэн.

Хаврын ээлжит чуулганы хугацаанд Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд биечлэн ирсэн нийт 150 иргэний санал, хүсэлтийг авснаас Улсын Их Хурлын бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хэлэлцэж буй хууль тогтоомжийн төслүүдтэй холбогдсон болон нийтэд тулгарч буй асуудлын талаар 79 иргэн саналаа илэрхийлж, иргэний тавьсан хувийн 71 хүсэлтийг Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслах нартай холбогдож, танилцуулан зөвлөгөө өгөх, өргөдөл, гомдлын хариуг нь лавлах, шаардлагатай албан тушаалтантай нь холбогдож хариуг өгүүлэх зэргээр шийдвэрлэв.


Мөн www.11-11.mn цахим хуудсаар Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороо, намын бүлэг, Тамгын газарт болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудад хандан 417 иргэнээс санал, хүсэлт, гомдол, шүүмжлэл, ирүүлснийг холбогдох байгууллагад уламжилж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.

4.3.МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БОЛОН ХУРАЛДААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Хуралдааны цахим системийн үйлчилгээ

Программ хангамж

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааны цахим системийг ашиглан Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд 37 удаагийн (системийн бүртгэлээр нийт 220 цаг 17 минутын) нэгдсэн хуралдаанд 1527 удаа санал хураалт явуулж, 3022 удаа гишүүдийн болон ажлын хэсгийн микрофоныг нээж, үг хэлэх, асуулт асуух, асуултад хариулах техникийн боломжийг бүрдүүлсэн. Байнгын (дэд, түр) хороодын 136 удаагийн (системийн бүртгэлээр нийт 249 цаг 05 минутын) хуралдаанд 1039 удаа санал хураалт явуулж, 3847 удаа гишүүдийн болон ажлын хэсгийн микрофоныг нээж ажиллуулав. Ээлжит чуулганы хугацаанд хуралдааны цахим системийн программ хангамжийн операторын үйлчилгээг нийт 172 удаа үзүүлэв.



Хуралдааны санал хураалтын үр дүн, хуралдааны талаарх тоон мэдээллийг хоёр удаа нэгтгэн боловсруулж холбогдох нэгж, албан тушаалтанд хүлээлгэн өгсөн.

Хуралдааны дүрсний систем

Хаврын ээлжит чуулганы хугацаанд 37 удаагийн нэгдсэн хуралдаан, 142 удаагийн Байнгын болон дэд, түр хороодын хуралдаан, 70 гаруй удаагийн ажлын хэсэг, мэдээллийн цаг, сургалт семинар, уулзалтын дүрс бичлэгийг хийсэн. Хуралдааны бүх дүрс бичлэгүүдийг хөрвүүлэн Улсын Их Хурлын Тамгын газрын файлын нэгдсэн сангийн cloud.parliament.mn системд байршуулан хэрэглэгчид ашиглах боломжийг бүрдүүллээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг МҮОНТ-ийн 2 дугаар суваг, ТМ телевиз, Парламент телевиз, Юнивишн, Скаймедиа IPTV, Төрийн ордны теле сүлжээ, Тамгын газрын дотоод сүлжээний IPTV болон www.parliament.mn, iptv.parliament.mn цахим хуудас, ParliamentMN, D.Parliament facebook хуудсаар 37 удаа шууд дамжуулж, Байнгын (дэд, түр) хороодын

хуралдаан, Улсын Их Хурал дахь намын бүлгүүд болон Улсын онцгой комиссын мэдээллүүдийг дотоод сүлжээний IPTV-ээр шууд дамжуулсан.

Хуралдааны дууны систем

Хаврын ээлжит чуулганы хугацаанд 37 удаагийн нэгдсэн хуралдаан, 142 удаагийн Байнгын болон дэд, түр хороодын хуралдаанаас гадна 284 удаагийн ажлын хэсэг, мэдээллийн цаг, сургалт семинар, уулзалтын дууны бичлэгийг хийсэн. Мөн хуралдааны дууны бичлэгүүдийг Улсын Их Хурлын Тамгын газрын файлын нэгдсэн сангийн cloud.parliament.mn системд байрлуулан хуралдааны тэмдэглэл хөтлөгчид болон эрх бүхий бусад хэрэглэгчид ашиглах боломжийг бүрдүүлээд байна.

Хуралдааны танхимуудад зохион байгуулагдсан хэлэлцүүлэг, ажлын хэсгийн хуралдаан болон Улсын Их Хурлын удирдлага, гишүүдийн оролцсон хурал, уулзалт зэрэг 10 гаруй удаагийн арга хэмжээнд орчуулгын систем, 20 гаруй удаагийн арга хэмжээнд цахим программ ашигласан.

Мэдээллийн технологийн үйлчилгээ

“MyParliament” хөдөлгөөнт оффисийн системийн мэдээллийн санд системийн хандалт 595, үйл ажиллагаа 1101, хуулийн төсөл, хэлэлцэх асуудал 231, дагалдах файлууд 767, үйл явдал, хуралдаан 498 шинээр нэмж бүртгэгдсэн бөгөөд “ТМ эмхэтгэл” аппликейшнд “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 14 дугаарыг шинээр нэмж оруулсан.

Хуулийн төсөл боловсруулах lawmaker.parliament.mn, хуулийн төслийн хэлэлцүүлгийн lawforum.parliament.mn системд нийт 63 ширхэг хуулийн төслийг нэмж байршуулсан бөгөөд одоогоор уг системд байршуулсан нийт 109 ширхэг (боловсруулж буй 42 ширхэг, өргөн мэдүүлсэн 67 ширхэг) төслийг иргэд 129880 удаа үзэж танилцан 1415 саналыг цахимаар ирүүлээд байна.

Системд 106780 иргэн зочилсон бол 2055 иргэн системийн хэрэглэгчээр бүртгүүлж, 1357 хэрэглэгч бүртгэлээ баталгаажуулж, 167 хэрэглэгч төслийг “даган” мэдээлэл авч байгаа бол системээс хэрэглэгчдэд нийт 4912 удаа цахим шуудан илгээсэн байна.

Парламентын цахим шилжилтийн “D-Parliament” цахим системийг ашиглалтад оруулж одоогоор боловсруулж буй 58, өргөн мэдүүлсэн 76 төслийг байршуулан иргэдийн саналыг авч байна. “D-Parliament” цахим системд 3294 иргэн хэрэглэгчээр бүртгүүлэн 1533 иргэн танилт нэвтрэлтийн ДАН системийн баталгаажуулалт хийж, нийт 56872 удаагийн хандалт хийгджээ. Цахим системд байршуулсан төслүүдийг иргэд үзэж танилцан дэмжих эсэхээ нийт 28027 удаа /like - 27415, dislike - 612/ илэрхийлж, нийт 901 ширхэг санал ирүүлэв.


Мөн уг цахим системийн мобайл аппликейшнийг ашиглалтад оруулж iOS хувилбарыг 2942, Android хувилбарыг 2831 хэрэглэгч гар утас, хөдөлгөөнт төхөөрөмжид суулган ашиглаж байна.

4.4. СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Судалгаа, мэдээлэл, лавлагаа хийх ажлын хүрээнд

Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд хуулийн төсөл болон Улсын Их Хурлаар хэлэлцэн баталж буй хууль, тогтоолын төсөлд холбогдох 28 судалгааны захиалгыг Улсын Их Хурлын дарга, гишүүдээс хүлээн авч гүйцэтгэлээ.

Судалгааны ажил - 28



Ном товхимол, гарын авлага гаргах ажлын хүрээнд

Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгээс ном, товхимол эмхэтгэн гаргах ажлын хүрээнд “Парламент” судалгааны эмхэтгэл цуврал ботийн 36, 37, 38 дахь дугаар, “Судалгааны мэдээллийн сангийн лавлагаа” цуврал брошюрын 28 дахь дугаар, “Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит, 2022 оны ээлжит бус чуулганы үйл ажиллагааны болон хүндэтгэлийн хуралдааны танилцуулга”, “Мэдээлэл судалгаа”-ны мэдээллийн хуудас долоон дугаарыг эмхэтгэн гаргаж Улсын Их Хурал, түүний Тамгын газрын албан хэрэгцээнд хүргүүлээ.

Мөн Улсын Их Хурлын гишүүдийн хууль хэлэлцэн батлах үйл ажиллагаанд мэдээллийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Парламентын номын сангаас Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлаар тогтмол хэвлэлийн ном зүйн лавлагаа, Парламентын номын санд буй ном товхимлын ном зүйн лавлагаа тус тус нэгийг боловсруулан Улсын Их Хурлын гишүүдийн “MyParliament” хөдөлгөөнт оффисийн системд байршуулсан.

Сургалт зохион байгуулах ажлын хүрээнд

Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн Сургалтын алба нь Улсын Их Хурлын гишүүд, түүний ажлын албаны ажилтнууд болон Улсын Их Хурлын Тамгын газрын нийт ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах, холбогдох ном, эмхэтгэл, гарын авлагаар хангах чиг үүргийг

хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд хаврын ээлжит чуулганы хугацаанд нийт 23 удаагийн сургалт, дөрвөн хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Ээлжит чуулганы хугацаанд зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүн, түүний ажлын алба болон Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд, Улсын Их Хурал дахь намын бүлгийн ажлын албанаас нийт 970 хүн (давхардсан тоогоор) хамрагдсан байна.

Сургалтын цогц хөтөлбөр боловсруулах хүрээнд

Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх ажлыг тогтмолжуулах, бодлогын бичиг баримтад тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхээр зургаан үндсэн, 25 дэд хөтөлбөр бүхий “Парламентын сургалтын цогц хөтөлбөр” нь Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 164 дүгээр захирамжаар батлагдсан.

Хаврын чуулганы хугацаанд Парламентын сургалтын цогц хөтөлбөрт тусгагдсан “Монгол Улсын Их Хурлын гишүүнд зориулсан чиглүүлэх мэдээлэл, сургалт”, “Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаа ба Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх”, “Хуулийн төсөл боловсруулагчдыг бэлтгэх сургалтын дэд хөтөлбөр”, “Улсын Их Хурлын Тамгын газрын шинэ ажилтанд зориулсан чиглүүлэх сургалт”, “Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй”, “Бодлогын баримт бичиг боловсруулах арга зүй” зэрэг дэд хөтөлбөрүүдийг батлуулав.

Монгол Улсын хууль тогтоох үйл ажиллагаа болон Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, Хуулийн төсөл боловсруулагч бэлтгэх анхан шатны сургалт, Хуулийн төсөл боловсруулагч бэлтгэх ахисан шатны сургалтын дэд хөтөлбөрүүдийн агуулгыг Азийн сангийн дэмжлэгтэйгээр боловсруулсан. Үүнээс гадна “Үндэсний аюулгүй байдал, геополитик”; “Монгол хэл, бичиг, найруулга зүй”; “Инновац цахим бодлого”; “Хүний эрхэд суурилсан хандлага” зэрэг хөтөлбөрүүдийг мэргэжлийн холбогдох шинжээчдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан боловсруулсан бөгөөд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар батлуулах бэлтгэлийг хангаад байна.

Парламентын боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын санаачилгаар өсвөр үеийнхэнд ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хууль тогтоох үйл ажиллагааны талаар ойлголт өгөх, тогтвортой хөгжлийн зорилго, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг олгох, шийдвэр гаргах түвшинд өсвөр үеийнхний оролцоог дэмжих зорилгоор “Өсвөрийн парламент-2021” хөтөлбөрийг үндэсний хэмжээнд Улсын Их Хурал, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо, НҮБ-ын “Хүүхдийн сан”, “People in need” байгууллагуудтай хамтран үндэсний хэмжээнд 2021 оны 09 дүгээр сараас 2022 оны 05 дугаар сарын хооронд зохион байгуулж, 90 сурагч, 10 багш, 10 сайн дурын ажилтан оюутныг хамруулаад байна.

Швейцарын хөгжлийн агентлагийн “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” дэд төсөл, Монголын Карл Попперын Мэтгэлцээний нийгэмлэгтэй хамтран “Парламентын боловсрол” илтгэх ур чадвар, мэтгэлцээний аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 05 дугаар сарын 28-наас 30-ны өдрүүдэд зохион байгуулав.

“Парламентын сургалтын цахим систем”-ийг нэвтрүүлж, хөгжүүлэх ажлын хүрээнд

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн тусламжтайгаар “Парламентын сургалтын цахим систем”-ийг хөгжүүлээд байна. Системийг бүрэн хүлээн авах ажлын хэсэг байгуулагдан гүйцэтгэгчтэй гурван удаагийн уулзалт хийж, ажил хүлээлцэх акт үйлдэж Ажлын хэсгийн дүгнэлт гаргахаар ажиллаж байна. Улсын Их Хурлын Тамгын газрын нийт 213 ажилтныг системд бүртгэх ажлыг хийж байна. Шинэ ажилтны чиглүүлэх цахим сургалтыг системд байршуулах бичлэгийн ажил хийж байна.

- 3  Эрдэнэсийн сангийн орлого нь иргэн, хуулийн этгээдээс төрд худалдсан, бэлэглэсэн, хандивласан, хууль тогтоомжийн дагуу шилжүүлсэн
- 4  Эрдэнэсийн санд худалдах эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлд тогтоох сорьцыг эрх бүхий хуулийн этгээд хийж болохоор;
- 5  Монголбанкны бүрэн эрх тодорхой болж, эрдэнэс худалдан авахад санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий мэргэжлийн зөвлөлтэй байх бөгөөд мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монголбанкны Ерөнхийлөгч батлахаар;
- 6  Монголбанк эрдэнэсийг эзэмшигч, өмчлөгч иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хадгалах, түүнтэй холбоотой ажил, үйлчилгээг үзүүлж болно.

АЧ ХОЛБОГДОЛ

Эрдэнэсийн сангийн эрх зүйн орчин боловсронгуй болж, Монгол Улсын түүх, соёлын өвийн эрх зүйн хамгаалалт сайжирч, үнэ цэнэ нэ мэгдэх, Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын жилийн төсөв, гүйцэтгэлийн тайлан, тооллогын дүн олон нийтэд ил болж, Эрдэнэсийн сангийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг илүү ойлгомжтой тодорхой болгосон.

Эрдэнэсийн сангийн байнгын хэсгээс эрдэнэсийг худалдсан, шилжүүлсэн, захиран зарцуулсан болон эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр байнгын бус хэсгээс эрдэнэсийг худалдсан, шилжүүлсэн, захиран зарцуулсан бол гэмт хэрэгт тооцож Эрүүгийн хуульд холбогдох нэмэлтийг оруулсан.

Монгол Улсын нутаг дэвсгэрт эрдэнэс эзэмшигч хүн, хуулийн этгээд, бусад байгууллага нь эрдэнэсийн санд худалдах эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлд сорьц тогтоолгох нь сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хязгаарлагдахгүй, эрх авсан хувийн хэвшлийн хуулийн этгээдэд нээлттэй болно.

1.3. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2022.04.29

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас 2022.04.20-ны өдөр өргөн
мэдүүлсэн.

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**

► ХАМРАХ ХҮРЭЭ:

**ТӨРИЙН БҮХ ШАТНЫ БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН БОЛОН
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ТЭДГЭЭРИЙН ОРОЛЦООТОЙ
ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХАМААРНА.**



**ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ ТАВИХ:**

**ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА,
САНХҮҮ, ТӨСВИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА.**

**ХУУЛИАР ХОРИГЛОСОН
ЗҮЙЛСИЙГ ЗӨРЧВӨЛ:**

**ХОЛБОГДОХ АЛБАН
ТУШААЛТНЫГ АЖЛААС
ХАЛАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО.**

ХЭМНЭЛТИЙН БОДЛОГО



Хууль батлагдсанаар төрийн бүх шатанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавих болон улсын салбарт хамаарах аливаа хуулийн этгээдийн зарим үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүллээ.



Хуулийн үйлчлэлд бүх төрийн албан хаагч, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд тэдгээрийн албан хаагчид, төрийн болон орон нутгийн өмчийн 50 болон түүнээс дээш хувийн оролцоотой хуулийн этгээд, мөн бүх шатлалын төсөв, тусгай сангууд, төсөвт авсан зээл, тусламжийн эх үүсвэр хамаарна.



Төрийн бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд түүний албан тушаалтны хувьд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахдаа бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуулийг дагаж мөрдөхөөр хуульчлагдлаа.

ДЭД, ОРЛОГЧ ДАРГА



Хуулийн үйлчлэлд хамаарах бүх этгээд агаарын тээврийн хэрэгслээр албан томиллоор энгийн зэрэглэлээс бусад суудлаар төсвийн болон байгууллагын хөрөнгөөр зорчихыг хориглож ингэхдээ нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ.

Албан томиллоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томиллоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.

Хуульд тусгайлан заагаагүй бол төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг, Засгийн газрын ажлын алба, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, эмнэлэг, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компаниас бусад этгээд тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглоно.

Нийслэлийн Засаг дарга ХОЁР, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга НЭГ орлогч даргатай байна.

Дээр дурдсанаас бусад бүх этгээд дэд, орлогч дарга, зөвлөхтэй байхыг хориглоно.

Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга зөвлөхгүй ажиллана.



ХОРИГЛОХ ЗҮЙЛС



Төрийн хэмнэлтийн хуульд жил бүрийн 5 дугаар сарын 31-ний дотор батлагдсан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн дуусгаагүй бол тэрхүү хөрөнгийг хэмнэлтэд тооцож, цаашид төрийн хөрөнгөөр хөшөө дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барих явдлыг хориглож байна.

Техник эдийн засгийн үндэслэлгүй, зураг төсөлгүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй төсөл арга хэмжээг төсөвт суулгаж батлахыг хориглосон.


Улсын төсвөөс орон нутгийн шинжтэй дэд бүтэц, нийтийн аж ахуйн үйлчилгээ зэрэг хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг санхүүжүүлэхийг ч мөн хориглосон.

Төрийн бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн 50 болон түүнээс дээш хувийн оролцоотой хуулийн этгээд Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэргүйгээр шинээр хараат болон охин компани байгуулах, чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох, төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглосон.

Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно.

БУСАД ХОРИГЛОХ ЗҮЙЛС

Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглосон.



ТӨРИЙН БҮХ ШАТЛАЛЫН БАЙГУУЛЛАГА САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОНО:


Төрийн бүх шатлалын байгууллагуудын албан тушаалтан гар утас, хэвлэл захиалга болон ээлжийн амралтаар амрах замын төлбөрөө байгууллагаас төлүүлэх, мөн хуулиар зөвшөөрөөгүй аливаа хангамж эдлэх;

Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авах;

Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгаанаар ашиглах боломжгүй болохыг тогтоосон тухай мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарснаас бусад тохиолдолд захиргааны зориулалтаар барилга шинээр барих.

ТӨРИЙН АВТОМАШИНЫ ХЭРЭГЛЭЭГ ХЯЗГААРЛАХ


Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.



Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албаны автомашин ашиглахыг хориглоно.

Төрийн бүх шатны байгууллага орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн автотээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно.

Төрийн өмчид бүртгэлтэй суудлын автомашинд бусад авто тээврийн хэрэгслээс ялгаатай дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.



АВТОМАШИНЫ ХЯЗГААРЛАЛТАД ХАМААРАХГҮЙ ЭТГЭЭД:

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд;

Эмнэлэг, цагдаа, гамшгаас хамгаалах, хил хамгаалах, зэвсэгт хүчин гэх мэт үндсэн үйл ажиллагаа нь тусгай зориулалтын автотээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ, шаардлагыг бий болгодог байгууллагууд автомашин хэрэглэнэ.

ТӨРИЙН БҮХ ШАТЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА МӨРДӨЖ ХЭМНЭЛТ ГАРГАХ ЧИГЛЭЛ

1

Мөн төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн болон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг хуульд заасны дагуу Засгийн газар болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтоож, хэрэгжүүлэх;



Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хор зэрэг зардлыг хэмнэх;

2

Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх, төв, суурин газрын төсвийн байгууллагуудад халаалтын хэмнэлтийн горим сонгох, тоолуурт шилжих зэргээр ашиглалтын зардал хэмнэх.

3

1.4. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2024-2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ, “ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2023-2025 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Нэг. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн дунд хугацаан дахь төсөөллийн баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоож өгсөн төсвийн тусгай шаардлагад нийцсэн байна гэж үзэн Засгийн газрын өргөн мэдүүлсэн төслийн хувилбараар буюу дор дурдсанаар баталлаа:

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2023 он	2024 он	2025 он
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.0	5.1	6.1
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	17,312.2	18,511.9	20,496.7
	-ДНБ-д эзлэх хувь	32.7	33.1	32.8
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	19,219.1	20,077.8	21,744.8
	-ДНБ-д эзлэх хувь	36.3	35.9	34.8
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	1,305.6	858.8	1,666.9
	-ДНБ-д эзлэх хувь	2.5	1.5	2.7
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,906.8	-1,565.9	-1,248.1
	-ДНБ-д эзлэх хувь	-3.6	-2.8	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	4,484.4	5,019.5	5,436.2
	-ДНБ-д эзлэх хувь	8.5	9.0	8.7
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	34,428.4	33,556.0	37,443.0
	-ДНБ-д эзлэх хувь	65.0	60.0	60.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	604.8	569.6	590.0
	-ДНБ-д эзлэх хувь	1.1	1.0	0.9

Уг хууль нь тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв, дунд хугацааны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын эрх зүйн үндэс болох бөгөөд 2023 оны төсвийн төслийг боловсруулах үндсэн баримт бичиг болох болно.

Уг хуулийг Төрийн мэдээлэл эмхэтгэлд нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр мөрдөж эхэлнэ.

Хоёр. Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт дараах агуулгыг тусган баталлаа.

1) Улсын нийт гадаад өр, Засгийн газрын өрийн өнөөгийн нөхцөл байдал:

Улсын нийт гадаад өр: Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн байдлаар 33.2 тэрбум ам.доллартой тэнцэж байна. Үүнээс Засгийн газрын гадаад өр 8.5 тэрбум ам.доллар /25.6хувь/, Төв банкны гадаад өр 2.6 тэрбум ам.доллар /7.8хувь/, бусад салбарын өр 8.2 тэрбум ам.доллар /24.7хувь/, Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагын өр 1.6 тэрбум ам.доллар /4.8хувь/, компани хоорондын зээллэг 12.3 тэрбум ам.доллар /37.0хувь/-ыг тус тус эзэлж байна.

Засгийн газрын өр: Засгийн газрын өрийн үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 26,918.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 50.7 хувьд хүрч, 2019 оны мөн үеэс 4.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2) Өрийн санхүүжилтийн боломжит эх үүсвэр:

Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэр: Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээний дийлэнх хувийг хөнгөлөлттэй нөхцөлтэй гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлсээр ирсэн байна.

Арилжааны нөхцөлтэй гадаад эх үүсвэр: Засгийн газраас 2012 онд 1.5 тэрбум ам.доллартой тэнцэх “Чингис” бонд, 2015 онд 1.0 тэрбум юаньтай тэнцэх “ДимСам” бонд, 2016 онд 500.0 сая ам.доллартой тэнцэх “Мазаалай” бонд, 2017 онд 600.0 сая ам.доллартой тэнцэх “Хуралдай” бонд болон 800.0 сая ам.доллартой тэнцэх “Гэрэгэ” бонд зэрэг нийт 3.6 тэрбум ам.долларын гадаад үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалжээ.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжих хугацаанд 2023 оны 5 дугаар сард “Гэрэгэ” бондын 533.1 сая ам.доллар, 2024 оны 3 дугаар сард “Хуралдай” бондын 600.0 сая ам.доллартой тэнцэх эргэн төлөлтүүд хийгдэх бол 2023 оны 12 дугаар сард

Хөгжлийн банкны “Самурай” төслийн хүрээнд арилжаалсан 30 тэрбум иентэй тэнцэх хөрөнгийг хөрөнгө оруулагчдад эргэн төлөх хуваарьтай байна.

Дотоодын банк, санхүү, хөрөнгийн зах зээлээс татах боломжит эх үүсвэр: Засгийн газраас төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, Засгийн газрын мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах, улсын төсвийн улирлын чанартай орлого, зарлагын зөрүүг бага зардлаар цаг хугацаанд нь санхүүжүүлэх болон төсвийн санхүүжилтийг хугацаанд нь олгох зорилгоор 2022 оны нэгдсэн төсөвт нийт 2.2 их наяд төгрөгийн Засгийн газрын дотоод үнэт цаас гаргахаар тусгагдсан бөгөөд Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулах сонирхолтой гадаад, дотоодын иргэд, аж ахуйн нэгжүүдийг өргөнөөр оролцуулахаар төлөвлөсөн.

3) Засгийн газрын өрийн шалгуур үзүүлэлтийн дунд хугацааны төсөөлөл ба нөлөөлөх хүчин зүйлс:

Өрийн тогтвортой байдлын шинжилгээнд аливаа улсын Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 50 хувиас давсан тохиолдолд тухайн улсыг “Сайтар шинжлэх” шаардлагатай орны ангилалд багтаан илүү нарийвчилсан шинжилгээг хийдэг. Монгол Улсын Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2020 онд 75.5 хувь байгаа бөгөөд 2023 он хүртэл Засгийн газрын өрийн баталгаа гаргаагүй тохиолдолд тус харьцаа хэвээр байх тул “Сайтар шинжлэх” шаардлагатай орны ангилалд орж байна.

Засгийн газрын өрийн хэмжээ 2012-2016 онд ихээхэн хэмжээгээр өссөн байна. Үүнд Засгийн газар өрийн баталгаа гаргаж эхэлсэн, төсөв алдагдалтай батлагдсан, валютын ханш суларсан зэрэг үзүүлэлтүүд ихээхэн нөлөө үзүүлжээ. Харин Засгийн газрын өрийн үлдэгдэл, ДНБ-ий харьцаа 2017-2019 онуудад буурсан нь ДНБ-ий өсөлт болон бодит хүүгийн түвшин буурсан зэргээс хамаарсан байна.

4) Засгийн газрын өрийн багц дахь зардал, эрсдэлд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийн таамаглал:

Өрийн удирдлагын боломжит хувилбарууд: Дотоод үнэт цаасаар санхүүжилтийн хэрэгцээг бүхэлд нь санхүүжүүлэх нь ханшийн эрсдэлийг багасгаж байгаа ч өрийн үйлчилгээний зардлыг ихэсгэснээр өрийн үйлчилгээний эрсдэл өндөр гарч байна. Цаашлаад арилжааны зээлийг ашигласнаар гадаад валютаар илэрхийлэгдсэн өрийн хэмжээг ихэсгэж, ханшийн эрсдэлийг өсгөж байна. Харин төсвийн алдагдлыг санхүүжүүлэх гадаад эх үүсвэрийг хязгаарлаж, дотоод эх үүсвэр ашиглах нь гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулж, гадаад өрийн дарамтыг бууруулах ач холбогдолтой болохыг шинжилгээний үр дүн харуулж байна.

Шинээр дэвшүүлсэн стратегийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга замууд: Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт дараах үндсэн зорилтуудыг тусгасан.

Үүнд:

- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулна;
- Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна;
- Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ;
- Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна;
- Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулна;
- Засгийн газрын өрийн ил тод байдлыг сайжруулна.

1.5.ДАЛАЙ АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2022.06.03

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас 2019.10.17-ны өдөр өргөн мэдүүлсэн.

**ДАГАН МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**

ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГАД ЗАРЧМЫН ШИНЖТЭЙ ДАРААХ ӨӨРЧЛӨЛТИЙГ ТУСГАСАН

 <p>Хөлөг онгоцны зориулалтаас хамаарсан олон улсын жишигт нийцүүлсэн шаардлагуудыг тусгаж өгсөн бөгөөд эдгээр шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих эрх, үүрэг бүхий Далбааны эзэн улсын хяналтыг шинээр тусгаж өгсөн.</p>	 <p>Хөлөг онгоцонд техникийн үзлэг шалгалт хийж, гэрчилгээжүүлэх үүрэг бүхий Монгол Улсаас хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих, томилохтой холбоотой зохицуулалтыг тусгалаа.</p>	 <p>Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн болон бүртгэгдэх хөлөг онгоцны баг, ахмадад тавигдах шаардлага, ээлжийн ажиллагаа болон чиг үүргийг нарийвчлан олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн тусгасан.</p>	 <p>Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцыг хэрэгжүүлэх, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог тусгаж, хуулийг практикт хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж өгсөн.</p>
---	---	---	---

ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН АЧ ХОЛБОГДОЛ

<p>1</p> <p>ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨХЦӨЛ БҮРДСЭН;</p>	<p>2</p> <p>МОНГОЛ УЛСЫН ХӨЛӨГ ОНГОЦНЫ БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЭРХ ЗҮЙН ТААТАЙ НӨХЦӨЛ БҮРДСЭН;</p>	<p>3</p> <p>ДАЛАЙН ТЭЭВРИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫГ ЧИГ ҮҮРГИЙГ НАРИЙВЧЛАН</p>	<p>4</p> <p>ДАЛБААНЫ ЭЗЭН УЛСЫН ХЯНАЛТ САЙЖРАХ БОЛОМЖ БҮРДСЭН;</p>
<p>5</p> <p>ДАЛАЙ АШИГЛАХТАЙ ХОЛБОГДСОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦСЭН;</p>	<p>6</p> <p>ТӨРИЙН, ТӨРИЙН БУС БОЛОН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХООРОНДЫН АЖЛЫН УЯЛДАА ХОЛБОО САЙЖРАХ БОЛОМЖ БҮРДСЭН;</p>	<p>7</p> <p>ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ЗӨРЧСӨН ЭТГЭЭДЭД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН.</p>	

1.6. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТАНИЛЦУУЛГА

<p>БАТАЛСАН ОГНОО</p> <p>2022.06.17</p>	<p>ХУУЛЬ САНААЧИЛСАН</p> <p>Засгийн газраас 2020.05.12-ны өдөр өргөн мэдүүлсэн.</p>	<p>ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА</p> <p>Ердийн журмаар</p>
---	--	---

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭХ ПРАКТИК ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

 <p>Үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгож, тэдгээрт тавих шалгуур, шаардлагыг тодорхой болгох;</p>	 <p>Хараат бус байдлаар үнэлүүлэх тохиолдлыг хуульчлах;</p>	 <p>Өмчийн эзэн иргэн, байгууллага /гуравдагч этгээд/-ын эрх ашиг, талуудын оролцоог хангах;</p>	 <p>Үнэлгээний бодитой байдлыг дээшлүүлж, үнэлгээчний хараат бус байдал, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх;</p>	 <p>Үнэлгээний чанарын хяналтын тогтолцоог бий болгох;</p>	 <p>Мэргэжлийн байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлох, оролцоог нэмэгдүүлэх;</p>	 <p>Үнэлгээний мэдээллийн санг зохистой бодитой хөгжүүлэх.</p>
---	--	---	--	---	--	---

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ЗОРИЛТ, ЗАРЧИМ

Хуулийн зорилт нь хөрөнгийн үнэлгээ хийх, түүний зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, хяналт тавих, энэ чиглэлээр төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг, үйл ажиллагаа болон үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ:

ХАРААТ БУС БАЙХ;	НУУЦЫГ ХАДГАЛАХ;	ШУДАРГА БАЙХ;	БОДИТОЙ БАЙХ;	ХУУЛЬ ТОГТООМЖ, СТАНДАРТАД НИЙЦСЭН БАЙХ.
------------------	------------------	---------------	---------------	--




ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ

<p>ҮНЭЛГЭЭЧИН БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ, ЭСХУЛ ЗАХИАЛАГЧТАЙ ХАРИЛЦАН БИЧГЭЭР ТОХИРОЛЦСОН;</p>	<p>ҮНЭЛГЭЭЧИН АЖИЛ ОЛГОГЧИЙН ДААЛГАСНЫ ДАГУУ ХӨРӨНГӨД ҮНЭЛГЭЭ ХИЙХ;</p>	<p>ХУУЛЬД ТУСГАЙЛАН ЗААСАН ТОХИОЛДОЛД ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ШИЙДВЭРЭЭР.</p>
--	---	---

НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ХӨНДСӨН ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭГ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛНЭ:

- аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн үнэлгээний зүйлийг санхүүгийн тайлагналын зорилгоор үнэлэхэд;
- төрийн болон орон нутгийн өмчийг хувьчлах, үл хөдлөх эд хөрөнгийг худалдах, зээлийн барьцаанд ашиглах, өр төлбөрт тооцоход;
- төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийг өөрчлөхөд;
- ашигт малтмалын болон газрын тосны орд, байгалийн хийн хөрөнгө болон байгалийн бусад баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулахад;
- хөрөнгийн үнэлгээний зүйлийг төрийн болон орон нутгийн хэрэгцээнд буцаан авахад;
- төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьцааг нийтэд санал болгон гаргах үед;




ХӨРӨНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ЖИГД ХАНГАСАН

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ, ҮНЭЛГЭЭЧНИЙ ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА, ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БАЙСНЫГ ӨӨРЧИЛСӨН.

Үйлчлүүлэгч, захиалагч, гуравдагч этгээд, үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээдийн хөрөнгийн үнэлгээнд оролцогч талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг зохицуулж, талуудын оролцоог жигд хангасан.

Захиалагч, гуравдагч этгээдийн үнэлгээний тайлантай танилцах, гомдол гаргах, бусад эрх, үүргийг хуульчилсан.



ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ОЛГОНО.

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГАЛТАД ТЭНЦСЭН ИРГЭНД ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЖ БАЙСНЫГ ӨӨРЧИЛСӨН.


ИРГЭНД ҮНЭЛГЭЭЧНИЙ ЭРХИЙГ ОЛГОНО.

- дээд боловсролтой, 2 ба түүнээс дээш жил ажилласан иргэн шалгалтад орох эрхтэй;
- шалгалтад тэнцсэн иргэнд 3 жилийн хугацаатай олгоно;
- 3 жилийн хугацаагаар сунгана; мэргэжлийн байгууллагаас олгоно;
- шаардлага хангасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд олгоно;
- хүлээх хариуцлагыг дээшлүүлсэн.

ҮНЭЛГЭЭНИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОНО.

- 2-оос доошгүй үндсэн орон тооны үнэлгээчинтэй хуулийн этгээд байна;
- захирал нь хугацаагүй эрхтэй үнэлгээчин байна;
- 5 жилийн хугацаатайгаар олгож, 5 жилээр сунгана;
- Сангийн сайд олгоно;
- Гадаадын иргэн, хуулийн этгээд үнэлгээний хуулийн этгээд байгуулах нөхцөл шаардлагыг тусгасан;
- хүлээх хариуцлагыг дээшлүүлсэн.

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭГ ӨРГӨЖҮҮЛСЭН




ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН САН



МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГАД ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ШИЛЖҮҮЛСЭН

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА



НИЙТИЙН ЭРХ
ЗҮЙН ХУУЛИЙН
ЭТГЭЭД

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

- Үнэлгээний олон улсын стандартыг орчуулж, стандартын хэрэглээний тайлбар гаргана.
- Үндэсний үнэлгээний стандартыг боловсруулж батлуулна.
- Үнэлгээчнийг сургаж, мэргэшүүлэн, мэдээллээр хангана.
- Үнэлгээчний ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлнэ.
- Үнэлгээний тайлантай холбоотой маргаан гомдлыг хянан шийдвэрлэнэ.

1.7. ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН
ОГНОО

2022.06.17

ХУУЛЬ САНААЧИЛСАН

УИХ-ын гишүүн С.Бямбацогт нарын 22 гишүүнээс 2019.03.29, Засгийн газраас 2019.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн.

ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА

2023.01.01

ХУУЛЬД ШИНЭЭР БОЛОН НАРИЙВЧЛАН ТУСГАСАН ЗОХИЦУУЛАЛТ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ, ШИНЭЭР БИЙ БОЛГОХОД БАРИМТЛАХ ЗАРЧИМ:



хуульд зааснаас бусад тохиолдолд Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, тэрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээд аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг **хориглоно**;

төрийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд зөвшөөрлийг шинээр бий болгосон, олгосон, эрх шилжүүлсэн бол хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болох бөгөөд үүсэх үр дагаврыг зөвшөөрлийг шинээр бий болгосон, олгосон, эрх шилжүүлсэн этгээд **харуцна**;

Засгийн газар үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, нийтийн ашиг сонирхол, үр ашигтай өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх үүднээс төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээдээс олгодог зөвшөөрлийг олгох үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар **хязгаарлалт хийнэ**;

зөвшөөрөл эзэмшиж байгаагай нь холбогдуулан зөвшөөрөл эзэмшигчийн тодорхой эрхийн хязгаарлалтыг **хуулиар тогтооно**;


зөвшөөрлийг шинээр бий болгоход тухайн үйл ажиллагааг төрөөс зохицуулах шаардлагатай эсэх, зохицуулалтын зохистой арга хэрэгсэл мөн эсэх, нийгэм, эдийн засгийн хувьд үр ашигтай байх эсэхэд судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ;

хуульд заасан зөвшөөрлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэх, хуулиар эрх олгосноос бусад тохиолдолд захиргааны хэм хэмжээний акт **гаргахыг хориглоно**;

зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой **дүрэм, журам гаргахыг хориглоно**.




ЗӨВШӨӨРЛИЙН АНГИЛАЛ, ХУГАЦАА:

 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
5 ЖИЛЭЭС ДООШГУЙ

 ЭНГИЙН ЗӨВШӨӨРӨЛ
3 ЖИЛЭЭС ДООШГУЙ



 байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулах зөвшөөрлийг хугацаатай олгоно;
байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахаас бусад зөвшөөрлийг хуульд заасан тохиолдолд хугацаагүй олгоно;
хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхлэх нэмэлт үйл ажиллагааны хугацаа нь тусгай зөвшөөрлийн хугацаатай адил байна.



ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:

- хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд зөвшөөрөл олгох бүрэн эрхээ бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно;
- зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргах баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явцыг зөвшөөрөл хүсэгч, зөвшөөрөл эзэмшигчид цахим хэлбэрээр, нээлттэй, ил тод байлгах;
- зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох тухай шийдвэрийг хуульд заасан хугацаанд гаргана.

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ:

Хуульд заасан тохиолдолд эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох эрхээ төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан, эсхүл Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1.3-т заасан холбоо /төрийн бус байгууллага/, мөн хуулийн 7.1.7-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд шилжүүлж болно.

Эрх шилжүүлэн авсан этгээд энэ хуульд заасан зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн эрхийг эдэлж, үүргийг хэрэгжүүлэх, зөвшөөрөл олгох эрхийг хууль бусаар шилжүүлсний улмаас бусдад учирсан хохирлыг тухайн эрх шилжүүлсэн этгээд хариуцахаар зохицуулсан.










ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ ГАРГАХ:

• иргэн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гаргах нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан байх;







• эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийн үндсэн дээрх эрхлэх нэмэлт зөвшөөрөл хүссэн өргөдөлд тусгай зөвшөөрлийг авахад бүрдүүлсэн баримт бичгийг дахин шаардахгүй байх;

• цахим хэлбэрээр гаргасан зөвшөөрөл хүссэн өргөдлийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 13.3-т заасны дагуу бичгээр гаргасан хүсэлт гэж үзнэ.


ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ:

	зөвшөөрөл хүссэн өргөдлийг ажлын 22 өдөр буюу хуанлийн 30 хоногийн дотор шийдвэрлэнэ;		өргөдлийг цахимаар шийдвэрлэнэ;
	өргөдлийг шийдвэрлэх хүртлэх явцын мэдээллийг өргөдөл гаргагч иргэн, аж ахуйн нэгж цахимаар танилцаж, хянах боломжтой;		зөвшөөрөл хүссэн иргэн, аж ахуйн нэгжээс төрд байгаа мэдээллийг шаардахгүй;
	зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг болон хуульд заасан шаардлагын дагуу нэмэлт магадлан шалгах ажиллагааг тодруулах 22 өдрийн дотор багтаан явуулна;		
	хуулийн хугацаанд өргөдлийг шийдвэрлээгүй тохиолдолд хугацаа дууссанаас хойш гурван хоногийн дотор энгийн зөвшөөрлийг олгох шийдвэрийг эрх бүхий этгээд гаргах үүрэгтэй;		
	хуульд заасан хугацаанд хариу өгөөгүй нь холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл болно.		


ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СУНГАХ:

	Зөвшөөрөл сунгах өргөдлийг ажлын 17 өдөр буюу хуанлийн 23 хоногийн дотор шийдвэрлэнэ;
	Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд зөвшөөрлийн хугацаа дуусахаас 45 хоногийн өмнө түүнийг сунгуулах талаарх мэдээллийг зөвшөөрөл эзэмшигчид цахим шуудангаар, эсхүл шуудангийн хаягаар мэдэгдэнэ;
	Зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногоос доошгүй хугацааны өмнө зөвшөөрлийг сунгуулах өргөдлийг эрх бүхий этгээдэд гаргана;
	Эрх бүхий этгээд зөвшөөрлийг анх авахад бүрдүүлж өгсөн материалыг иргэн, аж ахуйн нэгжээс дахин шаардахгүй;
	Зөвшөөрөл эзэмшигч татварын өргүй, байнгын тогтвортой үйл ажиллагаа явуулж, ажлын байраа хадгалсан бол зөвшөөрлийн анх олгосон хугацааг хоёр дахин нэмэгдүүлж сунгана;
	Хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдөл гаргасан, холбогдох хууль тогтоомж зөрчөөгүй, хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа бол эрх бүхий этгээд хуульд заасан хугацаанд зөвшөөрлийн хугацааг сунгуулах өргөдлийн хариу өгөөгүй бол зөвшөөрлийн анх олгосон хугацаагаар сунгасанд тооцно.

ЗӨВШӨӨРЛИЙН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН:




ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН, СУНГАСАН, ТҮДГЭЛЗҮҮЛСЭН, СЭРГЭЭСЭН, ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ШИЙДВЭРИЙН ТАЛААРХ ЗӨВШӨӨРЛИЙН НЭГДСЭН САНТАЙ БАЙНА.




САНГ ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГА ХАРИУЦАН АЖИЛЛАНА.

ЗӨВШӨӨРЛИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГЫН ТАЛААР САНАЛ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ЗӨВЛӨЛ:


ЗӨВЛӨЛ НЬ ДАРГА, НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, 11 ГИШҮҮНЭЭС БҮРДЭХ БӨГӨӨД ЗӨВЛӨЛИЙГ ЕРӨНХИЙ САЙД ТЭРГҮҮЛНЭ.




ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭНЭ.




ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, БҮРТГЭХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ, ЭНЭ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГЫН ТАЛААР САНАЛ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ТӨР, ХУВИЙН ХЭВШИЛ, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛЛӨӨС БҮРДСЭН ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ ЕРӨНХИЙ САЙДЫН ДЭРГЭД АЖИЛЛАНА.




ХУУЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ:




МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ЗӨВШӨӨРӨЛТЭЙГӨӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, ЖАГСААЛТ БОЛОН ЭДГЭЭРТЭЙ ХОЛБОГДОХ СУУРЬ ХАРИЛЦАА ТОДОРХОЙ БОЛСОН;



ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧ, ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ ЦЭГЦЭЙ МЕХАНИЗМЫГ БҮРДҮҮЛЭХ;



ЗӨВШӨӨРЛИЙН ХАРИЛЦААГ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ, ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХААР ХУУЛЬЧИЛСАН НЬ ИРГЭДЭД ЧИРЭГДЭЛ, ХҮНД СУРТАЛГҮЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХ;



АВИЛГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ БУУРЧ, ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ХҮНД СУРТАЛ БАГАСЧ, ОЛОН УЛС ДАХЬ АВЛИГЫН ИНДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД МЭДЭГДЭХҮЙЦ САЙЖИРНА.

1.8. ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН
ОГНОО

2022.06.28

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас 2022.05.04-ний өдөр өргөн
мэдүүлсэн.

ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА

Ердийн
журмаар



ХУУЛЬД ТУСГАСАН ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТ

Үндэсний их баяр наадмыг жил бүр, аймаг, сумын баяр наадмыг 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд, улсын баяр наадмыг 07 дугаар сарын 11, 12, 13-ны өдрүүдэд улс орон даяар нэгэн зэрэг тэмдэглэнэ;

Үндэсний их баяр наадам нь өөрийн билэгдэл (барааны тэмдэг)-тэй байна. Хэрэглэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж мөрдүүлнэ.

ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААН

Монгол Улсын Ерөнхийлөгч зохион байгуулах хорооны саналыг үндэслэн бөх, сур болон, шагайн харваачид, уяачдад улсын цолыг олгоно;

Улсын баяр наадмын бөхийн барилдаанд барилдах бөх 16 насанд хүрсэн байна. Улсын баяр наадамд түрүүлсэн, үзүүлсэн бөхийн эрэмбийг бөхийн холбооны дүрмээр зохицуулна.

ХУРДАН МОРИНЫ УРАЛДААН

Үндэсний хурдан морины уралдаанд уралдах морийг найм, түүнээс дээш насны хүүхэд унах;

Үндэсний хурдан морины уралдаан болон морины сунгаа, бэлтгэлийн үеийг хамруулсан нэг жилийн хугацаанд хүүхдийг ослын даатгалд даатгуулж, даатгал болон стандартын шаардлага хангасан хамгаалалтын хувцас, хэрэглэл хэрэглэж байгаа эсэхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина;

Засгийн газрын шийдвэрээр нэгэн зэрэг дөрөв хүртэлх бүсэд хурдан морины шигшмэл уралдааныг зохион байгуулж болно;



Үндэсний их баяр наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулж болно;

Монгол үүлдрийн адууны стандартыг шинэчлэн боловсруулж, батлуулах хүртэл хугацаанд Үндэсний их бар наадмын хурдан морины уралдааныг Засгийн газраас баталсан дүрмээр зохицуулна.

ДОПИНГИЙН ШИНЖИЛГЭЭ

Олон улсын допингийн эсрэг агентлагаас баталсан допингийн хориглосон жагсаалтад багтсан бодис, аргыг үндэсний бөх, сурын харваач хэрэглэхийг хориглоно;


Бөх, сурын харваачаас допингийн шинжилгээ хийх арга хэмжээг Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага зохион байгуулна;

Бөх болон сурын харваач допингийн төрлийн бодис хэрэглэсэн бол Үндэсний их баяр наадамд барилдах бөх, сурын харваачийн харвах эрхийг Дэлхийн допингийн эсрэг дүрэм, эсхүл Допингийн эсрэг үндэсний дүрэмд заасны дагуу хасах;

Шинжилгээгээр бөх, сурын харваач допинг хэрэглэсэн нь тогтоогдсон бол тухайн баяр наадамд олгосон цол, чимэг, байрыг хурааж, тухайн даваанд унасан бөх, удаалсан сурын харваачид улсын цолыг нөхөн олгох саналыг зохион байгуулах хороо Монгол Улсын Ерөнхийлөгчид гаргана;

Бөх, сурын харваач допинг хэрэглэсэн нь тогтоогдсон бол тухайн бөх, сурын харваачийн дасгалжуулагчийн эрхийг хоёр жилийн хугацаанд түдгэлзүүлэх саналыг зохион байгуулах хороо эрх бүхий этгээдэд гарган шийдвэрлүүлнэ;

Дэлхийн допингийн эсрэг агентлагаар итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтээр хориглосон бодис, арга хэрэглэсэн нь илэрсэн бөх, харваач "В" дээжид шинжилгээ хийлгэх бол уг шинжилгээний төлбөрийг өөрөө төлнө.



1.9. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**
2022.07.01

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас 2021.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн.

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨРӨЛ

- хууль зүйн зөвлөгөө өгөх;
- өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх;
- эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх.



ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ХЭЛБЭР

- хууль зүйн асуудлаар биечлэн, цахимаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулах.

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААГ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ АВАХ ХҮН

- Хүний бэлгийн эрх чөлөө, ялгаварлан гадуурхах, хүүхдийн эсрэг гэмт хэргийн 18 насанд хүрээгүй хохирогч хүүхэд;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хүн худалдаалах гэмт хэргийн 18 насанд хүрээгүй хохирогч
- Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан;
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд.
- Үл хөдлөх эд хөрөнгө, газар өмчлөх эрх нь зөрчигдсөн захиргааны хэргийн оролцогч төлбөрийн чадваргүй иргэн;



Хүүхдийн эцэг, эх, хүүхэд хамгаалах байгууллага, мөрдөгч, прокурор, шүүгчийн хүсэлтээр өмгөөллийн үйлчилгээг хүүхдэд үнэ төлбөргүй үзүүлж болно:

- гэмт хэргийн гэрч хүүхэд;
- гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсөн хүүхэд.

Гэрч, хохирогчид хүсэлтийн дагуу дарах иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлж болно:

- Ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн
- Олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх
- Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүн.



ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;



Тухайн иргэний өргөдөл болон баг, хорооны Засаг даргын тодорхойлолт, бусад нотлох баримтаар тогтоогдсон иргэн.

ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- Мэдээллийн нэгдсэн санд бүртгэлгүй үйлчлүүлэгчийн хувьд баг, хорооны Засаг даргын тодорхойлолт, бусад нотлох баримт бичиг;
- Ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувьд холбогдох нотлох баримт бичиг;
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд бол эрх бүхий байгууллагын тодорхойлолт;
- гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгчийн хүсэлт;
- гэрч, хохирогчийн хүсэлт.

ХУУЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх тогтолцоог бүрдүүлж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах эрхийг баталгаажуулах, тэдний хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эрхээ хамгаалуулах, иргэний үндсэн эрхийн баталгааг хангахад чухал ач холбогдолтой.

1.10. ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2022.07.05

ХУУЛЬ САНААЧИЛСАН

УИХ-ын гишүүн С.Бямбацогт нарын 14 гишүүнээс 2022.03.29, Засгийн газраас 2019.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн.

**ДАГАН МӨРДӨХ
ХУГАЦАА**

2022.08.01

ПАРКИЙН ХЭЛБЭР

Паркийн удирдлага нь төрийн

орон нутгийн өмчит,

хувийн өмчит, бусад гэсэн хэлбэртэй байна.

ПАРКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Засгийн газар паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын саналыг үндэслэн олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгоно;

Паркийн тусгай зөвшөөрлийн хугацаа 15 жил байна; Дээрх хугацаагаар нэг удаа сунгаж болно.

ПАРКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ҮЗҮҮЛЭХ ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ

Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах шийдвэрийг Засгийн газар гаргана;

Татвар төлөх хугацааг сунгасан хугацаанд үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгж өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.

1.11. СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2022.07.05

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас 2021.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн.

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

2023.01.01

ХУУЛИЙН ЗОРИЛТ

Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, түүгээр үйлчлэх, хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулж, архидаан согтуурахаас урьдчилан сэргийлэх, архидаан согтуурахтай тэмцэхэд чиглэсэн.



ХУУЛЬД ТУСГАСАН ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТ

- Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны үндсэн дээр олгох ба ингэхдээ хүн амын нягтрал, байршил, үйлдвэрийн хүчин чадлыг харгалзан тусгай зөвшөөрлийн тоог Засгийн газар тогтоох;
- Согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нар тус тус олгож, сунгаж, түдгэлзүүлж, сэргээж, хүчингүй болгох;
- Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэл болон холбогдох бусад мэдээллийг агуулсан мэдээллийн цахим сантай байх, мэдээллийн цахим сан нь татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, гаалийн үйл ажиллагааны мэдээллийн сантай холбогдсон байх;
- Монгол Улсад үйлдвэрлэсэн болон импортлосон, чөлөөт бүс, татваргүй барааны дэлгүүрт оруулсан бүх төрлийн согтууруулах ундааг үйлдвэрлэл, импорт, борлуулалтын үе шат бүрээр эцсийн хэрэглэгч хүртэл олон улсын стандартад нийцсэн дахин давтагдашгүй, цахим өгөгдөл бүхий код ашиглан цахим төлбөрийн баримт, гаалийн мэдүүлэгт үндэслэн татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх;
- Архидаан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд таниулан сурталчлах, согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээг нэвтрүүлэх, согтуурах, мансуурах дон болон дэлгэцэд донтох эмгэгтэй хүмүүст хүргэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, архидаан согтуурахтай тэмцэх, согтууруулах ундааны хор уршиг, хэрэглээний эсрэг бусад үйл ажиллагааг санхүүжүүлэх Архидаан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сантай байх;
- Согтууруулах ундааны зохистой хэрэглээ болон иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бусдад үйлчлэх үүрэг бүхий ажилтан нь согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтад заавал хамрагдсан байх;
- Дэлхий нийтийн жишиг, хүний биеийн онцлог, хуулийн хэрэгжилтийг нэг мөр хангах нөхцөл болон бусад эрх зүйн зохицуулалтыг харгалзан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх насыг 21 байхаар хуульчиллаа.



2.НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

2.1.ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2022.04.15	ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2022.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	---	--

1921 оны Ардын хувьсгалын үр дүнд Монгол орон тусгаар тогтнолоо зарлаж, Засгийн газраа эмхлэн таван яам байгуулсны нэг нь Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Цэргийн явдлын яам байсан бөгөөд тус яамны бүтцэд “Оператив-тагнуулын хэлтэс”-ийг анх үүсгэн байгуулсан нь орчин цагийн Цэргийн тагнуулын байгууллагын үндэс суурийг тавьсан байдаг.

100 жилийн түүхтэй Цэргийн тагнуулын байгууллага 2015 онд батлагдсан Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд Тагнуулын ерөнхий газрын бүтцэд шилжсэн байдаг.

Олон улсын жишгээр Цэргийн тагнуулын байгууллага нь тухайн улс орныхоо Батлан хамгаалах яам, эсхүл Зэвсэгт хүчний Жанжин штабынхаа бүтцэд байдаг.

Энэ жишгийн дагуу Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Цэргийн тагнуулын байгууллагыг Зэвсэгт хүчний жанжин штабын бүтцэд эргүүлэн авч байгаагаараа онцлог.

Цэргийн тагнуулын газар нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхолд нийцсэн цэрэг-улс төрийн тагнуулын мэдээллээр төр, засгийн болон Зэвсэгт хүчний удирдлагыг шуурхай, тасралтгүй хангах, тагнуул-судалгааны ажлыг зохион байгуулж, явуулах үндсэн үүрэгтэй байгууллага юм.

Түүнчлэн Цэргийн тагнуулын байгууллагыг Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчтай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газар байгуулж, өөрчилж, татан буулгах, Цэргийн тагнуулын байгууллагын даргыг Тагнуулын ерөнхий газрын даргад танилцуулж, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга томилох, мөн тус байгууллагын дүрэм, ажиллах журмыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга болон Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар батлах зохицуулалтуудыг хуульд тусгалаа.

Хууль батлагдсанаар Цэргийн тагнуулын байгууллагын эрх зүйн үндэс, чиг үүрэг тодорхой болж, Цэргийн тагнуулын байгууллагын тогтолцоо шинэчлэгдэн Зэвсэгт хүчин хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх чадавх нэмэгдэнэ.

2.2. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИУДЫН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2022.04.22	ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2022.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	--	--

Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгасан. Үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд тодорхойлсон нэр томъёотой бусад хууль тогтоомжийн нэр томъёог нийцүүлж, жигдлэх;
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан орон нутгийн чиг үүрэг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэрэгжүүлэх чиг үүрэг мөн нэгж дэх нутгийн өөрийн удирдлага болон төрийн удирдлагын эрх хэмжээ, бүрэн эрхтэй уялдуулан зарим харилцааг салбарын бусад хууль тогтоомжид тодруулах, нарийвчлан тусгах, зөрчилдөж байгаа зохицуулалтыг нийцүүлэх;
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг нэг мөр хангахад чиглэсэн бусад нэмэлт, өөрчлөлтийг тусгасан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай бусад хуулийг нийцүүлэх зорилгоор дараах гол агуулгаар хуулиудад өөрчлөлт оруулсан:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын зарчмын нэг өөрчлөлт бол орон нутгийг бие даалгах, эдийн засаг, нийгмийн асуудлаа шийдвэрлэх эдийн засаг, нийгмийн цогцолбор болон хөгжихөд түүний эдийн засаг, санхүүгийн үндсийг бүрдүүлэх;
- Иргэдэд хамгийн ойр нэгж болох баг, хорооны эрх зүйн байдлыг тодорхой болгох, энэ хүрээнд баг, хороо эрх зүйн харилцаанд оролцох эрх зүйн үндсийг бий болгох, баг хороонд нутгийн өөрийн удирдлагын бусад хэлбэрийг хэрэгжүүлэх, Үндсэн хуульд заасан зарчмын хүрээнд өдөр тутмынхаа тулгамдсан асуудлыг өөрсдөө бие дааж шийдвэрлэх, шийдвэрийн үр нөлөө, хүчин чадлыг дээшлүүлэх боломжийг бий болгох;
- Сум, дүүрэг нь орон нутгийн өөрийн удирдлагын бие даасан цөм (суурь) нэгж байж, иргэдийн амьдралын тулгамдсан асуудлууд, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн зорилтыг шийдвэрлэх чиг үүрэг, бүрэн эрхтэй байх, үүнтэй холбоотойгоор энэ хуулиар бий болох орон нутгийн чиг үүргийг голлон хэрэгжүүлэх нэгж нь байх зэргээр нутгийн өөрийн удирдлагыг иргэдэд илүү ойр нэгжид төвлөрүүлэх зэрэг гол үзэл баримтлал, зарчмыг алдагдуулахгүй байхыг хангах.

2.3. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2022.04.22	ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2021.05.12-ны өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАН МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	--	--

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд дараах онцлог зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор дүрс бичлэгийн техник хэрэгсэл буюу камержуулалтын нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлэх, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд зарцуулах санхүүжилтийн эрх зүйн орчныг тодорхой болгох үүднээс Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-д тодорхой торгох ял, зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хөрөнгийг дээрх арга хэмжээнд зарцуулах, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хөрөнгийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээнд зарцуулдаг байх талаар зохицуулалтыг хуульчлав.

Дүрс бичлэгийн техник хэрэгсэл буюу камержуулалтын нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлэх, түүнчлэн зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд зарцуулах хөрөнгийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцад төвлөрүүлэн хуваарилж, санхүүжүүлэх агуулга бүхий зохицуулалтыг тусгав.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар нутгийн захиргааны бүх шатны байгууллага болон хуулийн этгээдийн хүлээх үүрэгт харьяа нутаг дэвсгэрт орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгсэлд байнгын хяналт тавьж, арчлалт, хамгаалалтыг хариуцах агуулга бүхий зохицуулалтыг шинээр тусгасан.

Мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөлийн ажлын албаны албан хаагчдын статус болон санхүүжилтийн эрх зүйн орчныг бүрдүүллээ.

Энэ хууль батлагдсанаар камержуулалтын нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдэж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах, амар тайван амьдрах нөхцөл сайжирч, гэмт хэргийн гаралтыг бууруулах, гэмт хэргийг илрүүлэх ажилд эерэг үр дүн гарах ач холбогдолтой.

2.4. МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2022.04.29

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас 2022.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн.

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 15,526.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 33.3 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 17,913.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 38.4 хувь болж, нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал 2,387.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5.1 хувьтай тэнцүү байхаар батлагдлаа.

Төсвийн тодотголоор өмнө батлагдан хэрэгжиж байсан хуульд дараах өөрчлөлтүүдийг тусган баталлаа. Үүнд:

1) Төвлөрлийг сааруулах зорилгоор нийслэлээс үйлдвэр, агуулахаа нүүлгэсэн аж ахуйн нэгжийн зардлыг 50 хувиар нэмэгдүүлж тооцон, албан татвар ногдох орлогоос хасах, орон нутагт барилга байгууламж барьж ашиглалтад оруулсан бол элэгдэл, хорогдлыг 15 жилийн хугацаанд тооцох, орон нутагт үйл ажиллагаа шинээр эхлүүлсэн дулаан, цахилгааны төслийг эхний 3 жилд 90 хувь, дараагийн 3 жил 50 хувиар аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, орон нутагт идэвхтэй ажил хайгч иргэнийг 12 сарын хугацаанд авч ажиллуулсан тохиолдолд цалингийн зардлыг 20 хувиар нэмэгдүүлж татвараас хасч тооцох зэргээр бизнес эрхлэгчдийг орон нутагт үйл ажиллагаа явуулах сонирхлыг татварын бодлоготой хослуулах арга хэмжээ авахаар боллоо;

2) Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг 2022 оны 01 сарын 31-ний өдөр баталсан тодотголоор нийт 1431 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 6,292,735.7 сая төгрөгөөр, 2022 онд санхүүжих дүнг 1,894,634.2 сая төгрөгөөр баталж байсан бол эдгээр төсөл, арга хэмжээнээс өмнөх онуудад болон 2022 онд гэрээ байгуулсан, улмаар 2022 онд хэрэгжиж дуусах төсөл, арга хэмжээг хэвээр үлдээн 2022 онд бүрэн дуусгаж, ашиглалтад оруулах, мөн нэн шаардлагатай бус, хэрэгжилтийг хойшлуулж болох зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хасах, түүнчлэн зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, гүйцэтгэлтэй уялдуулан 2022 оны санхүүжих дүнд зохицуулалт хийх зэрэг өөрчлөлтийг оруулж баталлаа.

Ийнхүү 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан тодотголоор нийт 6,152,324.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 1,393,755.5 сая төгрөгөөр 2022 онд санхүүжих дүнтэй нийт 1376 төсөл, арга хэмжээг 2022 оны төсвийн жилд улсын төсвөөс санхүүжүүлж, хэрэгжүүлэхээр боллоо;

3) Хүүхдийн хуримтлалыг 2022 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал бэлэн мөнгөөр авах боломжийг нээж өглөө. Ингэснээр өмнө баталснаас 365.4 тэрбум төгрөг нэмж зарцуулах юм;

4) Импортоос хамааралтай гол нэрийн зарим хүнсний бүтээгдэхүүний үнийн эрсдэлийг бууруулах зорилгоор цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тосыг импортын гаалийн албан татвараас, мөн дотоодын түүхий эдээр үйлдвэрлэсэн ургамлын тос, дотоодын хүнсний үйлдвэрт борлуулсан ургамлын тосыг НӨАТ-аас тус тус 2023 оныг хүртэл чөлөөлөхөөр боллоо;

5) Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалингийн шатлалыг 5 дугаар шатлалд шилжүүлэн ахиулахаар боллоо. Энэ цалингийн нэмэгдэлд 34.0 тэрбум төгрөг зарцуулах юм;

6) Төрийн өмчийн оролцоотой 25 компани болон “Төрийн банк”-ыг хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах нь зүйтэй гэж үзэн холбогдох тогтоолыг баталлаа;

7) Гашуунсухайт боомтоор нэвтрэх машины тоог нэмэгдүүлэх, Шивээхүрэнгийн боомтыг ойрын хугацаанд нээж хэвийн горимд шилжүүлэх замаар 2022 оны төсвийн жилд 18.0 сая тонн нүүрс экспортлохоор тооцлоо;


8) Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталж, хэрэгжүүлснээр 39 тэрбум төгрөгийг төсвөөс хэмнэхээр тооцлоо;

9) Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн 1.0 сая төгрөг болон түүнээс доош цалинтай иргэдийн 5-12 дугаар сард төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн хураамжийн 50 хувийг буцаан олгох шийдвэр гаргалаа. Үүнд 2022 оны төсвийн жилд 150.8 тэрбум төгрөг зарцуулах юм;

10) Цэцэрлэгийн хүртээмж багатай, төрийн өмчийн цэцэрлэгт нэмэлт элсэлт авах боломжгүй байршилд төрийн бус өмчийн цэцэрлэг ажиллуулж, хамран сургах тойргийн хүүхдийг элсүүлсэн тохиолдолд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг 2 дахин нэмэгдүүлсэн дүнгээр хүүхдийн хоолны зардлын хамт санхүүжүүлэхээр боллоо. Энэ арга хэмжээнд 100 тэрбум төгрөг зарцуулах юм;

11) Орон нутагт анх удаа орон сууц худалдан авсан иргэдийн ипотекийн зээлийн хүүгийн төлбөрийн 50 хувийг төсвөөс санхүүжүүлэх, орон сууцны урьдчилгаа төлбөрийн 60 хувьд Зээлийн батлан даалтын сангаас баталгаа гаргахаар боллоо. Энэ арга хэмжээнд 30.1 тэрбум төгрөгийн хэмжээтэй татаас зарцуулна.

2.5.МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ЗАРИМ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА



Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн зургаан хуулийн төслийг эцэслэн баталлаа.

Эдгээр хуулиудад дараах зарчмын зохицуулалтуудыг тусгасан.

1) Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиар:

Дэлхийн үр тарианы экспортын дийлэнх хувийг хангадаг Оросын Холбооны Улс болон Украин улсын хооронд үүсээд байгаа тогтворгүй нөхцөл байдлаас шалтгаалж улс хооронд хүнсний ургамлын тос, элсэн чихэр, цагаан будааны хомсдолд орж болзошгүй нөхцөл байдал үүссэн.

Иймд Монгол Улсын хувьд импортоос хамааралтай хүнсний гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүн болох хүнсний ургамлын тос, элсэн чихэр, цагаан будааны үнийн өсөлтийн дарамтаас сэргийлэх зорилгоор дээрх нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг импортын гаалийн албан татвараас 2023 он хүртэл чөлөөлөхөөр болов.

2) Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиар:

Монгол Улс ургамлын тосны боловсруулах зургаан аж ахуйн нэгж байгаагаас хоёр үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Олон улсад үүсээд байгаа нөхцөл байдлаас шалтгаалж богино хугацааны ургамлын тосны нийлүүлэлт дэлхийн хэмжээнд доголдох эрсдэлтэй гэж үзсэн.

Иймд ургамлын тосны импортын хамаарлыг бууруулах, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт дотоодын түүхий эдээр үйлдвэрлэсэн ургамлын тос, дотоодын хүнсний үйлдвэрт борлуулсан хүнсний зориулалттай тосны ургамлыг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2022 оныг дуустал чөлөөлөхөөр болов.

3) Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар:

Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор шат дараатай арга хэмжээ авахаар тусгасан.

Энэ ажлын хүрээнд орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр дулаан, цахилгаан үйлдвэрлэх шинэ төслүүдийг орлого олж эхэлснээс хойш 3 жилийн хугацаанд 90 хувиар, дараагийн 3 жилд 50 хувиар орлогын татвараас хөнгөлөх боломж бүрдсэн.

Түүнчлэн нийслэл хотоос орон нутагт үйлдвэр, агуулахаа нүүлгэх, орон нутагт шинээр бизнес эрхлэхэд татварын хөнгөлөлт үзүүлэх, аж ахуйн нэгжүүд орон нутагт шинээр үл хөдлөх эд хөрөнгө бий болгож бизнесийн үйл ажиллагаа эрхлэхийг дэмжих, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн түвшинг бууруулах зорилгоор ажил хайгчдыг ажлын байраар хангасан аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэхээр боллоо.

4) Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар:

Төрийн өмчийн үр өгөөжийг дээшлүүлж, төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх үүднээс төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг нээлттэй хувьцаат компани болгон олон нийтийн хяналтад оруулахаар зохицуулсан.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхдээ аливаа этгээд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг, улс төрд нөлөө бүхий этгээд, түүний хамаарал бүхий этгээд нээлттэй арилжаалах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьцаа эзэмшихийг тус тус хориглохоор заав.

5) Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар:

2022 оноос орон нутаг хагас бие даасан тогтолцоонд шилжиж, гүйцэтгэлийн үр дүнгийн санхүүжилтээр улсын төсвөөс шууд санхүүжих болсон боловсрол, соёлын байгууллагуудын хувьд байрны үйлчилгээтэй холбоотой чиг үүргийг байгууллагын үндсэн бүтцээс салгаж, орон нутаг руу шилжүүлснээр ТҮ1-ТҮ3 зэрэглэлээр цалинждаг үйлчилгээний ажилчдын цалин хөлсийг орон нутгаас олгож байгаа бол тухайн байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг албан хаагчдын цалин хөлсийг улсын төсвөөс буюу тухайн байгууллагын төсвөөс олгож байна.

Иймд дээрх байгууллагын албан хаагчдын цалинг ялгаатай эх үүсвэрээс олгодог болсноор салбарын хэмжээнд ажиллагсдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, түүнтэй уялдсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж байгаа тул үйлчилгээний албан хаагчдыг үндсэн байгууллагадаа харьяалагддаг байх өөрчлөлтийг баталсан.

6) Монгол Улсын Засгийг газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар:

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хамт баталлаа.

Уг хуулиар төрийн бүх шатанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг зогсоох үүднээс зөвхөн төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг нэг дэд даргатай байхаар баталлаа.

2.6. ОЗОНЫ ҮЕ ДАВХАРГЫГ ЗАДАЛДАГ БОДИСЫН ТУХАЙ МОНРЕАЛИЙН ПРОТОКОЛД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИУДЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдөр өргөн мэдүүлсэн Протоколд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж соёрхон баталсан.

Протоколд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд дараах зарчмын шинжтэй зохицуулалтуудыг тусгасан. Үүнд:

1) Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд “Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн Протокол”-ын Кигалийн нэмэлт, өөрчлөлтөөр Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодисын хэрэглээг үе шаттай бууруулахтай холбогдуулан “дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис” гэдэг шинэ нэр томъёог нэмж тусгасан.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах, хязгаар тогтооход хяналт тавих асуудлыг хэрэгжүүлэхээр тусгасан.

Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис импортлох тоо хэмжээг аж ахуйн нэгж, байгууллагуудад хуваарилах ямар нэгэн батлагдсан аргачлалгүй байсныг тодорхой болгож, холбогдох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар хуульчиллаа.

Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг тухайн жилд импортлох, худалдсан, ашигласан, үйлдвэрлэсэн тухай тайлан, мэдээллийг гаалийн байгууллага болон импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэн жил бүр төрийн захиргааны төв байгууллагад ирүүлдэг байх зохицуулалтыг тусгасан болно.

Ингэснээр тухайн бодис, тоног төхөөрөмжийн импорт, худалдаа, ашиглалтад хяналт тавих нөхцөл бүрдэх юм.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан мэргэжлийн байгууллагууд озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодисыг системээс юүлэх, цэвэрлэх, дахин боловсруулах, дахин цэнэглэх, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг суурилуулах, ашиглах, засвар үйлчилгээ хийх, устгах үйл ажиллагааг эрхлэх бөгөөд мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, эрх олгох журмыг Засгийн газрын гишүүн батлах шинэ зохицуулалтыг тусгасан болно.

2) Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хариуцан гүйцэтгэх озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис агуулсан хөргөлт, агааржуулалтын системтэй барилга байгууламжийг байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн ангилалд хамруулах зохицуулалтыг нэмсэн болно.

Хууль батлагдсанаар хот суурин газруудад томоохон худалдаа, үйлчилгээний төв, үйлдвэрийн газар, орон сууцны хороолол, хотхонууд олноор баригдан хөргөлт, агааржуулалтын бодис, тоног төхөөрөмж ихээр ашиглах болсонтой холбогдуулан төсөл хэрэгжүүлэгчид байгаль орчны ерөнхий үнэлгээгээр дамжуулан зөвлөмж өгөх замаар болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин бүрдэх юм.

3) Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд озоны давхаргыг хамгаалах талаар бодлого, хөтөлбөр боловсруулах, холбогдох дүрэм, журмыг баталж, хэрэгжилтийг хангах асуудлыг нэмж тусгасан.

Байгаль орчны салбарын суурь хуульд озоны үе давхаргыг хамгаалах тухай асуудлыг тусган, агаарын тухай болон бусад холбогдох хуулиар зохицуулах боломжгүй асуудлыг энэ хуулиар зохицуулдаг байх эрх зүйн орчин бүрдсэн болно.

4) Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд шинээр барих барилгын зураг төсөлд хөргөлт, агааржуулалтын систем нь озон задалдаг бодисыг орлуулах бодис ашигласан байх шаардлагыг нэмж тусгалаа.

5) Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх зохицуулалтыг нэмсэн.

Мөн дээрх бодисыг системээс юүлэх, цэвэрлэх, дахин боловсруулах, дахин цэнэглэх, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах, засвар үйлчилгээ хийх, устгах үйл ажиллагааг мэргэшсэн, тусгай эрхтэй байгууллагууд тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх эрх зүйн орчин бүрдсэн болно.

6) Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгохдоо озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвараар нь хоёр ангилан, 675-аас их нүүрсхүчлийн хийн эквиваленттай тэнцэх орлуулах бодис бол 40000-100000 төгрөг, 675-аас ихгүй нүүрсхүчлийн хийн эквиваленттай тэнцэх орлуулах бодис бол 11000-27000 төгрөгийн тэмдэгтийн хураамж төлөхөөр хуульчиллаа.

Монгол Улс “Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн Протокол”-ын Кигалийн нэмэлт, өөрчлөлтөөр дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодисын хэрэглээг үе шаттай бууруулах, олон улсаас тогтоосон хуваарийн дагуу гидро фторт нүүрстөрөгч (ГФН)-ийн төрлийн бодисын хэрэглээг бууруулах үүрэг хүлээсэнтэй холбогдуулан Улсын Их Хурал ийнхүү холбогдох хуулиудад зохих нэмэлт, өөрчлөлтийг орууллаа.



“Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай
Монреалийн Протокол”-ын Кигалийн нэмэлт, өөрчлөлт



- Монгол Улс “Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн Протокол”-ын Кигалийн нэмэлт, өөрчлөлтөөр дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодисын хэрэглээг үе шаттай бууруулах, олон улсаас тогтоосон хуваарийн дагуу гидро фторт нүүрстөрөгч (ГФН)-ийн төрлийн бодисын хэрэглээг бууруулах үүрэг хүлээсэнтэй холбогдуулан Улсын Их Хурал холбогдох хуулиуддаа зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулсан болно.

2.7.УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН
ОГНОО

2022.06.03

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас 2022.03.11-ний өдөр өргөн
мэдүүлсэн.

ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА

Ердийн
журмаар

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь заалтад заасны дагуу иргэний үнэмлэхэд хязгаартай мэдээлэл буюу регистрийн дугаарыг ил харагдах бичилтээр бичиж байгаа эрх зүйн зохицуулалтыг өөрчилж иргэний биеийн давхцахгүй өгөгдөл болох улсын бүртгэлийн мэдээллийн сангаас өгөгдсөн 12 орон бүхий тоо болох иргэний бүртгэлийн дугаарыг иргэний бүртгэлийн холбогдох баримт бичигт ил харагдах бичилтээр тусгаж өгснөөр иргэний хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангана.

АЧ ХОЛБОГДОЛ



Иргэний оршин суугаа газрын хаягийн мэдээлэл иргэний үнэмлэхэд ил бичигдсэнээр бусад этгээд харах, иргэний хаягийн мэдээллийг ашиглан хохирол учруулах, иргэний хувийн аюулгүй байдал алдагдах зэрэг нөхцөл байдлыг бий болгосоор байна. Иймд иргэний улсын бүртгэлийн баримт бичгийн үнэн зөв байдлыг хангах, иргэнд эдийн засгийн аливаа дарамт, хүндрэл бэрхшээлийг учруулахгүй байх, эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэний оршин суугаа газрын хаягийн мэдээллийг иргэний үнэмлэхийн санах ойд тусгахаар заасан.

2.8.ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2022.06.03

ХУУЛЬ САНААЧИЛСАН

УИХ-ын гишүүн Б.Энхбаяр, Б.Пүрэвдорж,
Ц.Сандаг-Очир нарын гишүүдээс 2021.04.08-ны
өдөр өргөн мэдүүлсэн.

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ



1
Хэргийн бодит байдлыг тогтоох;

2
Оролцогчдын эрхийг хангах, хэргийг буруу тусгаарласан;

3
Мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай

4
Хууль буруу хэрэглэсэн алдааг засах, дутуу хийсэн мөрдөн шалгах ажиллагааг нөхөж хийх ажиллагааг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, 33.3 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд хэргийг прокурорт буцаах зохицуулалтыг хэвээр үлдээсэн.

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.7 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, 39.9 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 40.8 дугаар заалтын дагуу Шүүхийн шатанд болон давж заалдах, хяналтын шатны шүүхээс хэргийг прокурорт, эсхүл дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах заалтыг хүчингүй болгох зохицуулалтыг тусгасан



Ингэснээр шүүх, прокурорын байгууллагад улс төрд нөлөө бүхий этгээдээс дарамт шахалт үзүүлэх, авилга өгөхөөс урьдчилан сэргийлэх бөгөөд Үндсэн хуулиар баталгаажсан шүүхийн бие даасан байдлын зарчим, прокурор гадны нөлөөнд үл автах зарчим, гэм буруугийн зарчим, дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн шүүгдэгчийн гэм бурууг нэг л удаа шүүхээр эцэслэн шийдвэрлэх зарчмыг ноцтой зөрчиж, гэм буруутай этгээдэд ял завших боломж олгож буй хуулийн хийдлийг залруулах ач холбогдолтой.



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдлыг, мөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг нэг удаа 60 хүртэл хоногоор хойшлуулах зохицуулалтыг тусгасан.

2.9. ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

<p>БАТАЛСАН ОГНОО 2022.06.03</p>	<p>ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2022.03.28-ны өдөр өргөн мэдүүлсэн.</p>	<p>ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар</p>
--	---	--



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 59 дүгээр зарлигийн дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг улс орон даяар өрнүүлсэн.

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар Монгол орны ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ нэмэгдэж 2030 он гэхэд нийт газар нутгийн 9 хувьд хүргэх ногоон хөгжлийн зорилго хангагдах боломжтой боллоо.

ОЙН ТУХАЙ ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

<p>мод, бут, сөөг үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээхэд ашиглах ойн үр, үржлийн материалыг бэлтгэх, үйлдвэрлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, ойн үрийн улсын нөөцийн санг бий болгох, ойн үрийн шинжилгээг магадлан итгэмжлэгдсэн лабораторид хийх, чанарын гэрчилгээ олгох асуудлыг тусгасан.</p>	<p>гарал үүсэл нь тодорхойгүй, эсхүл итгэмжлэгдсэн лабораторид шинжлэгдээгүй, стандартын шаардлага хангаагүй ойн үрийг худалдах, импортлохыг хориглох, ойн үрийн үржлийн материал бэлтгэх, үйлдвэрлэх, худалдах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах асуудлыг тусгасан.</p>	<p>Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгуулагдсанаар ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, хяналт тавьж ажиллах боломжтой болсон.</p>
--	---	---

2.10. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2022.06.10	ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	--	--

Хуульд дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас тендерт оролцогч хувийн хэвшлийн санхүүгийн үйл ажиллагаанд учирсан хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах, тендер шалгаруулалтад оролцох боломжийг нэмэгдүүлэхэд нэн шаардлагатай зохицуулалтуудыг тусган баталлаа.

Хуулийн төсөл батлагдсанаар гүйцэтгэлийн баталгаагаа компаниуд шинэчлэн гаргах боломжтой болно.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хуулиар нэмэгдүүлэн баталсан бол захиалагч магадлалын дүгнэлтэд үндэслэн тухайн ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнэ, ажлын тоо хэмжээг нэмэгдүүлэн баталсан төсөвт өртөгт багтаан нэг удаа өөрчилж болохоор боллоо.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлдэг жил бүр давтагддаг ажил, зөвлөхийн бус үйлчилгээг нэгж үнэ болон бусад нөхцөлийг тухайн жилд нь худалдан авах ажиллагаа зарлахгүйгээр, гурав хүртэл жилийн хугацаанд тогтоосон тендер шалгаруулалт зохион байгуулан гэрээ байгуулах боломжийг бүрдүүллээ. Энэ нь хувийн хэвшилд гурав хүртэл жилээр гэрээ байгуулж, үйл ажиллагаагаа дунд хугацаанд төлөвлөх боломжийг бий болгох юм.

2.11. ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2022.06.17

ХУУЛЬ САНААЧИЛСАН

УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн, Ц.Туваан, Н.Учрал нарын гишүүдээс 2022. 05.06-ны өдөр өргөн мэдүүлсэн.

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**



ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХИЙН ХҮРЭЭНД




Цусны болон эс, эд, эрхтний донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан байгуулах, сангийн ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар;

цусны болон эс, эд, эрхтний амьд донорыг тухайн эзний зөвшөөрлийг үндэслэн олон нийтэд таниулах, алдаршуулах, амьгүй донор болон түүний гэр бүлд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг үндэслэн зохион байгуулахаар

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах асуудлаар мэргэжил, ёс зүйн хороо ажиллана. Тус хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тусгасан.

21 насанд хүрсэн иргэн эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлэн суулгахыг зөвшөөрсөн шийдвэрээ бие даан гаргах эрхтэй болсон;

сэтгэцийн хувьд эрүүл, 21 насанд хүрсэн, эс, эд, эрхтнээ өгөх тухай зөвшөөрлөө бичгээр гаргасан донороос түүний амь насанд аюул учруулахгүйгээр эмнэлгийн нөхцөлд эс, эд, эрхтнийг авах;



2.12. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2022.06.17

ХУУЛЬ САНААЧИЛСАН

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**

1

Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтны ял эдэлсэн хугацааг тоолохдоо шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болж, ялтанд цахим бугуйвч зүүлгэсэн өдрөөс эхэлж тоолох өөрчлөлтийг оруулсан.

2

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 1921-2015 оныг хүртэлх хугацаанд төрийн цэргийн байгуулалд хамаарч ирсэн төрийн цэргийн байгуулал, цэргийн албанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хамаарахгүй байхаар тусгасан. бөгөөд Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндсийг батлах тухай" болон 2016 оны Монгол Улсын батлан хамгаалах тухай, Цэргийн албаны тухай, Зэвсэгт хүчний тухай хуулиудад

Энэ нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал дахь дотоод аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг, оролцоо бүхий шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэж байгаа хэдий ч бусад цэргийн байгууллагын алба хаагчийн нэгэн адил Цэргийн албаны тухай хуулиар олгогдсон эрхийг эдэлж чадахгүй орхигдож эрх зүйн байдал дордох, алба хаагчийн эрх ашиг, сонирхол алдагдаж байсан тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 257 дугаар зүйлийн 257.1 дэх хэсгийн "төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий" гэснийг "тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн" гэж өөрчлөлт оруулж, үүнтэй холбогдуулан дээрх хууль, Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

3

"Цагдан хорих төв, байр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дэргэдэх мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн болон согтуурах, мансуурах донтох эмгэгтэй этгээдийг албадан эмчлэх байгууллагын ажилтныг хорих байгууллагын алба хаагчтай адилтган үзнэ." гэж заасан.

Энэ нь баривчлах төв болон баривчлах байранд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад хамаарахгүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын хуульд заасан эрх зүйн байдал харилцан адилгүй, ялгамжтай байдлаар зохицуулсан байх тул баривчлах төв болон байранд ажиллаж буй алба хаагчдыг хорих байгууллагын алба хаагчтай адилтган үзэх зохицуулалтыг оруулсан.

4

Шийдвэр гүйцэтгэгч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад тасралтгүй ажилласан боловч эрх зүйн шинэчлэлээс хамааран 2002-2018 онд ажилласан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцогдохгүй, уг хугацаанд оруулан тооцох хууль, эрх зүйн зохицуулалт байхгүйгээс тэдний эрх зүйн байдалд сөргөөр нөлөөлж, хуульд заасан тэтгэвэр тогтоолгох насны дээд хязгаарт хүрсэн шийдвэр гүйцэтгэгч нар 10-аас дээш жил цэргийн цолгүй энгийнээр ажилласан тул цэргийн алба хаасан хугацааны бүрэн тэтгэвэрт гарах боломжгүй нөхцөл байдал үүссэн.

Шийдвэр гүйцэтгэгчээр ажиллаж буй албан хаагчдын эрх байдлыг дордуулахгүйн тулд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл шийдвэр гүйцэтгэгчээр энгийнээр ажилласан хугацааг цэргийн албанд ажилласан хугацаанд тооцох тухай нэмэлтийг оруулсан.

Харин тус зохицуулалтад 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө цэргийн алба хаасны тэтгэвэр болон өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан иргэнд хамаарахгүй байхаар хуульчилсан.

2.13. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2022.07.01

ХУУЛЬ САНААЧИЛСАН

УИХ-ын гишүүн О.Цогтгэрэл нарын 9 гишүүнээс
2022. 05.18-ны өдөр өргөн мэдүүлсэн.

**ДАГАН МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үр дүнд Ардчилсан намаас 11 гишүүн сонгогдож, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлснийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын дарга танилцуулснаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж байсан.

Гэвч Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг, бүлгийн гишүүд, Ардчилсан намаас Улсын Их Хурлын даргад удаа дараа албан бичиг хүргүүлж, хоорондоо санал нэгдэхгүй, бүлгийн даргаа хүлээн зөвшөөрөхгүй, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан бүлгийн эрх, үүргээ хэрэгжүүлж чадахгүй байдалд нэлээд хугацаанд ажилласан байна.

Эдгээр асуудлыг нэг мөр болгох, бүлгийн дарга, гишүүдийн эрх, үүргийг тодорхой болгох зорилгоор хэрэв бүлгийн нийт гишүүдийн олонх бүлгийн даргыг чөлөөлөх, огцруулах, шинээр томилох талаар санал нэгдвэл шийдвэрээ Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлснийг нэгдсэн хуралдаанд сонсгосноор эрх, үүрэг хэрэгжих зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд тусгасан.

2.14. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**
2022.07.05

ХУУЛЬ САНААЧИЛСАН

УИХ-ын гишүүн Н.Учрал нарын 12 гишүүнээс
2022.07.01-ний өдөр өргөн мэдүүлсэн.

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Уг хуулиар Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаар саналаа Улсын Их Хурлын албан ёсны санал авах цахим хуудсаар дамжуулан гаргаж болох асуудлыг хуульчилсан.



Улсын Их Хурал төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж, шийдвэрлүүлэх эрхийг хангаж, шийдвэр гаргахдаа иргэдийн оролцоог хангах зорилгоор албан ёсоор санал авахаар байршуулснаас хойш 30 хоногийн хугацаанд

тодорхой асуудлаар
ажлын хэсэг
байгуулах саналыг
33 000 ба түүнээс
дээш тооны иргэд
дэмжсэн бол;

Байнгын хорооны
эрхлэх асуудлын
хүрээнд хяналт шалгалт
явуулах саналыг 70 000
ба түүнээс дээш тооны
иргэд дэмжсэн бол
Монгол Улсын Их
Хурлын хяналт
шалгалтын тухай
хуулийн 9.3-т заасны
дагуу;

хуулийн төслийн
талаарх саналыг
100 000 ба түүнээс
дээш тооны иргэн
дэмжсэн бол;

Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу хэлэлцэнэ.

САНАЛЫН ТОО ХҮРСЭН ТОХИОЛДОЛД



Байнгын хороо тухайн асуудлыг хэлэлцээд бодлогын баримт бичиг боловсруулах, хуулийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийг арилгах асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх, Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах, олон нийтийн хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зохион байгуулах, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах эсэх асуудлыг шийдвэрлэж, шаардлагатай гэж үзвэл санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Ерөнхий сайдын мэдээллийн сэдвийн талаар цахим хуудсанд байршуулж, тав хоногийн хугацаанд тухайн сэдвийн хүрээнд иргэдийг асуулт асуух боломжоор хангах асуудлыг хуульчиллаа.



2.15. ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА


<p>БАТАЛСАН ОГНОО</p> <p>2022.07.05</p>	<p>ХУУЛЬ САНААЧИЛСАН</p> <p>УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэгээс 2022.07.05, Засгийн газраас 2022.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн.</p>	<p>ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА</p> <p>Ердийн журмаар</p>
---	--	---

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ТӨРИЙН ТУСГАЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫГ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛТАЙ АДИЛТГАХ, ДҮЙЦҮҮЛЭХ ТАЛААР:

төрийн тусгай болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтыг Засгийн газрын саналыг үндэслэн төрийн албаны төв байгууллага батлах;

төрийн улс төрийн албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргааны албан тушаалын зохих ангилалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцож болох бөгөөд ийнхүү дүйцүүлэн тооцох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батлах.



ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ ШАЛГАЛТТАЙ ХОЛБООТОЙГООР:

- 01**

ерөнхий шалгалтыг төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй, тус хуульд заасан шаардлагыг хангасан иргэн, төрийн үйлчилгээний болон улс төрийн албан хаагчаас;
- 02**

тусгай шалгалтыг төрийн захиргааны албан тушаалын ангилал хооронд шилжих тохиолдолд болон тус хуулийн 27.1.3, 33.8-д заасан нөөцөд байгаа иргэдээс;
- 03**

хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж болох;
- 04**

ерөнхий шалгалтыг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулах.

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ӨӨР АЛБАН ТУШААЛД ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХТАЙ ХОЛБООТОЙГООР:

Төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулах хугацаа дуусахаас өмнө урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь буцаан ажиллуулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд анх илгээсэн төрийн байгууллагын саналыг авч, харилцан тохиролцсоны дагуу шийдвэрлэх

Төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллага түүнийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр дахин өөр төрийн байгууллагад үргэлжлүүлэн сэлгэн ажиллуулахгүй байх

Томилох эрх бүхий этгээд төрийн жинхэнэ албан хаагчид өөрт нь мэдэгдэн тухайн байгууллагын нэгж хооронд шилжүүлэн ажиллуулж болохоор тусгагдсан болно.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

ТЭРГҮҮН ТҮШМЭЛИЙН АНГИЛАЛД

тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 6-аас доошгүй жил ажилласан байх;

ЭРХЭЛСЭН ТҮШМЭЛИЙН АНГИЛАЛД

эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх;

АХЛАХ ТҮШМЭЛИЙН АНГИЛАЛД

ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.

ХУУЛЬД ТУСГАСАН ЗОХИЦУУЛАЛТ

Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсан тохиолдолд хамаарч байсан бол иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр тусгагдсан.

Төрийн албан дахь хөдөлмөрийн харилцаанд хориглох зүйлд улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа үйл ажиллагаанд дайчлах, чиг үүрэгт нь ул хамаарах ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглохоор тусгагдсан.



3. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

3.1. ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

(Ази, номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай)

БАТАЛСАН ОГНОО 2022.04.28	ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2022.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	---	--

Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээрийг 2016 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын 72 дугаар чуулганаар баталсан бөгөөд энэхүү хэлэлцээр нь олон улсын худалдааны хэлцлийг үр ашигтай, ил тод болгох, холбогдох хууль, дүрмийг сахих явдлыг сайжруулах үүднээс худалдаатай холбоотой цахим өгөгдөл, бичиг баримтыг харилцан хүлээн зөвшөөрч, солилцох нөхцөлийг бүрдүүлэх, хил дамнасан цаасгүй худалдааг дэмжих, үндэсний болон дэд бүс нутгийн нэг цонхны үйлчилгээ, бусад цаасгүй худалдааны системийн харилцаа холбоо, уялдааг хангахад чиглэсэн.

Монгол Улс Дэлхийн Худалдааны Байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг хэрэгжүүлбэл худалдааны зардлыг 10 орчим хувиар хэмнэх боломжтойгоос гадна хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх ерөнхий хэлэлцээртэй хамтатган хэрэгжүүлбэл зардлаа 30 орчим хувиар бууруулж, экспорт болон импортод зарцуулах хугацааг 55-60 хувиар багасгах боломжтой болно.

Манай улс энэхүү хэлэлцээрт нэгдэн орсноор экспорт, импортын бичиг баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, худалдааны горимоо хөнгөвчлөх, транзит тээврийн хугацааг богиносгох замаар худалдааны зардлыг бататгахын зэрэгцээ санхүүгийн хууль бус урсгал, татвараас зугтах, худал мэдүүлэх зэрэг явдлыг багасгаж, хил дамнасан цаасгүй гадаад худалдааг хөгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох ач холбогдолтой.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хууль нь нэг зүйлтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн болно.

3.2. ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА (Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн багийн ажлын тухай Европын хэлэлцээр)

<p>БАТАЛСАН ОГНОО</p> <p>2022.07.01</p>	<p>ХУУЛЬ САНААЧИЛСАН</p> <p>Засгийн газраас 2022.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн.</p>	<p>ДАГАН МӨРДӨХ ХУГАЦАА</p> <p>Ердийн журмаар</p>
---	---	---

Олон улсын тээвэрлэлтийн эрх зүйн орчныг сайжруулах, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, автотээврийн салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, үндэсний тээврийн сүлжээг олон улсын тээврийн сүлжээнд нэгтгэх үүднээс олон улсад мөрдөгдөж буй эрх зүйн хэм хэмжээг хүлээн зөвшөөрөх, өөрийн орны тээвэрчид, аж ахуйн нэгжийн эрх ашгийг хамгаалахын тулд олон улсын хэмжээнд даган мөрдөж буй гэрээ, хэлэлцээрт нэгдэн орж байна.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн талаар

- Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр нь:
 - олон улсын худалдааны хэлцлийг үр ашигтай, ил тод болгох;
 - холбогдох хууль, дүрмийг сахих явдлыг сайжруулах үүднээс худалдаатай холбоотой цахим өгөгдөл, бичиг баримтыг харилцан хүлээн зөвшөөрч, солилцох нөхцөлийг бүрдүүлэх,
 - хил дамнасан цаасгүй худалдааг дэмжих;
 - үндэсний болон дэд бүс нутгийн нэг цонхны үйлчилгээ, бусад цаасгүй худалдааны системийн харилцаа холбоо, уялдааг хангахад чиглэгдсэн байна.

Хууль батлагдсанаар:

- ❖ Монгол Улс Дэлхийн Худалдааны Байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг хэрэгжүүлбэл худалдааны зардлыг 10 орчим хувиар хэмнэх боломжтойгоос гадна хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх ерөнхий хэлэлцээртэй хамтатган хэрэгжүүлвэл зардлаа 30 орчим хувиар бууруулж, экспорт болон импортод зарцуулах хугацааг 55-60 хувиар багасгах боломжтой болно.
- ❖ Манай улс энэхүү хэлэлцээрт нэгдэн орсноор экспорт, импортын бичиг баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, худалдааны горимоо хөнгөвчлөх, транзит тээврийн хугацааг богиносгох замаар худалдааны зардлыг багасгахын зэрэгцээ санхүүгийн хууль бус урсгал, татвараас зугтах, худал мэдүүлэх зэрэг явдлыг багасгаж, хил дамнасан цаасгүй гадаад худалдааг хөгжүүлэх эрх зүйн орчинг бий болгох ач холбогдолтой.

3.3. КОНВЕНЦОД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

(Олон улсын хөдөлгөөнт хиймэл дагуулын байгууллагын 1976 оны конвенц)

<p>БАТАЛСАН ОГНОО</p> <p>2022.07.05</p>	<p>ХУУЛЬ САНААЧИЛСАН</p> <p>Засгийн газраас 2022.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн.</p>	<p>ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА</p> <p>Ердийн журмаар</p>
---	--	---

Манай улс Олон улсын далайн байгууллагын гишүүнээр 1996 онд элссэн бөгөөд Далайн хиймэл дагуулын олон улсын байгууллагын 1976 оны конвенц болон түүний 1981 оны протоколд 2011 онд нэгдэн орсон.

Энэхүү конвенцын гол зорилго нь хөдөлгөөнт хиймэл дагуулын тусламжтайгаар сансрын технологийг ашиглаж далайн тээврийн хөлөг онгоцны байршлыг хянах, осол, гамшгийн үед хүний аюулгүй байдлыг хангах, шаардлагатай тохиолдолд тэдэнд дэмжлэг үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх, тус байгууллагын зүгээс хөлөг онгоц, түүний багийн гишүүд, зорчигчидтой эргийн хяналтаас холбоо барих, мэдээлэл солилцох боломжийг сайжруулахад чиглэсэн.

Далайн хиймэл дагуулын олон улсын байгууллага нь 1994 оны Ассамблейн хурлаараа байгууллагынхаа нэрийг “Олон улсын хөдөлгөөнт хиймэл дагуулын байгууллага” гэж өөрчилжээ.



ХУУЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ:

Конвенцод оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталснаар Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэх, Олон улсын далайн байгууллагын аудитын зөвлөмжийг биелүүлэх, Монгол Улсын хөлөг онгоцонд бүртгэлтэй онгоцны аюулгүй байдлыг хангах, алсын зайнаас илрүүлэх, хянахтай холбогдсон харилцааг зохицуулах ач холбогдолтой юм.

4. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

4.1. “ХӨШИГИЙН ХӨНДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮС БАЙГУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

“ХӨШИГИЙН ХӨНДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮС БАЙГУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАЛААР

Төсөл санаачлагч “Чингис хаан” Олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг түшиглэн Хөшигийн хөндийд эдийн засгийн чөлөөт бүс байгуулснаар нүүдлийн соёлын үнэт зүйлсийг харуулсан аялал жуулчлал, төлбөрт таавар бусад бооцоот тоглоом, дагалдах үйлчилгээ, соёлын бүтээлч үйлдвэрлэл, худалдаа, олон улсын банк, санхүүгийн төв бүхий аялал жуулчлал, бизнес, эдийн засгийн төвтэй болох, шинжлэх ухаан, дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаанд суурилсан экспортын баримжаатай үйлдвэрлэл, инновацын бүс бий болгох, Ази-Европыг холбосон худалдаа тээврийг хөнгөвчлөх, хөрөнгө оруулалтыг дэмжсэн санхүү эдийн засгийн зангилаа “Транзит Монгол Улс” болох зорилгоор тогтоолын төслийг санаачилжээ.

“Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх “Чингис хаан” Олон улсын шинэ нисэх буудлыг түшиглэн “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс” байгуулах бөгөөд уг бүсийн газрын талбайн хэмжээг 1000 га-гаар тогтоож, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицлыг хавсралт ёсоор батлахаар тусгасан.

“Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсэд тогтвортой аялал жуулчлал, амралт зугаалгын рессорт, соёлын бүтээлч үйлдвэрлэл, олон улсын худалдааны төвүүд, байгалд ээлтэй үйлдвэрлэлийн бүсийг байгуулж, түүнчлэн Ази-Европыг холбосон олон улсын тээвэр, ложистикийн төвийг хөгжүүлснээр уул уурхайн салбарын хамаарлаас хараат бус, олон тулгуурт эдийн засагтай байх бодлогод нийцсэн нийгэм, эдийн засаг, хууль зүйн таатай үр дагавар бий болно.

4.2. “ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

(Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах үүрэг бүхий)

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нарын 20 гишүүнээс 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Хянан шалгах түр хороо байгуулах” тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Улсын Их Хурлын даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгээс Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах явцад тус банкны үйл ажиллагаанд хууль зөрчигдсөн, санхүүгийн чадавч доройтсон ноцтой нөхцөл байдлууд нь Монгол Улсын гадаад өрийн асуудлыг хүндрүүлэх, Монгол Улсын зээлжих зэрэглэл, Олон улс дахь нэр хүнд зэрэгт муугаар нөлөөлж болзошгүй асуудлууд үүсэх магадлалтай гэж үзэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц байдлыг шалгах Хянан шалгах түр хороог байгуулахаар тогтоолын төслийг санаачилжээ.

Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаараа “Хянан шалгах түр хороо байгуулах” тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу хэлэлцсэн.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн байдалд Улсын Их Хурлаас хяналт шалгалт хийх түр хороо байгуулах нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй гэж үзэж, дээрх тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Улсын Их Хурал 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, Монгол Улсын Хөгжлийн банкны асуудлаар Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог олонхыг төлөөлөн Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Э.Батшугар, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаатар, Ц.Мөнхцэцэг, Ж.Сүхбаатар, Б.Энхбаяр, цөөнхийг төлөөлөн Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал, Т.Доржханд нарын бүрэлдэхүүнтэйгээр байгууллаа.

4.3. “ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХУВЬЦААГ 2022-2023 ОНД БИРЖЭЭР ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХУДАЛДАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ирээдүй өв сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Монгол Улсын Засгийн газар Улсын Их Хурлаас баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд төр бизнесийн үйл ажиллагааны удирдлагад хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх байдлыг хязгаарлаж, бизнесийн шийдвэр нь улс төрийн нөлөөллөөс ангид байх, төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, нээлттэй хувьцаат компани болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх юм.

Эрчим хүчний тухай хуульд эрчим хүч дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна гэж заасны дагуу Эрчим хүчний чиглэлийн 11 төрийн өмчит хуулийн этгээдийг үндсэн чиглэлийн жагсаалтаас хасаж, нийт 25 төрийн өмчит хуулийн этгээдийн 34 хүртэлх хувийн хувьцааг биржээр олон нийтэд худалдах, түүнчлэн Төрийн өмчит банкны нийт хувьцааны 20 хүртэлх хувийг нээлттэй худалдахаар Улсын Их Хурлын тогтоолд заасан.

Уг тогтоол батлагдсанаар төрийн өмчит компаниудын санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах, олон нийтийн хяналтад оруулах, үйл ажиллагааны тогтвортой байдал, ил тод байдлыг хангах, төрийн оролцоог бууруулах ач холбогдолтой.

4.4. “ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ирээдүй өв сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт “Хүүхдийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Тогтоол батлагдсанаар 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн Улаанбаатар хотын цэцэрлэгийн хүртээмж багатай, төрийн өмчийн цэцэрлэгт нэмэлт элсэлт авах боломжгүй байршилд төрийн бус өмчийн цэцэрлэг байгуулан ажиллуулж тухайн хамран сургах тойргийн хүүхдийг элсүүлсэн тохиолдолд хувьсах зардлыг 2 дахин нэмэгдүүлж, хүүхдийн хоолны зардлын хамт санхүүжүүлэх, хувийн хэвшил дэргэдээ цэцэрлэг байгуулах санаачилгыг дэмжихийг Засгийн газарт үүрэг болгосон.

Уг тогтоол батлагдсанаар Улаанбаатар хотод хүүхдийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн бус өмчийн цэцэрлэгийг дэмжих, хүүхэд хамран сургах тойрогтоо цэцэрлэгт хамрагдах боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

4.5. “НООС, НООЛУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурал “Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар баталлаа.

Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгалаа.

1

Ноос, ноолуурын боловсруулалтын түвшнийг үе шаттайгаар нэмэгдүүлэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, 2023 оноос хялгас ялгахаас дээш боловсруулалт хийсэн чанар, стандартын шаардлага хангасан ноолуурыг үйлдвэрлэх болон экспортлохтой холбоотойгоор үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг баталж, мөрдүүлэх;

2

Хялгас ялгахаас дээш боловсруулалт хийх зориулалттай үйлдвэрийн тоног төхөөрөмжийг импортоор оруулахад нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3

Хялгас ялгасан ноос, ноолуур, хөөвөр, зэрмэл утас болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор бага хүүтэй, урт хугацаат, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг олгоход шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг жил бүр бүрдүүлэх;

4

Малчин, мал бүхий этгээдийн бэлтгэж боловсруулах үйлдвэрт тушаасан сарлагийн хөөвөр, торомны ноосны чанараас хамааруулан мөнгөн урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5

Байгаль орчинд ээлтэй, тогтвортой бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор бүтээгдэхүүнийг баталгаажуулах хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн хүрээг өргөтгөн олон улсын түвшинд хүргэх, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацыг хөгжүүлэх, ноос, ноолууран бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

ТОГТООЛЫН БИЕЛЭЛТЭД ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО ХЯНАЛТ ТАВИН АЖИЛЛАНА.

4.6. “ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

(Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсад эмийн хяналт шалгалтыг сайжруулах, хянан шалгах үүрэг бүхий)

Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Ц.Анандбазар, Э.Бат-Амгалан, Ж.Батжаргал, Э.Батшугар, Б.Баярсайхан, Б.Бейсен, С.Бямбацогт, Г.Дамдинням, Ц.Идэрбат, Ж.Мөнхбат, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Д.Өнөрболор, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Ц.Цэрэнпунцаг, С.Чинзориг, Л.Энх-Амгалан нараас 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Хүний эмийн чанарын асуудлаарх хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг Улсын Их Хурал 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн баталлаа.

Хянан шалгах түр хороог Улсын Их Хурал дахь олонхыг төлөөлөн П.Анужин, Д.Батлут, Э.Батшугар, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Н.Учрал, Ж.Чинбүрэн нар, цөөнхийг төлөөлөн Б.Бейсен, С.Ганбаатар, Т.Доржханд, С.Одонтуяа, Ц.Туваан нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулав.

Тус Хянан шалгах түр хороог 2014-2018 оны хооронд хэрэгжүүлсэн “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн үр дүнг үндэслэн байгуулсан. Тус тайланд Монгол Улсад 44 аж ахуйн нэгж эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх 63 тусгай зөвшөөрөлтэйгөөс 84.1 хувь нь эм үйлдвэрлэлийн зохистой дадал GMP-ын шаардлагыг хангаагүй, түүнчлэн зах зээлд хийгдэж буй урьдчилан сэргийлэх хяналтаар 2014 онд 49 нэрийн, 2015 онд 130 нэрийн, 2016 онд 519 нэрийн эм Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, бүртгэлийн загвараас зөрүүтэй эм илэрчээ. Мөн дотоодод үйлдвэрлэж буй эмийн 18.6 хувь, импортын эмийн 6.1 хувь нь стандартын шаардлага хангаагүй болох нь тогтоогджээ.

Түүнчлэн Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгодог эмийн 10 хувь нь чанаргүй байх эрсдэлтэй бөгөөд зах зээлд байгаа эмийн 14 хувь нь стандартын бус, 19 хувь нь бүртгэлгүй эм байна гэж дүгнэжээ. Мөн дотоодын зах зээлд байгаа эм нь өндөр хөгжилтэй орны зах зээлд байгаа эмтэй орц, найрлагын хувьд ижил боловч үйлчлэлийн хувьд харилцан адилгүй нөлөөтэй байна гэсэн дүгнэлт гарсан.

Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаар нь 2019 оноос 2022 оны 3 дугаар сарыг дуусталх хугацааг хамрах бөгөөд хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлттэй холбоотой тодорхой асуудлыг шалгаж, улмаар Монгол Улсад эмийн хяналт шалгалтыг сайжруулах, эсхүл хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох талаарх саналыг Улсын Их Хуралд танилцуулахаар тогтоосон.

Тус Хянан шалгах түр хороог Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу зургаан сарын хугацаатай байгууллаа.

4.7. “МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр эцэслэн баталлаа.

“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол нь 4 заалт, 1 хавсралтаас бүрдэх бөгөөд Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг хавсралтаар баталж, Монгол Улсын Засгийн газарт дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасан. Үүнд:

- Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах талаар төлөвлөгөөнд тусгасан улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах, төр, хувийн хэвшлийн түншлэл болон зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээнд шаардагдах бэлтгэл хангаж ажиллах;
- Цаашид улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ хөгжлийн бодлогын тэргүүлэх салбар, чиглэлийг тодорхойлж, хөгжлийн төсөл, арга хэмжээг эрэмбэлэн тусгах, тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт бүрийн хэрэгжилтийг үнэлэх боломжтойгоор боловсруулах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл боловсруулах, түүнд санал ирүүлэх, хэрэгжилтийг үнэлэх талаар салбар, орон нутгийн хэмжээнд холбогдох байгууллага, албан тушаалтныг нэгдсэн арга зүй, удирдамжаар хангаж ажиллах.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжих төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх хуулийн шаардлагад нийцүүлэн баталлаа.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд Хүний хөгжлийн бодлого, Эдийн засгийн бодлого, Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого, Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ногоон хөгжлийн бодлого, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого гэсэн 5 бүлгийн 18 зорилгын хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх 75 төсөл, арга хэмжээ, түүнд хамаарах 201 шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, 2023 онд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр, үндсэн болон хамтран хариуцагч байгууллагыг тусгав.

4.8. “ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

(Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох үүрэг бүхий)

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяшаа нарын 25 гишүүнээс 2022 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Хянан шалгах түр хороо байгуулах” тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Монгол Улс 2022 онд 18.0 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөснөөс 2022 оны эхний дөрвөн сарын байдлаар 3.8 сая тонн нүүрс экспортолж, нүүрсний экспортоос улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн 1.3 их наяд төгрөгийн орлого тасалдах нөхцөл байдал үүссэнийг, түүнчлэн Монгол Улсын хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн зардал хэт өссөн, үүнтэй холбогдон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг тогтоох шаардлагыг тус тус үндэслэн Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо байгуулахаар төсөл санаачлагчид уг тогтоолын төслийг өргөн мэдүүлжээ.

Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулсан.

Улсын Их Хурал 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог олонхыг төлөөлөн Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазар, Б.Баттөмөр, Г.Ганболд, Л.Мөнхбаатар, Г.Мөнхцэцэг, Н.Наранбаатар, Т.Энхтүвшин, цөөнхийг төлөөлөн Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяшаа, Б.Бейсен, С.Ганбаатар, Н.Ганибал, Т.Доржханд нарын бүрэлдэхүүнтэйгээр байгууллаа.

Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг “Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох”-оор тогтоосон.

Улсын Их Хурлаас хугацааг сунгахаас бусад тохиолдолд Хянан шалгах түр хороо нь энэ тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын дотор тусгай шалгалт явуулж, тайланг санал, дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд танилцуулахаар тусгав.

4.9. “МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЭСЭХ АСУУДЛААР АРД ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар Т.Доржханд тэргүүтэй 100 000 иргэд саналаа, улс төрийн намууд “Тунхаг бичиг”-ээ, түүнчлэн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг иргэдийн санал болон “Тунхаг бичиг”-т үндэслэсэн шийдвэрээ тус тус Улсын Их Хуралд ирүүлсэн билээ.

Дээрх санал, шийдвэрийн дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооны Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах, олон нийтийн санаа бодлыг судлах сэдвийн хүрээг тодорхойлох, хэлэлцүүлгийн хугацааг тогтоох тухай Ажлын хэсгийг Улсын Их Хурлын 2022 оны 13 дугаар тогтоолоор байгуулсан.

Тус ажлын хэсэг 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр хуралдаж “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан бөгөөд Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар уг тогтоолыг хэлэлцэн батлав.

Улсын Их Хурлын тогтоолд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах ажлыг улсын хэмжээнд 2022 оны 06 дугаар сарын 18-наас 26-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулж, дүнг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулахаар тусгав.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд тэргүүтэй 100 000 иргэдийн санал, улс төрийн намуудын “Тунхаг бичиг” болон Монгол Ардын Намын бүлгийн шийдвэрийг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаарх ард нийтийн саналыг судлах зорилгоор 4 бүлгийн хүрээнд 11 сэдвийг тодорхойлж, тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталлаа.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Улсын Их Хуралд суудалтай нам, эвслийн бүлгийн гишүүдээс бүрдүүлж, тогтоолын 2 дугаар хавсралтаар батлав.

4.10. “ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр баталлаа.

Тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд хавсралтад заасан 114 арга хэмжээг 2022-2026 онд 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр тусгалаа. Тогтоолын хавсралтад шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшин, нийт санхүүжилтийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр, 2022-2026 оны санхүүжилтийн хуваарь, хамтран хэрэгжүүлэх байгууллага, хэрэгжих хугацааг хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрээр тусган батлав.

Тогтоолыг хэрэгжүүлснээр дотоодод үйлдвэрлэх хүнсний бүтээгдэхүүний нэр, төрөл нэмэгдэж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээс хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулж, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.



4.11. “ТӨРИЙН ОРДНЫ НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ, ЗААГИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, ЗАРИМ ОРЧНЫГ ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ БОЛГОХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Д.Цогтбаатар нараас өргөн мэдүүлсэн “Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг шинэчлэн тогтоож, зарим орчныг олон нийтэд нээлттэй болгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн баталлаа.

Дээрх тогтоол батлагдсанаас хойших 20 жилийн хугацаанд Төрийн ордны урд талын өргөтгөл баригдсан, ойр орчмын авто болон явган хүний зам шинэчлэгдсэн, Төрийн ордны арын цэцэрлэгт хүрээлэнг иргэдэд нээлттэй болгох шаардлага үүссэн зэргийг харгалзан энэхүү тогтоолыг шинэчлэн батлах шаардлага үүссэн.

Төрийн ордны урд байрлах Чингис хааны хөшөө, Төрийн ордны хойно байрлах цэцэрлэгт хүрээлэнг олон нийтэд нээлттэй болгох, цэцэрлэгт хүрээлэнг төрийн тусгай хамгаалалтын хамаарах бүсээс гаргах зэрэг асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, түүнчлэн Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор аюулгүй байдал, хамгаалалтын асуудлыг зохион байгуулах, хэв журмыг сахиулах, иргэдийн амгалан тайван байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, цэвэрлэгээ, арчилгаа, тохижилтыг хариуцах асуудлыг холбогдох журмаар зохицуулахыг Засгийн газарт даалгалаа.

1

Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг Төрийн ордны баруун, зүүн, урд, хойд хашаагаар хязгаарлан шинэчлэн тогтоов.

2

Төрийн ордны хойд талын цэцэрлэгт хүрээлэнг Төрийн ордны нутаг дэвсгэрээс хасаж, иргэдэд нээлттэй болгов.

3

УИХ-ын үйл ажиллагаатай танилцах, гишүүдтэй уулзахаар ирсэн иргэдийг Төрийн ордонд нэвтрэхэд энгийн хувцаслалттай байх боломж нөхцөлийг бүрдүүлэв.



4.12.МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН БОЛОН “МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу хэлэлцсэн.

Улсын Их Хурал 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа “Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэн баталлаа.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд 33 төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэл, сум, дүүргийн 4,674 төсөвт байгууллага болон Ирээдүйн өв сан, төсвийн Тогтворжуулалтын сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийг нэгтгэлээ.

Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланд татварын зарлагын тайлан, худалдан авсан ажил, үйлчилгээний тайлан, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүнгийн танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл зэргийг хамруулсан болно.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдал 2021 онд хүнд хэвээр үргэлжилсэн хэдий ч бэлэн байдлын зэргийг үе шаттай бууруулж, Монгол Улсын Засгийн газрын зүгээс иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах чиглэлээр бодлогын арга хэмжээ авч, “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-г батлан, хэрэгжүүлсний үр дүнд эдийн засгийн өсөлт 2020 оноос зургаан нэгж пунктээр өсөж 1.4 хувьд хүрсэн байна.

Дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ, эрэлт нэмэгдэж, манай улсын уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн экспорт 2021 оны эхэнд нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж байсан бол оны сүүлд цар тахлын улмаас хилийн боомтуудын үйл ажиллагаа доголдож, түүхий эдийн экспорт огцом буурч эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн төдийгүй, уул уурхайн салбарын өсөлт эхний улиралд 39.3 хувь байсан бол оны эцэст 1.7 хувь болж саарсан байна.

Зэсийн баяжмалын үйлдвэрлэл өмнөх оноос 4.0 хувиар 1.3 сая тонн, газрын тосны үйлдвэрлэл 13.7 хувиар өсөж 4.7 сая баррельд хүрсэн нь уул уурхайн салбарын өсөлтийг дэмжиж улмаар төсвийн орлогын гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тухайд: Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн орлогын гүйцэтгэл 12.7 их наяд төгрөгт хүрч, төлөвлөснөөс 478.6 тэрбум төгрөгөөр давж биелсэн, нэгдсэн төсвийн зарлага 15.6 их наяд төгрөгт хүрч, төлөвлөснөөс

573.7 тэрбум төгрөгөөр бага байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2.9 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, дотоодын нийт бүтээгдэхүүний 6.8 хувьтай тэнцэж байна.

Улсын төсвийн гүйцэтгэлийн хувьд: Монгол Улсын 2021 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 9.1 их наяд төгрөгт хүрч, төлөвлөснөөс 38.6 тэрбум төгрөгөөр дутуу, улсын төсвийн зарлага 12.2 их наяд төгрөг болж, төлөвлөснөөс 407.9 тэрбум төгрөгөөр бага байна. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 3.1 их наяд төгрөгийн алдагдалтай байлаа.

“Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолоор Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 6,829,026.3 сая (зургаан их наяд найман зуун хорин есөн тэрбум хорин зургаан сая гурван зуун мянга) төгрөгөөр, Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэлийн зарлагын (тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн) хэмжээг 10,735,610.8 сая (арван их наяд долоон зуун гучин таван тэрбум зургаан зуун арван сая найман зуун мянга) төгрөгөөр тус тус баталлаа.

**4.13. “ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**
(Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй
байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг
дэмжих асуудлаарх холбогдох хууль тогтоомжийн
хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг
нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий)

*Улсын Их Хурал “Түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг
хэлэлцэж, 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар баталлаа.*

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 22 гишүүнээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг үндэслэн 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаарх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороог байгуулахаар тусгасан бөгөөд тус түр хороо нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжиж, хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах зэрэг асуудлаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, дүнг хуульд заасны дагуу танилцуулах чиг үүрэгтэй ажиллана.

Түр хороо нь нийт 18 гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, С.Ганбаатар, Г.Ганболд, Н.Ганибал, Л.Мөнхбаатар, Н.Наранбаатар, М.Оюунчимэг, Д.Өнөрболор, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Ч.Ундрэм, С.Чинзориг, Т.Энхтүвшин нар ажиллах болно. Уг тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

4.14. “МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 21 ДЭХ ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 21 дэх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн баталлаа.

Уг тогтоолоор дараах асуудлын хүрээнд холбогдох арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан болно. Үүнд:

1) (КОВИД-19)-ын цар тахлаас шалтгаалан хүний амь нас хохирсон, иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, дархлаажуулах үед гарсан хүндрэл, хорио цээр болон хязгаарлалтын дэглэмийн үед гарсан хүний эрхийн зөрчилд дүгнэлт хийн гамшиг, ослын үед хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг тооцох, хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолоор баталсан “Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах хойшлуулашгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө”-г Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг авч шинэчлэн батлах, цар тахлын үеийн хязгаарлалтын дэглэмээс үүдэлтэй сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгах арга хэмжээг үр дүнтэй, шуурхай зохион байгуулах;

2) Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хүрээнд ажлын байран дахь бэлгийн болон бусад хэлбэрийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох, жендэрийн эрх тэгш байдлын талаар олон нийтийг соён гэгээрүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх, сахилга хариуцлагыг сайжруулах, эрх зүйн соёлыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлж, судалгаанд суурилсан, төлөвлөлт, төсөвтэй уялдуулсан үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх;

3) Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй бүх хэлбэрийг устгах бодлого, үнэлэх шалгуур үзүүлэлт болон хэрэгжилтийг хянах тогтолцоог бий болгох, хуульд зөвшөөрснөөс бусад аливаа хэлбэрээр хүүхдийг хөдөлмөрлүүлэхэд чиглэсэн үйлдэл, эс үйлдэхгүйг гаргасан ажил олгогч, уралдаанч хүүхдийг сургуулиас завсардуулсан уяач, эцэг, эх, асран хамгаалагчдад хуулийн хариуцлага хүлээлгэх, өвлийн улиралд хурдан морины үсэргээ, сунгаа зохион байгуулж хүүхдээр хурдан морь унуулахыг хориглох, хянах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, хурдан морины уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, хэрэглэлийн стандартыг өөрчилж, хувцас, хэрэглэл нь уралдаанч хүүхдийг бүрэн хамгаалж байх нөхцөлийг бүрдүүлэх;

4) Цэргийн албанд хүний амь нас, эрүүл мэнд хохирч байгаа шалтгаан, нөхцөлд дүгнэлт хийж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цэргийн дүрмийн бус харьцааг илрүүлэх, бүртгэх, таслан зогсоох арга хэмжээ авах, Цэргийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх, хүний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бусаар харьцахыг хориглосон зохицуулалтыг тусгах;

5) Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хамгаалах чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах салбар дундын ажлын уялдаа холбоог сайжруулж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хохирогч хамгааллын бүтэц, тогтолцоо, байгууллагуудын чиг үүргийн давхардлыг арилгаж, уялдаа холбоог хангах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх;

6) Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвгүй хороо, суурин газарт стандартын шаардлага хангасан өрхийн эрүүл мэндийн төв байгуулах, өргөжүүлэх ажлыг эрчимжүүлэх, нийгмийн сүлжээний хяналтгүй хэрэглээнээс шалтгаалан цахим гадуурхалтад өртөх, хүүхэд дэлгэцийн хамааралтай болох, цахим гэмт хэргийн хохирогч болох, нас, сэтгэхүйн онцлогт үл тохирох, зүй бус агуулгатай контент үзэх, зан суртахуунд нь сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээ авах, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, санхүүжилтийг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгохыг даалгалаа.

Монгол Улсын Засгийн газар Улсын Их Хурлын 2021 оны 67 дугаар тогтоол болон энэ тогтоолын хэрэгжилтийг Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар болов.

4.15. “МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулсан “Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас 118, Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгээс 58, Байнгын хороодоос 69, Улсын Их Хурлын гишүүнээс найман хууль, тогтоолын төслийн санал ирүүлсэн.

Тогтоолд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар тогтоолд туссан хуулийн төслүүд, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолд 2022 болон 2023 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгагдсан хууль,

тогтоолын төслүүд, “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх болон 2022 онд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх хуулийн төслүүд, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолд 2022 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан хууль, тогтоолын төслүүдийг тусгах зарчим баримтлан 64 хууль, Улсын Их Хурлын тогтоолыг Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөв.

Хэлэлцүүлгийн шатанд байгаа болон хууль санаачлах эрх бүхий субъектүүдээс өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дараалалд оруулах асуудлыг Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга шийдвэрлэхээр уг тогтоолд тусгалаа.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫГ ХААЖ УИХ-ЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАРЫН ХЭЛСЭН ҮГ



Улсын Их Хурлын Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулган хуулийн дагуу ажлын 80 хоног хуралдаж, бие даасан 16, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 314, хууль хүчингүй болсонд тооцох тухай найм, олон улсын гэрээ, хэлэлцээр соёрхон батлах тухай гурав, нийт 341 хууль, 44 тогтоол баталснаар ийнхүү өндөрлөж байна.

Хаврын чуулган дэлхий нийтийг хамарсан халдварт цар тахлын нөлөөгөөр тээвэр логистик, нийлүүлэлтийн сүлжээ тасалдсан, хөрш орнуудын хил гааль тодорхой хугацаанд хязгаарлагдсан, олон улсад геополитикийн хурцадмал байдал үүссэн хүндрэл бэрхшээлтэй цаг үед хуралдлаа. Дээрх шалтгаануудын улмаас улсын эдийн засаг агшиж, үнийн өсөлт иргэдийн худалдан авах чадвар, амьжиргаанд сөргөөр нөлөөлж, ядуурал, тэгш бус байдал даамжрах нөхцөлийг бий болгож байна.

Инфляц 2021 оны эхний хагасаас хойших нэг жилийн дотор 2.4 дахин, улсын хэмжээнд 15.1 хувьд, Улаанбаатар хотод 16.2 хувьд хүрч өссөн. Энэ бол сүүлийн 10 жилд гараагүй өндөр өсөлт юм. Улсын хэмжээнд хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт 18 хувьд хүрсэн байна.

Тиймээс өнгөрсөн 4 дүгээр сард Улсын Их Хурлаас үнийн өсөлтийг хязгаарлах чиглэлээр хууль баталсан. Инфляцыг бууруулах, үнийн өсөлтийн иргэдэд ирэх дарамтыг бууруулах чиглэлээр Улсын Их Хурлаас Эдийн

засгийн байнгын хорооны дарга Жамбалын Ганбаатараар ахлуулсан ажлын хэсгийг саяхан байгууллаа. Ажлын хэсэг хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эрчимжүүлэх, иргэдийн амьжиргаа, орлого, худалдан авах чадвар, хөдөлмөр эрхлэлтийг эрсдэлээс хамгаалах бодлого, шийдвэрийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Засгийн газарт үүрэг чиглэл өгөх чиглэлээр ажиллах болно.

Хямралт байдлаас яаж хурдан, ямар оновчтой арга замаар гарах вэ гэдэгт төр, засгийн байгууллагууд, үүрэг хүлээсэн албан тушаалтнууд арга ухаанаа сүвэгчилж, эдийн засгаа өсгөх, үйлдвэрлэгчдээ дэмжих, хөрөнгө оруулалтын гадаад, дотоод орчныг сайжруулах цэгцтэй бодлого дэвшүүлж, мэдэгдэхүйц үр дүнд хүргэх нь нэн чухал боллоо.

Иймээс Улсын Их Хурал үнийн өсөлтийн болон бусад эрсдэлээс улсын эдийн засаг, иргэдийн амьжиргааг хамгаалах асуудалд завсарлагааны хугацаа буюу энэ зуны турш тууштай анхаарч ажиллах болно. Уул уурхайн зарим орд газруудаа яаралтай эргэлтэд оруулж, Үндэсний баялгийн сангийн тухай хуулиа хэлэлцэж, үр өгөөжийг ард иргэддээ хүртээмжтэй болгох Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрэгжүүлэх хэрэгтэй. Иргэдийн орлогыг нэмэгдүүлэх тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллах шаардлагатай. Бидэнд амрах, аялах цаг зав байхааргүй онцгой үе тохиож байгааг ард иргэдээсээ эхлээд Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд ойлгон ухамсарлана гэдэгт итгэж байна. Ажлын хэсгүүдээс холбогдох хууль, тогтоолын төсөл боловсруулж, шийдэл олсон шаардлагатай тохиолдолд ээлжит бус чуулган зарлан хуралдуулах ч боломжтой.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Улсын Их Хурал баталсан. Энэ хуулиар төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагууд санхүүгийн сахилга батыг чанд сахих асуудлыг тусгайлан журамлаж, хангамж үйлчилгээ, хөрөнгө оруулалт, бараа, үйлчилгээний худалдан авалтад хориглох зүйлсийг тодорхойлсон. Мөн үрэлгэн байдлыг хязгаарлах, бүх шатанд хэмнэлтийн горимыг мөрдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн. Энэ хуулийн заалт нэг бүрийг ягштал хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, хэрвээ хэрэгжүүлээгүй бол хариуцлага хүлээлгэж, ил тод мэдээлэх ёстой.

Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд мах, гурил, газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлт, хангамж, нийлүүлэлтийн хомстол үүсгэхгүй байх үүднээс Засгийн газраас цогц төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэхээр заасан. Хуулийн хэрэгжилт хэр үр дүнд хүрч байгааг шалган дүгнэж, намрын чуулганд танилцуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Улсын Их Хурал импортоор оруулж ирэх элсэн чихэр, ёотон, ургамлын тос, цагаан будааг гаалийн татвараас чөлөөлж, эх орны үйлдвэрийн түүхий эдээр үйлдвэрлэсэн ургамлын тос, дотоодын хүнсний үйлдвэрт борлуулсан тосны ургамлыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөллөө.

Хүн амаа цэвэр, аюулгүй хүнсээр хүртээмжтэй хангах нь манай улсын үндэсний аюулгүй байдлын нэг гол баталгаа мөн. Тиймээс Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах тухай” тогтоолыг Улсын Их Хурал хэлэлцэж баталсан. Энэ тогтоолыг бүрэн хэрэгжүүлж чадвал хүнс үйлдвэрлэгчдээ урт хугацаатай хөнгөлөлттэй зээлээр дэмжиж, мэргэжлийн чадварлаг хүний нөөцтэй болж, мал амьтны халдварт болон гоц халдварт өвчнөөс ангижирч, ирэх таван жилд хүнсний гол нэрийн 19 төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, хүнс экспортлогч орон болох зорилт хангагдана.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг орон даяар өрнүүлэх Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилгыг холбогдох бүх байгууллагууд, ард нийтээрээ бүрэн дэмжиж, идэвхтэй, санаачилгатай ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Иймээс Улсын Их Хурлаас хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Жадамбын Бат-Эрдэнэ гишүүнээр ахлуулсан түр хороог байгууллаа. Түр хороо зуны хугацаанд хүнсний үйлдвэрлэлээ дэмжих, намрын ургац хураалтын бэлтгэл хангах, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах тухай” тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлд онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна.

Эрхэм гишүүд ээ,

2022 оны хаврын ээлжит чуулган Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаа шинэ шатанд гарсан чуулган боллоо. Чуулганы хугацаанд Хянан шалгах түр хороо гурав, Хяналт шалгалтын дөрвөн ажлын хэсэг байгуулагдсан. Нийтдээ дөрвөн түр хороо, 19 ажлын хэсэг ажиллаж байна. Хөгжлийн банкны хэрэг, эмийн чанар, хуурамч болон стандартын бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлт, хилийн боомтууд, чөлөөт бүсийн үйл ажиллагаа зэрэг улс орон, ард иргэдийн нийтлэг эрх ашгийг хөндсөн асуудлуудаар байгуулагдсан түр хороодын ажлын үр дүнг Улсын Их Хурал намрын чуулганаараа хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргах болно. Мөн Монгол Улсын Хөгжлийн банкны тухай, Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулиудын хэрэгжилт, хүний эрх, эрх чөлөөг хангах, барилгын дотор орчны агаарын чанар зэрэг асуудлаар нийтийн сонсгол зохион байгууллаа. Нийт 18 бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхээр шийдвэрлэснээс 13-ыг нь бүрэн хэрэгжүүлж, холбогдох Байнгын хороо, албан тушаалтнуудад хүргүүлээд байна.

Түүнчлэн иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд учирч буй хүнд суртал, саад бэрхшээлийг багасгахад энэ удаагийн чуулган анхаарлаа хандуулсан. Энэ хүрээнд Зөвшөөрлийн тухай хуулийг шинэчлэн найруулж, Тендерийн хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулж, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталлаа.

Төрөөс аливаа зөвшөөрөл олгох үйл ажиллагааг ил тод болгож, цахимаар зохион байгуулах, хэн нэгэн албан тушаалтан дураараа зөвшөөрөл

бий болгох болон зөвшөөрлийн тоо, төрлийг нэмэгдүүлэхийг хориглох заалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан. Энэхүү хуулиар төрөөс олгодог зөвшөөрлийн тоог тав дахин буурууллаа.

Эдгээр эрх зүйн шинэ орчин нь хүнд суртал, зардал чирэгдлийг мэдэгдэхүйц багасгаж, цаашлаад авлига, албан тушаалын гэмт хэрэг буурах, манай улсын авлигын индекс болон эдийн засгийн голлох үзүүлэлтүүд сайжирна гэдэгт итгэж байна.

Эрхэм нөхөд өө,

Монголчууд бид Ардын хувьсгалын 100, 101 жилийн түүхт ойгоо тэмдэглэх гэж байна. Цар тахлын улмаас монгол түмэн наадмаа үндсэндээ гурван жил тэмдэглэж чадаагүй. Тиймээс ард олноороо сэтгэл тэнэгэр, өргөн дэлгэр, шударга, сайхан наадах таатай нөхцөлийг бүрдүүлэх талаар Баяр наадмын комисс онцгой анхаарах нь чухал байна.

Улсын Их Хурал Үндэсний баяр наадмын тухай хуулийг шинэчлэн найруулж баталсан. Үүгээр үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдааны маргаантай асуудлуудыг хуулийн хүрээнд цэгцэлсэн гэж үзэж байна.

Улсын Их Хурлын Эрхэм гишүүд Та бүхэнд болон Монголынхоо нийт ард түмэнд, дэлхий даяар тархан суугаа монголчууддаа Ардын хувьсгалын 100, 101 жил, Үндэсний их баяр наадмын мэндчилгээ дэвшүүлье.

Хотол түмнээрээ сайхан наадаарай.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулган өндөрлөснийг мэдэгдье.



УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы хаалтын үйл ажиллагаа.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АБГББХ	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо
БЗД	Баянзүрх дүүрэг
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал, жуулчлалын яам
БОХХААБХ	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо
БСШУСБХ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо
БХАХХ	Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтэс
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГТБЦГ	Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар
ДНБ	дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕАБХАБ	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага
ЁЗСХБХ	Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо
ЖАЙКА	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
ЖДҮДХ	Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хороо
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ИЦББХ	Инновац, цахим бодлогын байнгын хороо
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НББХ	Нийгмийн бодлогын байнгын хороо
НУДХ	Нутгийн удирдлагын дэд хороо
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СБД	Сүхбаатар дүүрэг
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЯ	Сангийн яам
ТББ	төрийн бус байгууллага
ТББХ	Төрийн байгуулалтын байнгын хороо
ТБХ	Төсвийн байнгын хороо

ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТЗХДХ	Төсвийн зарлагын хяналтын дэд хороо
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	төрийн өмчит хувьцаат компани
ТХЗДХ	Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо
ТХШХ	Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
УИХГХБДХ	Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо
УОК	Улсын онцгой комисс
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮББХ	Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХК	хувьцаат компани
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХУД	Хан-Уул дүүрэг
ХҮХДХ	Хөнгөн үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо
ХҮХДХ	Хүнд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШҮГ	Хяналт шалгалт, үнэлгээний газар
ХШХ	Хяналт шалгалтын хэлтэс
ХЭЗГ	Хууль, эрх зүйн газар
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН
ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААНЫ ТАНИЛЦУУЛГА

Редактор: Б.Эрдэнэбаяр

Эмхэтгэсэн: Ц.Оюун

Гэрэл зургийг: Г.Эрдэнэтуяа
Г.Аргуужин

Эх бэлтгэсэн: Г.Баатар

Улсын Их Хурлын Тамгын газраас
2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр эрхлэн гаргав.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх, олшруулах цехэд 1350 хувь хэвлэв.



ТӨРИЙН ОРДНЫ ЦАХИМ АЯЛАЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



forum.parliament.mn



<http://tour.parliament.mn/>
Цахим хаягаар Төрийн ордонтой танилцах боломжтой.